

**“МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛЛИЙН
БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”
ТӨСЛИЙН СУРГАЛТ, ЧАДАВХЖУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



Монгол Улсын Их Хурлын
Тамгын Газар



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC



Empowered lives.
Resilient nations.

“МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН СУРГАЛТ, ЧАДАВХЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Захиалагч: Монгол Улсын Их Хурлын Тамгын газар
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр

Гүйцэтгэгч: “Түгээмэл эрх хөгжил” ТББ

2020 он

“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь”
төслийн сургалт, чадавхжуулах үйл ажиллагааны
үр нөлөөний судалгааны тайлан

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” /2017-2020/ төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, чадавхжуулах үйл ажиллагааны үр нөлөөний судалгааг 2019 оны 11 дүгээр сараас 2020 оны 1 сард хийж гүйцэтгэв.

Улаанбаатар хот

2020 он

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА	ii
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	iii
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	iv
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	vii
УДИРТГАЛ	viii
1. Үнэлсэн үйл ажиллагаа тус бүрийн үр нөлөөний үнэлгээ	1
1.1 Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын үр нөлөө	1
1.2 ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө	17
1.3 Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө	33
1.4 Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын үр нөлөө	48
1.5 ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн үр нөлөө	60
1.6 УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх ажлын үр нөлөө	70
2. Судалгааны нэгдсэн дүгнэлт	84
3. Судалгааны зөвлөмжүүд	90
4. Хавсралт	92
4.1 Судалгааны тухай ерөнхий мэдээлэл	93
4.2 Судалгаанд ашигласан анкетын асуулгын загвар	104
4.3 Судалгаанд ашигласан ярилцлагын судалгааны чиглүүлэх асуултууд	113
4.4 УИХТГ-ын албан хаагчдаас авсан ярилцлагын чиглүүлэх асуултууд болон анкетын судалгааны загвар	115

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сургалтад хамрагдсан аймаг, сумдын хуваарь	2
Хүснэгт 2. Сургалтад хамрагдсан нийслэл, дүүргүүдийн хуваарь.....	3
Хүснэгт 3. ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтын ерөнхий үнэлгээ	14
Хүснэгт 4. ИТХ-ын Тэргүүлэгчдийн манлайллын сургалт зохион байгуулсан хугацаа, оролцогчид /орон нутгаар/	18
Хүснэгт 5. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын ерөнхий үнэлгээ.....	31
Хүснэгт 6. Сургалтад хамрагдсан аймаг, сумдын хуваарь	48
Хүснэгт 7. Багийн ИНХ-ын дарга нарын сургалтын ерөнхий үнэлгээ	58
Хүснэгт 8. Оролцогчдын мэдлэгийн бүтээгдэхүүнийг ашиглаж байгаа түвшин	77
Хүснэгт 9. Үр нөлөөний судалгааны ерөнхий үр дүн	86
Хүснэгт 10. Анкетын түүврийн хэмжээг тооцох нь (99.7% баталгааны түвшинтэй, $p=0.5$)	100
Хүснэгт 11. Анкетын түүврийн хэмжээг тооцсон нь	100
Хүснэгт 12. Чанарын (ярилцлага) судалгаанд хамрагдах түүврийг тооцсон байдал	103

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Иргэдийн төлөөлөгчдийн суурь сургалтад хамрагдсан байдал	4
Зураг 2. Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин, сургалтын үзүүлэлтүүдээр...	4
Зураг 3. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авч чадсан гэж үзэж байна уу?.....	6
Зураг 4. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авч чадсан гэж үзэж байна уу? /хүйсээр/.....	7
Зураг 5. Сургалтын үр дүнд таны мэдлэг, ур чадвар хэрхэн дээшилсэн бэ?	8
Зураг 6. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтаас сурсан мэдлэг, ур чадвараа ашиглаж байгаа юу?	9
Зураг 7. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтаас сурсан мэдлэг, ур чадвараа ашиглаж байгаа юу? /хүйсээр/	10
Зураг 8. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад хамрагдсанаар таны ажлын арга барил өөрчлөгдсөн үү?	12
Зураг 9. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад хамрагдсанаар таны ажлын арга барил өөрчлөгдсөн үү? /хүйсээр/	12
Зураг 10. Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад танай хурлын төлөөлөгчид хамрагдсанаар танай байгууллагын ажилд өөрчлөлт гарсан уу?.....	12
Зураг 11. ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтын ерөнхий үнэлгээ	15
Зураг 12. ИТХ-ын Тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчид.....	19
Зураг 13. Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг үнэлсэн байдал	20
Зураг 14. Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг үнэлсэн байдал /хүйсээр/	20
Зураг 15. Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдал.....	21
Зураг 16. Багшийн ур чадвар, заах арга зүй	21
Зураг 17. Сургалтын хугацааны тохиромжтой байдал	22
Зураг 18. Сургалтын гарын авлага, тараах материалын чанар.....	23
Зураг 19. ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан Манлайллын сургалтын оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин /үзүүлэлт бүрээр/	23
Зураг 20. Төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авч чадсан байдал.....	25
Зураг 21. Төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авч чадсан байдал.....	25
Зураг 22. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр дүнд тэргүүлэгчдийн мэдлэг, ур чадвар дээшилсэн байдалд өгсөн үнэлгээ /үзүүлэлт тус бүрээр/.....	26
Зураг 23. Төлөөлөгчдийн мэдлэг, ур чадвар тодорхой чиглэлд дээшилсэн байдал.....	26

Зураг 24. ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтаас сурсан мэдлэг, чадвараа ашиглаж байгаа байдал.....	27
Зураг 25. ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтаас сурсан мэдлэг, чадвараа ашиглаж байгаа байдал /хүйсээр/	28
Зураг 26. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар төлөөлөгчдийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдал	29
Зураг 27. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар эмэгтэй төлөөлөгчдийн ажлын арга барил илүү өөрчлөгдөн сайжирсан байдал /хүйсээр/	29
Зураг 28. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар тухайн хурлын ажил сайжирсан байдал	30
Зураг 29. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар тухайн хурлын ажил сайжирсан байдал /хүйсээр/	30
Зураг 30. ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан Манлайллын сургалтыг үнэлсэн байдал /Үзүүлэлт бүрээр/	32
Зураг 31. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчид.....	34
Зураг 32. Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг үнэлсэн байдал	35
Зураг 33. Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдал.....	35
Зураг 34. Багшийн ур чадвар, заах арга зүй	36
Зураг 35. Сургалтын хугацааны тохиромжтой байдал	36
Зураг 36. Сургалтын гарын авлага, тараах материалын чанар.....	37
Зураг 37. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин /Үзүүлэлт бүрээр/	38
Зураг 38. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авсан байдал	39
Зураг 39. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын үр дүнд эмэгтэй төлөөлөгчдийн мэдлэг, ур чадвар дээшилсэн байдалд өгсөн үнэлгээ /үзүүлэлт тус бүрээр/.....	39
Зураг 40. Эмэгтэй төлөөлөгчдийн мэдлэг, ур чадвар тодорхой чиглэлд дээшилсэн байдал.....	40
Зураг 41. Эмэгтэй төлөөлөгчид манлайллын сургалтаас олж авсан мэдлэг, ур чадварыг ашиглаж байгаа байдал	40
Зураг 42. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар төлөөлөгчдийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдал	41
Зураг 43. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар тухайн хурлын ажил сайжирсан байдал	42
Зураг 44. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтыг үнэлсэн байдал /Үзүүлэлт бүрээр/.....	46
Зураг 45. Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсан байдал	49

Зураг 46. Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин, сургалтын үзүүлэлтүүдээр	50
Зураг 47. Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтаас хангалттай мэдлэг, чадвар олж авч чадсан гэж үзэж байна уу?	51
Зураг 48. Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтаас хангалттай мэдлэг, чадвар олж авч чадсан гэж үзэж байна уу? /хүйсээр/	52
Зураг 49. Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтаас сурсан мэдлэгээ ашиглаж байгаа юу?	53
Зураг 50. Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтаас сурсан мэдлэгээ ашиглаж байгаа юу? /хүйсээр/	53
Зураг 51. Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсанаар таны ажлын арга барил өөрчлөгдсөн үү?	54
Зураг 52. Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсанаар таны ажлын арга барил өөрчлөгдсөн үү? /хүйсээр/	55
Зураг 53. Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсанаар танай байгууллагын ажилд өөрчлөлт гарсан уу?	56
Зураг 54. Багийн ИНХ-ын дарга нарын сургалтын ерөнхий үнэлгээ	58
Зураг 55. Тэтгэлэгт хамрагдсан орон нутгийн оролцогчдын эзлэх хувь	61
Зураг 56. Оролцогчид ИТХ-д олгосон тэтгэлгийг үр нөлөөг үнэлсэн үнэлгээ /хувиар/	62
Зураг 57. Илтгэлийн постер	69
Зураг 58. Оролцогчдоос мэдлэгийн бүтээгдэхүүний ашиглагдахуйц байдалд өгсөн үнэлгээ /Бүтээгдэхүүн тус бүрээр/	78
Зураг 59. “Хууль зүйн техник” номыг үндсэн ажилдаа ашиглах боломжтой байдал	80
Зураг 60. “Хууль зүйн техник” номыг уншиж ашиглахад тохиромжтой байдал	80
Зураг 61. “Хууль зүйн техник” номын орчуулгын чанарыг үнэлсэн байдал	81
Зураг 62. “Хууль зүйн техник” номын хүрэлцээт байдал	82
Зураг 63. “Хууль зүйн техник” номыг уншиж ашиглаж байгаа байдал	82
Зураг 64. Үр нөлөөний судалгааны ерөнхий үр дүн	87
Зураг 65. Судалгааны ажлын арга зүйн зураглал	98
Зураг 66. Судалгаанд хамрагдсан талбар (Аймаг, дүүргүүд)	101
Зураг 67. Судалгаанд оролцогчдын насны бүлэг болон хүйсийн харьцаа	102
Зураг 68. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин	102
Зураг 69. Судалгаанд оролцогчид /хурал тус бүрээр/	103
Зураг 70. Сургалтад хамрагдсан байдал /сургалтын төрлөөр/	103

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БИНХ	Багийн иргэдийн Нийтийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
УИХТГ	Улсын Их Хурлын Тамгын газар
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХУД	Хан-Уул дүүрэг
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ШХУ	Швейцарын Холбооны Улс

УДИРТГАЛ

УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд 2017-2019 онд зохион байгуулсан сургалт, чадавхжуулах үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх зорилгоор “Түгээмэл эрх-Хөгжил” ТББ-аас энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Энэхүү үр нөлөөний судалгааны хүрээнд “ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт”, “ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалт”, “Эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалт”, “Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалт” болон Шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлэгт хөтөлбөр, УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн сургалт, туршлага судлах хөтөлбөр, мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах үйл ажиллагааны үр нөлөөг тус бүрд нь үнэлж төслийн эдгээр үйл ажиллагааг нэгтгэн дүгнэх болно.

Судалгааны баг нь төслийн хүрээнд хэрэгжүүлсэн дээрх үйл ажиллагааны үр нөлөө буюу төслийн үр шимийг шууд хүртэгчдийн олж авсан мэдлэгийн түвшин, уг мэдлэгийг албан ажилдаа ашиглах ур чадвар сайжирсан эсэх, үүний үр дүнд тодорхой үр нөлөө гарч байгаа эсэхийг шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитойгоор үнэлж, сургалт болон чадавхжуулах үйл ажиллагааны үр дүнд бий болсон сайн туршлагыг судалж, цаашид анхаарах асуудлууд болон тогтвортой байдлыг хэрхэн хангах талаар санал зөвлөмж боловсруулах төлөвлөгөөтэй энэхүү үр нөлөөний судалгааны тайланг бэлтгэсэн болно.

Харин судалгааны 1 дүгээр бүлэгт энэхүү судалгааны хүрээнд үнэлсэн үйл ажиллагаа тус бүрийн үр нөлөөг баримт бичгийн, тоон болон чанарын судалгааны үр дүнд суурилан дэлгэрэнгүй тайлбарлалаа. Тус бүлэгт Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт, ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалт, Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалт, Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалт, ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн үр нөлөө болон УИХТГ-ын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны үр нөлөөг тус тус дэд бүлэг болгон нийт 6 дэд бүлэгт хуваан авч үзсэн бөгөөд дэд бүлэг тус бүр тодорхой үзүүлэлтүүд болон дэд үзүүлэлтүүдийг илтгэх 5 хүтэлх тооны хэсгүүдээс бүрдэх үндсэн зохион байгуулалтыг баримталлаа.

Ингэхдээ төслийн зохион байгуулсан сургалтын үйл ажиллагаа бүр нь оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин, сургалтаар заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин, сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал болон мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт өөрчлөлт гаргасан байдал гэсэн үндсэн 4 үзүүлэлтэд үндэслэхээр, ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн үр нөлөө гэсэн дэд бүлэг нь

ИТХ-д олгосон тэтгэлгийн үр нөлөө, ТББ-д олгосон тэтгэлгийн үр нөлөө гэсэн үндсэн 2 хэсгээс, харин УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх ажлын үр нөлөө гэсэн дэд бүлэг нь туршлага судлах, нийтийн сонсгол зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах гэсэн үндсэн 3 хэсгээс тус тус бүрдэх бөгөөд дэд бүлэг тус бүр нь дүгнэлттэй, дүгнэлтэд тухайн дэд бүлгийн зөвлөмж багтах зохион байгуулалттай байна.

Харин 2 дугаар бүлэгт үр нөлөөний үнэлгээний тусгайлан үнэлсэн болон нэгтгэсэн үр дүнг төслийг хэрэгжүүлж эхлэхдээ хүрэхээр хүлээж байсан үр дүнтэй харьцуулан дүгнэсэн болно.

Судалгааны 3 дугаар бүлэгт энэхүү судалгааг боловсруулж, гүйцэтгэх, дүгнэх үйл явцын үр дүнд бий болсон судалгааны зөвлөмжүүдийг үнэлсэн үйл ажиллагаа тус бүрээр ангилж оруулсан болно.

Эцэст нь буюу судалгааны хавсралтуудыг агуулах 4 дүгээр бүлэгт судалгааны тухай ерөнхий мэдээллийг өгөх зорилгоор судалгааны үндэслэл, зорилго, зорилтууд, хамрах хүрээ, хүрэх үр дүнг товч танилцуулж, үр нөлөөний судалгаа боловсруулсан арга зүйг дэлгэрэнгүй орууллаа. Ингэхдээ тоон болон ярилцлагын судалгааны түүврийг сонгосон аргачлал, түүврийн хэмжээг тодорхойлж, төлөөлөх чадварыг хангасан баталгааг тайлбарласан болно. Мөн энэхүү бүлэгт судалгааг нарийвчлан ойлгоход хэрэг болох бусад материалуудыг хавсарган орууллаа.

1. ҮНЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТУС БҮРИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Энэхүү 1 дүгээр бүлэг нь нөлөөллийн үнэлгээний судалгааны үндсэн үр дүнг дэлгэрэнгүй харуулах бөгөөд түүнд үндэслэн ерөнхий дүгнэлт зөвлөмжүүдийг боловсруулсныг энэхүү тайлангийн 3 болон 4 дүгээр бүлгээс үзнэ үү.

1.1 Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын үр нөлөө

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Удирдлагын академитай хамтран төслийн эхний үе шат болох “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд 2016 онд бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын хөтөлбөрийн агуулгыг сайжруулан боловсруулан энэхүү хөтөлбөрийн дагуу ИТХ-ын төлөөлөгчдийн үндэсний сургалт нь:

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, хуралдаан, хуралдааны дэг;
- Орон нутгийн төсөв, санхүү;
- Байгаль хамгаалал, газрын харилцаа;
- *Иргэний оролцоо иргэдтэй харилцах* гэсэн 4 сэдэвтэй, 2 өдрийн 18 цагийн сургалтыг зохион байгуулсан байна.

2016 оны 06 дугаар сард аймаг, нийслэлийн; 10 дугаар сард сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгууль явагдсан бөгөөд сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан ИТХ-ын төлөөлөгчдийн 60 гаруй хувь нь анх удаагаа сонгогдсон байна. Иймд шинээр сонгогдсон төлөөлөгчдөд зориулж суурь сургалтыг цаг алдалгүй зохион байгуулах хэрэгцээ шаардлага гарч, 2016 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдөд болон 21 аймгийн ИТХ-д, 9 аймгийн болон 330 сумдын нийт төлөөлөгчдийг хамруулан, 2017 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд бусад 12 аймгийн сумдын болон нийслэлийн 9 дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт зохион байгуулсан байна.

Төслийн зүгээс дараах зүйлсийн холбогдох удирдамж, чиглэлээр хангаж ажилласан байна.

- Төлөөлөгчдийн сургалтад ажиллах сургагч багш нарын ажлын удирдамж
- Төлөөлөгчдийн сургалт зохион байгуулах аймгийн ИТХ-ын ажлын албаны ажлын удирдамж
- Сургалтын хяналт-үнэлгээний ажлын удирдамж
- Сургалтын санхүүжилтийг зарцуулах ажлын удирдамж

Ингэснээр сургалтыг үндэсний хэмжээнд стандартын дагуу зохион байгуулах боломж бүрдсэн байна.

Хүснэгт 1. Сургалтад хамрагдсан аймаг, сумдын хуваарь¹

№	Аймаг	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт					Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт					
		Огноо		Нийт төлөөлөгч	Сургалтад хамрагдсан		Огноо		Нийт төлөөлөгч	Сургалтад хамрагдсан		
		2016 оны 11 сар	оны		тоо	хувь	2017 оны 1 сар	оны		тоо	хувь	
1	Архангай	2016 оны 11 сар	оны	39	33	84.6	2017 оны 1 сар	оны	1	433	409	93.6
2	Баян-Өлгий	2016 оны 12 сар	оны	39	36	92.3	2017 оны 1 сар	оны	1	329	293	89.4
3	Баянхонгор	2016 оны 11 сар	оны	41	41	100	2016 оны 12 сар	оны	12	418	418	100
4	Булган	2016 оны 12 сар	оны	33	30	90.9	2017 оны 2 сар	оны	2	340	280	83.1
5	Говь-Алтай	2016 оны 12 сар	оны	40	35	87.5	2017 оны 4 сар	оны	4	363	303	83.9
6	Говьсүмбэр	2016 оны 11 сар	оны	16	11	68.8	2016 оны 11 сар	оны	11	67	59	84.3
7	Дархан-Уул	2016 оны 11 сар	оны	33	31	93.9	2016 оны 12 сар	оны	12	106	101	95.0
8	Дорноговь	2016 оны 12 сар	оны	31	28	90.3	2017 оны 2 сар	оны	2	272	259	94.7
9	Дорнод	2016 оны 11 сар	оны	35	35	100	2016 оны 11 сар	оны	11	274	256	94.2
10	Дундговь	2016 оны 11 сар	оны	35	35	100	2017 оны 2 сар	оны	2	295	295	100
11	Завхан	2016 оны 11 сар	оны	40	40	100	2016 оны 11 сар	оны	11	442	416	94.6
12	Орхон	2016 оны 12 сар	оны	33	23	69.7	2016 оны 12 сар	оны	12	52	41	75.3
13	Өвөрхангай	2016 оны 11 сар	оны	41	31	75.6	2017 оны 1 сар	оны	1	447	416	91.6
14	Өмнөговь	2016 оны 11 сар	оны	33	12	36.4	2016 оны 11 сар	оны	11	305	252	78.1
15	Сүхбаатар	2016 оны 12 сар	оны	33	28	84.8	2017 оны 3 сар	оны	3	271	257	93.8
16	Сэлэнгэ	2016 оны 11 сар	оны	37	30	81.1	2017 оны 2 сар	оны	2	387	323	83.3
17	Төв	2016 оны 10 сар	оны	41	34	82.9	2017 оны 3 сар	оны	3	529	432	81.8
18	Увс	2016 оны 11 сар	оны	41	41	100.0	2016 оны 11 сар	оны	11	403	372	93.0
19	Ховд	2016 оны 11 сар	оны	41	24	58.5	2016 оны 11 сар	оны	11	371	356	92.2
20	Хөвсгөл	2016 оны 12 сар	оны	41	41	100.0	2017 оны 1 сар	оны	1	517	517	100

¹ Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн 2017 оны үйл ажиллагааны тайлан

21	Хэнтий	2016 оны 11 сар	39	31	79.5	2017 оны сар	2	380	365	94.5
	Нийт		762	650	85.3			7001	6420	92

Аймгийн ИТХ-ын сургалтад нийт 762 төлөөлөгчөөс 650 төлөөлөгч оролцсон нь 85.3 хувийн ирцтэй байсан бол сумын ИТХ-ын сургалтад нийт 7001 төлөөлөгчөөс 6420 төлөөлөгч оролцсон нь 92 хувийн ирцтэй байна.

Нийслэлийн дүүргүүдийн ИТХ-ын ажлын алба мөн дүүргийнхээ сургалтыг хариуцан зохион байгуулсан нь өмнөх удаагийн сургалттай харьцуулахад ирц сайн байхад нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 2. Сургалтад хамрагдсан нийслэл, дүүргүүдийн хуваарь²


№	Дүүрэг	Огноо	Нийт төлөөлөгч	Сургалтад хамрагдсан	
				тоо	хувь
	Нийслэлийн ИТХ	2016.09.08.22	45	35	77.8
1	Чингэлтэй	2017.02.02-03	35	30	85.7
2	Багануур	2017.03.11-12	25	24	96.0
3	Багахангай	2017.03.10-11	17	15	88.2
4	Налайх	2017.03.10-11	21	17	81.0
5	Хан-Уул	2017.04.14-15	35	22	62.9
6	Сүхбаатар	2017.04.06-07	35	35	100
7	Сонгинохайрхан	2017.04.06-07	41	31	75.6
8	Баянгол	2017.04.20-21	41	27	65.9
9	Баянзүрх	2017.04.21-22	41	36	87.8
	Нийт		291	272	86.1

“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл нь 1) бүх шатны нутгийн удирдлагын байгууллагыг чадавхжуулах; 2) төлөөллийн байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх үндсэн зорилгын хүрээнд 2017, 2018 онд бүх шатны иргэдийн **Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт**, манлайллын сургалт, эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалт, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан байна.

Энэ иргэдийн төлөөлөгчдийн суурь сургалтад дээр дурдсан хугацаанд нийт 7377 төлөөлөгч оролцсон байна.

² Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн 2017 оны үйл ажиллагааны тайлан

Зураг 1. Иргэдийн төлөөлөгчдийн суурь сургалтад хамрагдсан байдал




Энэ удаагийн үр нөлөөний судалгаанд оролцсон төлөөлөгчдийн 389 буюу 83.3% нь Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад хамрагдсан байна.

Суурь сургалтын үр нөлөөг дүгнэхдээ доорх дэд хэсгүүдэд ангилан үзлээ. Үүнд:

Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин

Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшинг сургалтын ерөнхий зохион байгуулалт, сэдвийн ач холбогдол, багшийн ур чадвар, сургалтын хугацаа гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэснийг доорх хэсгээс үзнэ үү.

Зураг 2. Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин, сургалтын үзүүлэлтүүдээр



Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг оролцогчдын 18.6% нь маш сайн, 67.7% нь сайн, 13.2% нь дунд, 0.5% нь муу гэж үнэлсэн бол маш муу гэж хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид зохион байгуулалтыг ерөнхийдөө сайн (86.3 оноо) гэж дүгнэжээ.

Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдлыг оролцогчдын 20.7% нь маш сайн, 63% нь сайн, 15.5% дунд 0.5% нь муу гэж үнэлсэн бол маш муу гэж

хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдлыг ерөнхийдөө сайн (83.7 оноо) гэж дүгнэжээ.

Багшийн ур чадвар, заах арга зүйг оролцогчдын 27.5% нь маш сайн, 60.7% нь сайн, 11.8% дунд гэж үнэлсэн бол муу болон маш муу гэж хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид багшийн ур чадвар, заах арга зүйн чадварыг ерөнхийдөө сайн (88.2 оноо) гэж дүгнэжээ

Сургалт зохион байгуулсан цаг үе болон, сургалт үргэлжилсэн хугацааг оролцогчдын 18.6% нь маш сайн, 57.3% нь сайн, 20.9% дунд 2.9% нь муу гэж үнэлсэн бол маш муу гэж хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид зохион байгуулсан цаг үе болон сургалтын үргэлжилсэн хугацааг ерөнхийдөө сайн (76.2 оноо) гэж дүгнэжээ.

Сургалтын гарын авлага, тараах материалын чанарыг оролцогчдын 22.2% нь маш сайн, 58.4% нь сайн, 17.6% дунд 1.8% нь муу гэж үнэлсэн бол маш муу гэж хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид сургалтын тараах материал, гарын авлагыг ерөнхийдөө сайн (81.6 оноо) гэж дүгнэжээ

Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшинг сургалтын ерөнхий зохион байгуулалт, сэдвийн ач холбогдол, багшийн ур чадвар, сургалтын хугацаа гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэж, тус бүрд нь оноо тавьж дээрх хэсэгт оруулсан билээ. Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл оролцогчдын ерөнхий сэтгэл ханамж түвшинг 83.2 оноо гэж үзэхээр байна.

Шигтгээ 1. Говь-Алтай аймаг, Бугат сум ярилцлага

Өмнө нь ажиллаж байгаагүй буюу 2016 оны сонгуулийн үр дүнд бүрэлдсэн хурлын төлөөлөгчдөд тэдний эрх, үүрэг, хариуцлага зэрэг шинэ тутам ойлголтыг өгч чадсан. **Миний хувьд сургалтын агуулгаас төсөв, санхүүтэй холбоотой сэдэв нь хамгийн сонирхолтой байсан. Тухайлбал, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх бараа, ажил, үйлчилгээний журмын талаар, мөн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, төлөвлөлт, үүнтэй холбоотой асуудлаар нягтлан бодогч болон төрийн сантай харьцах зэрэг асуудлыг хамгийн сайн ойлгож, мэдэж авсан.** Сургалт явуулсан багш нарын заах арга барил сайн, хүмүүсийг идэвхжүүлэх зүйлүүдийг хийж байсан болохоор сонирхолгүй юм уу ач холбогдолгүй санагдсан сэдэв байгаагүй, сургалтын хөтөлбөр гайгүй байсан гэж үзэж байна.

Мөн 2016 оны сонгуулийн үр дүнд шинээр сонгогдсон төлөөлөгч нарт илүү их хэрэгтэй, сэтгэл ханамжтай байсан байна. Харин сургалтад оролцогчид сургалтын 5н үзүүлэлтээс хугацааны хувьд болон сургалтын материал, гарын авлага зэрэгт шүүмжлэлтэй хандах тохиолдол гарчээ.


Шигтгээ 2. Булган аймаг, Булган сум ярилцлага

Сургалтын хувьд хоёр өдөр явуулахад тохиромжтой юм байна лээ. Өдрийн цагийг нь багасгаад хоногийг нь сунгаад байвал нэг өөр, нэг өдөрт олон цагаар бүх сургалтаа бөөндөхөөр ойлгомжтой байдлын тал дээр асуудал үүсч байгаа юм. Хоёр өдрийн сургалт нь өөрөө их цэгцтэй бөгөөд байршлын хувьд их зүгээр санагдсан. Нэг давхарт нь сургалт явагдаад нөгөө давхарт нь хоол унд, амрах асуудал шийдэгдээд явчихаар цаг алдалгүйгээр хоёр хоногийнхоо 8 юмуу 10 цагийг үр дүнтэй өнгөрөөх боломж нь хангагдаж байгаа юм. Цаг хугацааны хувьд 11-р сард болсон болохоор манай аймгийн хувьд газар тариалангийн асуудал цэгцэрчихсэн, харьцангуй өвөлжилтийн байдал хангагдчихсан, ажлын ачаалал харьцангуй гайгүй үеэр зохиогдсон учраас үр дүнтэй л санагдсан.

Зарим орон нутгийн төлөөлөгч нарын суурь сургалтын хугацааны хувьд тохиромжтой байсан (сайн жишээ) талаар дурдаж байсан бол зарим орон нутгийн сургалтууд тийм биш байжээ.


Төлөөлөгчид төслийн баримт бичигт заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин

Зураг 3. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авч чадсан гэж үзэж байна уу?



Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад хамрагдсан оролцогчдоос тус сургалтаас олж авсан мэдлэг, ур чадварыг нь өөрсдөөр нь үнэлүүлэхэд маш хангалттай гэж 11% нь, ер нь хангалттай гэж 72% нь, дундаж гэж 15% нь, ер нь хангалтгүй гэж 2% нь, хангалтгүй гэж 2 оролцогч (0.5%) тус тус үнэлсэн байна. Үүнийг дүгнэж үзвэл оролцогчид өөрийн олж авсан мэдлэг, ур чадвартаа дунджаар 82.7 оноо өгсөн байна.

Зураг 4. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авч чадсан гэж үзэж байна уу? /хүйсээр/




Суурь сургалтаас төлөөлөгчид хангалттай мэдлэг, ур чадвар олж авсан талаар хүйсээр харьцуулж үзвэл эрэгтэй төлөөлөгчид эмэгтэй төлөөлөгчдөөсөө 10 орчим хувиар дунд буюу дутуу үнэлгээ өгсөн байна.

Шигтгээ 3. Булган аймаг, Булган сум ярилцлага

Хичээл орсон сэдвүүдээр мэдлэгээс гадна мэдээлэл олж авах давуу талтай байсан. Ур чадварын тал дээр багаар ажиллах, эргээд багийнхаа ажилласан ажлынхаа гүйцэтгэлийг танилцуулах, өөрийн байр сууриа илэрхийлж асуудлын мөн чанарыг эрэлхийлэх, хуулийн хүрээнд хандах, хуулийн хэллэгээр хандах гэх мэт мэдлэг мэдээллийг олж авсан. Үр дүн бол мэдээж байгаа, бид бүхэн тогтоолыг гаргахдаа холбогдох тогтоолын хуулийн үндэслэл гаргалгаа юу байна г.м. асуудлыг агуулгаар нь өргөн хүрээнд олж харж хэрэгжүүлдэг. Энэ маань өөрөө хурлын шийдвэрийн үр дүнд эрх зүйн үндэслэлтэй шийдвэр гаргах боломжийг нээж өгч байна гэж харж байгаа. Гол нь хурлын байгууллагаас гарч байгаа шийдвэр өөрөө оновчтой үр дүн тодорхой байх ийм асуудал гэж харж байгаа. Хоёр дах асуудал нь шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангахад үр дүнтэй гэж үзэж байгаа. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, хэлэлцэх асуудал жилийн 4 улирал дамнаад явж байдаг. Дээрээс нь төрийн буюу орон нутгийн хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд иргэний хөндлөнгийн хяналт тавих, эсвэл төрийн үйл ажиллагаанаасаа иргэдэд тайлагнах гэх мэтээр төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах тал дээр ололттой яваа гэж үзэж байна.

Төлөөлөгчид сургалтын үндсэн 4 сэдэв болох Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, хуралдаан, хуралдааны дэг; Орон нутгийн төсөв, санхүү; Байгаль хамгаалал, газрын харилцаа; Иргэний оролцоо иргэдтэй харилцах зэрэг сэдвүүдээр ур чадвар эзэмшихийн зэрэгцээ олон төрлийн мэдээллүүд авсан. Мөн төлөөлөгч хүнд байх ёстой хандлагуудыг сурч авсан гэж дурдаж байна.

Зураг 5. Сургалтын үр дүнд таны мэдлэг, ур чадвар хэрхэн дээшилсэн бэ?



Харин тус сургалтад оролцсон төлөөлөгчдийн мэдлэг, ур чадвар дараах чиглэлд хэрхэн дээшилсэн эсэхийг тодруулахад оролцогчдоос иргэдтэйгээ ажиллах санаачилга, чадвар нэмэгдсэн байдалд дунджаар 80 оноо, байгаль хамгаалал, газрын харилцааны гэх мэт асуудлыг илүү анхаардаг болсон байдалд дунджаар 78 оноо, орон нутгийн төсвийн төлөвлөлт, хяналтад оролцох мэдлэг, оролцоо дээшилсэн байдалд дунджаар 81 оноо, хууль тогтоомжийн талаарх мэдлэг, хэрэглэх чадвар сайжирсан байдалд дунджаар 78.9 оноо, ИТХ-ын хуралдаанд илүү идэвхтэй оролцдог болсон байдалд дунджаар 86 оноог тус тус өгч дүгнэсэн байна. Нэгтгэн үзвэл төлөөлөгчид тодорхой чиглэлээр мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байдлаа дунджаар сайн буюу 80.8 оноо гэж дүгнэж болохоор байна.

Харин үүнийг өмнөх мэдлэг ур чадварыг эзэмшсэн байдалд ерөнхийд өгсөн 82.7 оноотой дунджилж үзвэл 81.75 оноо байна.

Шигтгээ 4. Булган аймаг, Бүрэгхангай сум ярилцлага


Миний хувьд тухайн үед төрийн үйлчилгээний байгууллагад ажилладаг байсан. Харин одоо нутгийн өөрөө удирдах байгууллагад төлөөлөгчөөр сонгогдсон. Анх нутгийн өөрөө удирдах байгууллага гэж юу байдаг талаар мэдлэггүй байсан. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг юу гэдгийг мэддэггүй байв. **Харин тухайн сургалтанд сууснаар нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний эрх зүйн орчин, эрх үүрэг зэргийг судалж мэдэж авсан. Төрийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа учир хуулийн эрх зүйн орчинг амьдрал ахуйдаа хэрэглэж байна. Ажлын чанарын хувьд дээшилсэн гэж бодож байна. Үйл ажиллагаа, чиглэл, эрх зүйн орчинг мэдэж хуулийн дагуу тухайн багаас сонгогдож ард иргэдийн эрх ашгийн төлөө тодорхой шийдвэр гаргаж ажиллаж байна. Бусад сургалтанд суусан төлөөлөгч нарын хувьд 50, 50 хувьтай гэж бодож байна. Шинээр**

сонгогдсон төлөөлөгч нар надтай адил эрх зүйн орчингоо мэдэхгүй байсан. Харин одоо тийм асуудал харьцангуй гайгүй болж байна. Энэ нь сургалтын ач гэж бодож байна. Сайн жишээ гэвэл манай сумын хэмжээнд тог цахилгааны асуудал байсан. Үүнийг иргэдийн хурлын төлөөлөгч нар ард иргэдтэйгээ уулзан санал гомдлын дагуу дээд шатны байгууллага руу албан тоот явуулсан. Энэ нь нэг дэвшил гэж бодож байгаа. **Энэхүү сургалтын сөрөг тал гэхээс илүү зөрөг тал бий. Манай сонгуулийн тогтолцоо нь 4 жил. Манай залуучууд улс төр лүү ихээр орж байгаа. Тэдний эрх зүйн орчин болон хуулийн тухай мэдлэг мэдээлэл хомс гэж харагддаг. Би ч мөн адил анх тийм байсан. Тиймээс энэхүү сургалтыг цааш нь өшөө илүү үр дүнтэй үргэлжлүүлж бусад аймаг, сум, дүүргүүдэд хэрэгжиж байгаа хэрэгцээтэй туршлага сургалтуудыг нэмэн санаа авбал хэрэгтэй гэж санагдсан.** Анх сонгогдож байгаа хүмүүс өмнөх хүмүүс яаж хэрхэн ажиллаж байсныг мэдэхгүй тул санаа авах зорилгоор байвал зүгээр юм болов уу гэж харсан. Монголын хувьд нутгийн өөрийн удирдлага нилээн сайн тогтож үйл ажиллагаа нь жигдэрч эрх зүйн орчин бүрдсэн гэж харж байна.

Төлөөлөгчид маань урьдчилан бэлтгэгдэж гэхээсээ илүүтэйгээр иргэд, олон нийтээс сонгогдож орж ирдэг тул тэр бүр дүрэм журам, эрх үүргээ мэдэж дадсан байдал нь хомс байдаг. Иймээс энэ сургалтаас олж авах ур чадвар, мэдлэг, мэдээлэл бол зайлшгүй хэрэгтэй гэж үзжээ. Мөн төлөөлөгчдийн үндсэн ажил болох хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааг мөн чанарын түвшинд ойлгож хуралдааныг дүрэм, журмын дагуу оролцож хийдэг болсон гэжээ. Төлөөлөгчдийн үндсэн ажил болох хуралдаандаа идэвхтэй оролцох байдал нь нэмэгдэхүйц нэмэгдсэн гэжээ.

Төлөөлөгчид сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал


Зураг 6. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтаас сурсан мэдлэг, ур чадвараа ашиглаж байгаа юу?



Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад хамрагдсан оролцогчдоос тус сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа өдөр тутам ашиглаж байгаа гэж 24%

нь, ихэвчлэн ашигладаг гэж ½ буюу 50% нь, заримдаа ашигладаг гэж 23% нь, бараг ашигладаггүй гэж 3% нь, ашигладаггүй гэж 1 оролцогч тус тус хариулсан байна. Эдгээрээс үзэхэд сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдлаа оролцогчид дунджаар 78.6 оноогоор үнэлсэн байна.

Зураг 7. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтаас сурсан мэдлэг, ур чадвараа ашиглаж байгаа юу? /хүйсээр/



Суурь сургалтаас сурсан мэдлэг, ур чадвараа ашиглаж байгаа талаар хүйсээр харьцуулж үзвэл эрэгтэй төлөөлөгчид эмэгтэй төлөөлөгчдөөсөө ялимгүй бага үзүүлэлтээр ашигладаггүй гэж хандлага ажиглагдаж байна.

Шигтгээ 5. Төв аймаг, Алтанбулаг сум ярилцлага

Сургалтын үр дүнд багаар ажиллах чадвар, өөрийгөө илэрхийлэх чадвар болон хурлаараа зайлшгүй шаардлагатай асуудлыг оруулах, хэлэлцүүлэх чадвар сайжирсан. Эдгээр мэдлэг, чадвараа ажилдаа өдөр тутам ашиглаж байна. Урьд нь буюу 2013 оноос өмнө ИТХ-д ихэвчлэн төрийн албан хаагчид сонгуулийн өмнө ажлаа хүлээлгэж өгөөд ИТХ-д сонгогдон гарч ирдэг байсан. Харин 2013 оноос хойш энэ үзэгдэл ерөнхийдөө хумигдаж ИТХ-д иргэд, малчид, аж ахуйн нэгжийн төлөөлөл их хэмжээгээр орж ирж байна. Энэ нь нэг давуу тал бөгөөд эдгээр анх удаа сонгогдож буй төлөөлөгчдөд хууль, эрх зүйн анхан шатны мэдлэг өгөх, ИТХ-ын чиг үүргийг таниулах, мэдүүлэх сургалт зохион байгуулж байгаа нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оруулж байгаа маш том хөрөнгө оруулалт гэж үзэж байна. Түүнчлэн энэ сургалтаар дамжаад малчдад зориулсан сургалтыг орон нутгаас мөн зохион байгуулснаар ИТХ-ын чадавх дагаад сайжирч байна. Түүнчлэн хурлын ирц сайжрах, хуралдаа идэвхтэй оролцох, сургалтад хамрагдсан төлөөлөгчид бусдыгаа манлайлж ажилласнаар жишиг тогтоох, үлгэр дуурайл үзүүлэх, багийн хэмжээнд өдөрлөг зохион байгуулж иргэдэд мэдээлэл өгөх, тараах материал тараах зэрэг өөрчлөлтүүд гарч байна. Ингэснээр иргэд тэр дундаа залуучуудын идэвх оролцоо илт нэмэгдэж байна.

Урьд дурдаж байсанчлан төлөөлөгч нарын ур чадвар, мэдлэг мэдээлэл нэмэгдэхийн зэрэгцээ түүнийг ашиглах, хэрэгжүүлэх дадал төдий хэмжээнд нэмэгдсэн байна. Мөн 2013 оноос хойш төлөөлөгчөөр төрийн албан хаагч байсан хүн сонгогдох гэхээсээ илүүтэйгээр жирийн иргэд малчин, аж ахуйн нэгжийн төлөөлөл зэрэг хүмүүс

сонгогдох нь ихэссэн гэжээ. Энэ нь нэг талаасаа жирийн иргэд, ард түмний төлөөлөл шийдвэр гаргах түвшинд нэмэгдэж байгаа нь сайн талтай боловч нөгөө талдаа тэр сонгогдсон төлөөлөгчдөд ур чадвар, мэдлэг мэдээллийн эрэлт хэрэгцээ өндөр байсан нь харагдаж байна.

Шигтгээ 6. Булган аймаг, Баян-Агт сум ярилцлага

Миний хувьд бол ажлын шаардлагаар ч тэр өдөр тутамдаа янз янзын зүйлийг ашиглаж байна л даа. Тухайн сургалтаас олзуурхаж авсан зүйл гэвэл **иргэдэд мэдээллийг байнга өгөх, түгээх юм байна** гэж бодоод төсөв батлахад сумын иргэдэд хамгийн их хэрэгцээ шаардлагатай зүйл юу вэ?, явал иргэдийн дийлэнх нь үр ашгийг нь хүртэх вэ гэдгийг бодсон. Олон хүнийг оролцуулж байж л зөв санааг гаргаж авах юм байна лээ.


Жишээ нь бид нар хавраас эхлээд орон нутгийн хөгжлийн сан дээр юу хийх вэ? гэдэг санал авахдаа аль болох олон хүнийг оролцуулахыг хичээж байна. Багийн дарга нарыг ашиглаад, интернет цахим орчныг ашиглаад хавар яг эцэслэх дээр нь багийн хурлууд дээр, тэрнээс өмнө урилга болон өмнөх жилийн тайлан тараах зэргээр мэдээлэл их өгвөл идэвхитэй байх хандлагатай байгаа юм. Манай хөдөөний иргэд яг өөрт нь хандсан урилга өгвөл их дуртайгаар оролцдог. Мөн сум хөгжүүлэх сан, ялангуяа зээл төсөл авсан иргэдийн хариуцлагатай байлгах юмаа сайн хийхэд нь ч нөлөөлж байх шиг байгаа юм. Нөгөөтэйгүүр төсөл шалгаруулж байгаа зөвлөлийн хүмүүст зөв шийдвэр гаргахад нь нөлөөлж байх шиг байгаа юм. Олон нийтийн сүлжээ, багийн хурал зэргээр тайлан мэдээллүүдийг оруулаад байдаг юм. Тооллогоны үеэр явж байгаа ажлын хэсгээр мэдээлэл дамжуулж байгаа юм, хавар мөн татвар хураамж хураах, айлуудаар явах үеэр мэдээлэл өгч байгаа. Ямар мэдээлэл гэхээр сум хөгжүүлэх сангаар энэ жил ийм төслүүд дэмжиж, энэ хүн ийм хэмжээний мөнгийг ийм юм хийнэ гэж авсан гэх мэт. Мэдээллийг аль болох олон хүнд хүргэх буцаад хариуцлага нэхэх юм. Мэдээлэлгүй байвал элдэв хардлага сэрдлэг их байдаг ч юмуу тийм ээ, мэдээлэлтэй хүн оролцоно зөв зүйтэй шийдвэр гарна.

Төлөөлөгчид иргэдийг шийдвэр гаргалтад оролцуулах, иргэдэд мэдээлэл түгээх ажлыг идэвхтэй хийж байгаа талаар дурдаж байна. Ингэхдээ мэдээллийг түгээж ил тод байснаар элдэв хардлагагүй, хяналтын механизм нь үр өгөөжтэй байх талаар дурджээ. Ингэхдээ малчид, ард иргэдэд төрийн ямар нэг төрлийн үйлчилгээг хүргэхдээ танилцуулга материал болон аман байдлаар мэдээллийг байнга хүргэж байх нь чухал талаар дурдаж байна.

Мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүд

ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын үр дүнд олж авсан мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн төлөөлөгчид болон тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүдийг авч үзвэл доорх байдалтай байна.


Зураг 8. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад хамрагдсанаар таны ажлын арга барил өөрчлөгдсөн үү?



Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад хамрагдсанаар тухайн төлөөлөгчийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдлыг асуухад маш их дээшилсэн гэж 31% нь, ер нь дээшилсэн гэж 51% нь, зарим талаар дээшилсэн гэж 15% нь, харин бараг дээшлээгүй гэж 2% нь хариулсан бол нөлөөгүй гэж 2 оролцогч хариулсан байна.


Эдгээрээс дүгнэхэд сургалтын үр дүнд тухайн төлөөлөгчийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдалд оролцогчид дунджаар 82.1 оноо өгчээ.

Зураг 9. Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад хамрагдсанаар таны ажлын арга барил өөрчлөгдсөн үү? /хүйсээр/



Ажлын арга барил өөрчлөгдсөн талаар хүйсээр харьцуулж үзвэл эрэгтэй төлөөлөгчид эмэгтэй төлөөлөгчдөөсөө ялимгүй бага өөрчлөгдсөн гэж өөрсдийгөө үзжээ.

Зураг 10. Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад танай хурлын төлөөлөгчид хамрагдсанаар танай байгууллагын ажилд өөрчлөлт гарсан уу?



Төлөөлөгчид нь тус сургалтад хамрагдсанаар тухайн ИТХ-ын ажил сайжирсан эсэхийг тандахад маш их сайжирсан гэж 19% нь, ер нь сайжирсан гэж 51% нь, зарим талаар сайжирсан гэж 27% нь, бараг сайжраагүй гэж 2% нь, огт сайжраагүй гэж 1% нь нь тус тус хариулсан байна.

Эдгээрээс дүгнэхэд сургалтын үр дүнд тухайн байгууллагын ажил өөрчлөгдсөн байдалд оролцогчид дунджаар 76.8 оноо өгчээ. Үүнийг өмнөх төлөөлөгчийн ур чадвар өөрчлөгдсөн байдалтай нэгтгэн дүгнэвэл 79.45 оноо өгөхөөр байна.

Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын үр дүнд бий болсон хамгийн эерэг болон сөрөг туршлагуудын талаар асуухад давхардсан тоогоор 100 гаруй эерэг, 50 гаруй сөрөг туршлагуудыг дурдсан бөгөөд эдгээрийн багцалвал:

- Орон нутгийн хөгжлийн сангийн талаар мэдээлэлтэй болсон,
- Аливаа зүйлд хууль эрх зүйн үндэслэлээр ханддаг болсон,
- Багаараа ажиллах туршлагатай болсон,
- ИТХ-ын мөн чанар, яах ёстой зэргийг ойлгосон,
- Төлөөлөгчийн бүрэн эрх, эрхээ хэрхэн эдлэх зэргийг мэдэж авсан,
- Төсөвт хянат тавих байдал сайжирсан,
- Хуралдаанд санал гаргах, асуудал оруулах, шийдвэрлэх ур чадвар нэмэгдэж, сайжирсан,
- Шинэ төлөөлөгч нарт маш хэрэгтэй сургалт болсон ... зэрэг эерэг туршлагуудыг дурдсаныг онцлон тэмдэглэх шаардлагатай гэж үзэж байна. Тооны хувьд эерэг санал олон байна.

Шигтгээ 7. Булган аймаг, Баян-Агт сум ярилцлага

Энэ жил болон өнгөрсөн жил ч хийгдсэн **иргэдийн хурлын хяналтын ажлууд** хийгдэнэ.

Жишээ нь, орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлууд дээр, сум хөгжүүлэх сангаас олгосон зээлүүд дээр тэдгээрийн хэрэгжилт ямар байгаа дээр хяналтын баг ажилладаг. Нэг хяналтын баг нь 2-3 ажил дээр ч юмуу. Иргэдийн хурлын дарга шийдвэр, захирамж гаргаад ажилладаг. Жишээ нь Баянхайрхан баг дээр хийгдэж байгаа ажлыг хянахын тулд тус багийн төлөөлөгч болон төвөөс сонгогдсон төлөөлөгч гэх маягаар баг бүрдээд хяналт хийдэг. Төлөөлөгч, тэргүүлэгч

нарын хурал дээр төсвийн байгууллагын худалдан авалттай холбоотой, сургуулийн үдийн цай болон цэцэрлэгийн хүүхдүүдийн гал тогооны худалдан авалттай холбоотой зарлаж байгаа байдал нь буцаад хяналт тавьж байгаа байдал тайлангаас харахад бүрхэг байна гээд иргэдийн хурлаас баг гаргаад ажиллаж байгаа.

Төлөөлөгч нар иргэд, олон нийтэд мэдээлэл, үйл ажиллагааны ил тод байдлыг илүү дэмждэг болсон байна. Мөн сум, орон нутгийн төрийн байгууллагын худалдан авах ажиллагаанд хяналт тавих, түүнд хараат бусаар баг томилж хянах болжээ. Энэ байдал нь мөн Говь-Алтай аймгийн Бугат сумын төлөөлөгчийн ярилцлагад мөн дурдагдаж байсан. Энэ нь бусад сумдууд (Шигтгээ 7)-ын ИТХ-д хэрэгжиж байгаа нь сургалтаас олж авсан ур чадвар, мэдлэг мэдээлэлд тулгуурласан байна гэж дүгнэж болохоор байна.

Шигтгээ 8. Булган аймаг, Бүрэгхангай сум ярилцлага

Хурлын тасралтгүй үйл ажиллагааг хангах хүмүүс бол хурлын тэргүүлэгчид маань байгаа юм. Сургалтад сууснаар энэ түвшний хуралд оролцох тэргүүлэгчдийн идэвхи оролцоо нэмэгдсэн. Оролцохдоо асуудлуудаа **судлах, асуудалд хандах, ач холбогдол өгөх асуудал үндсэндээ нэмэгдсэн**. Дээрээс нь асуудлыг үндэслэлтэй судалж хандах, хуулийн үг хэллэг ашиглах, хэрэгжиж байгаа дүрэм журмыг судлах ийм түвшинд явж байна. Төлөөллийн байгууллага учраас иргэдийн саналыг авах тал дээр иргэдрүү чиглэсэн ажлууд түлхүү хийж хэрэгжүүлж байна гэж харж байна. Иргэдийн хурал маань дотроо бас хороодтой байгаа юм. Хөдөө аж ахуйн байнгын хороо, дэд бүтцийн хороо г.м. Уул уурхайн чиглэлээр манай аймаг тодорхой үйл ажиллагаа явуулдаг байгалийн нөөц баялагтай. Тухайлбал: Бүрэг сумын нутаг дэвсгэр дээр уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байна уу, нийгмийн хариуцлагын хүрээнд хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байна, ус ашигласны татвараа цаг тухайд нь төлж байна уу гэдэг дээр газар дээр нь шалгалт хийгээд хяналт тавих үүргийг зохих байгууллагуудад нь өгөөд ажилласан.

Дэд бүлгийн дүгнэлт

Хүснэгт 3. ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтын ерөнхий үнэлгээ

№	Үзүүлэлтүүд	Үнэлгээ	Оноо
1	Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	83.2	4.3
2	Төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин	81.75	4.05

3	Төлөөлөгчид сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал	78.6	3.9
4	Мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүд	79.45	4.0
	Дундаж үнэлгээ	80.75	4.01

ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтын үр нөлөөг судалгаанд оролцсон оролцогчид 80.75 хувийн үнэлгээ өгсөн байна. 1-5 оноонд шилжүүлж үзвэл 4.01 оноо байна. Үүнийг дотор нь дээрх хүснэгтэд байх 4 үзүүлэлтээр хувааж үзвэл сургалтын сэтгэл ханамжийн түвшин 83.2 хувь, төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин 81.75 хувь, сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдлыг 78.6 хувь, мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүдэд 76.45 хувийн үнэлгээг тус тус өгсөн байна.

Зураг 11. ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтын ерөнхий үнэлгээ



Энэ нь сургалтын агуулга, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь 80 хувь буюу 4 онооноос дээш байгаа боловч түүнийг амьдрал дээр хэрэгжүүлэх тал дээр бага зэрэг учир дутагдалтай байдал ажиглагдаж байна. Мөн ИТХ-ын төлөөлөгч болон олон нийт, иргэдийн идэвх санаачлага сул байна.

Шигтгээ 9. Булган аймаг, Баян-Агт сум ярилцлага

Төлөөлөгч болгонд эхний сургалтыг дагуулаад сумдын ижил түвшний иргэдийн хурлын сайн муу туршлагыг хүн болгон ойлгоход амар байдлаар гарын авлага хийвэл зүгээр санагдсан. Хөдөөний малчид гэхэд л хурлын тал хувийг нь бүрдүүлдэг шүү дээ. Иргэддээ та ямар төрлийн мэдээллийг яаж хүргэвэл зүгээр вэ зэргийг зааварчилсан юм их хэрэгтэй санагдсан. Нутгийн удирдах байгууллагуудын холбоо билүү тэднийхээс жил бүр 6000 төгрөгөөр төлөөлөгч болгоныг захиалаач гээд сэтгүүл гаргадаг. Тэдгээрийг унших үед хэрэгтэй зүйл 20 хуудас материал байлаа гэхэд 1 хуудас л байх жишээтэй. Заавар зөвлөгөө гэхээсээ танилцуулга л байгаад байдаг.

Бүх шатны ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтад хамрагдсан оролцогчид сургалтын талаарх үзүүлэлтүүд болох сургалтын сэтгэл ханамж, заасан мэдлэг ур чадвар түвшин, төлөөлөгчийн дадал, ажлын өөрчлөлтүүд зэрэгт нийтэд нь 80 хувь буюу хангалттай сайн үнэлгээ өгсөн.

ИТХ-ын төлөөлөгч нар 4 жил тутамд солигддог. Солигдох бүрт нь шинэ төлөөлөгчид 50 орчим хувь нь байдаг байна. Шинэ ИТХ бүрдсэн эхний жилдээ дээрх энэ суурь сургалт болохоос өмнө шинэ төлөөлөгч нар эрх, үүргээ мэдэхгүй, хуралдаанд идэвхтэй оролцохгүй, хамтын шийдвэр гаргах ур чадвар дутах явдал их гардаг байна. Харин энэ суурь сургалт нь төлөөлөгч нарт ус, агаар мэт хэрэгтэй бөгөөд тэдний үндсэн ажил болох хуралдаан зохион байгуулах хамтын шийдвэр гаргах ажлыг нь жигдрүүлж өгч чаддаг ажээ.

Чанарын ярилцлагын үр дүнд ч мөн тус сургалтад хамрагдсан төлөөлөгчид маш их сэтгэл хангалуун байсан талаар дурджээ. Төлөөлөгчид суурь сургалтыг явуулсны дараа хуралдах, хуралдаанд асуудал тавих, шийдвэрлэх, төлөөлөгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх чадвар эрс сайжирдаг, тэр бүр нь бусад төлөөлөгч нарт илт мэдрэгддэг байна.

Харин сургалтын үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулж үзвэл оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин буюу зохион байгуулалт, сэдэв, багшийн ур чадвар, хугацаа, гарын авлага болон төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин зэрэгт 80 аас дээш үнэлгээ өгсөн бол төлөөлөгчид сургалтаас авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал болон тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүд зэрэгт 80-аас доош үнэлгээ өгсөн байна.

Үүнээс үзэхэд сургалтыг тасралтгүй цааш үргэлжлүүлэх нь зайлшгүй бөгөөд төлөөлөгч нар солигдоод явна, түүнийг сонгодог иргэд солигдохгүй учир иргэдийн эрх зүйн ухамсар, тэдний идэвх, оролцоог нэмэгдүүлэх нь орон нутгийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд хувь нэмэртэй байна.

1.2 ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран ШХА-ын санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн Хүрэх үр дүн 3-ын хүрээнд ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтыг зохион байгуулахаар 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна.

Орон нутгийн сонгуульт төлөөлөгчдөд зориулсан манлайллын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Их Британийн Нутгийн удирдлагын холбооны мэргэжилтэн Мари Дэвис 2016 онд Монгол Улсад ажиллан нийслэл, дүүрэг, аймаг, сумдын төлөөлөгчидтэй уулзаж манлайллын сургалтын хөтөлбөрийн агуулга, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр сургалтын хөтөлбөр боловсруулсан байна. Ингээд эхний ээлжинд Удирдлагын Академи, нутгийн удирдлагын ТББ-ууд, аймгийн ИТХ-ын сургагч багш нарын бүрэлдэхүүнээс 25 сургагч багш нарыг бэлтгэсэн бол зөвлөх багш Мари Дэвис 2017 оны 5 дугаар сард манай улсад дахин ирж, манлайллын үндэсний сургагч багш нарт давтан сургалт явуулжээ.

Олон улсын зөвлөх Мари Дэвисийн бэлтгэсэн тус сургалтын агуулгад үндэслэн үндэсний сургагч багш нараас бүрдсэн ажлын хэсэг өөрийн улсын онцлогт тааруулан, манлайллын орчин үеийн онол, хандлагад суурилсан, төлөөлөгчийн нийгмийн хүсэн хүлээж байгаа өөрчлөлтийг хийх, уг хүсэл эрмэлзлээ бусдад ойлгуулах, нөлөөлөх чадваруудыг хөгжүүлэх зорилготой сургалтын шинэ агуулгыг ИТХ-ын төлөөлөгчдөд тусгайлан зориулж боловсруулсан байна.

“Төлөөлөгчийн манлайлал” сургалт нь улс төрийн манлайлал, хувийн манлайлал, стратегийн манлайлал, иргэдийг манлайлах гэсэн дөрвөн үндсэн сэдвээс бүрдсэн хоёр өдрийн сургалт байв. Энэ сургалтын хөтөлбөрөөс Төлөөлөгчид өнгөрсөн үеийн сорилт, ололтоосоо үнэт зүйлээ тодруулж, алсын хараагаа тодорхойлох, өөрийн зорилго, ажил үйлсийг бусдад ойлгуулах, тэдний дэмжлэгийг авахын тулд манлайллын цогц түүх бүтээх, ярих, орон нутагт тулгамдаж буй асуудлыг томоор буюу бүтэн зургаар харж, цогцоор шийдэх зэрэг манлайллын орчин үеийн шинэлэг онол хандлагад суурилсан “үйлдэн суралцах” буюу “интерактив” аргаар суралцсан байна.

Түүнчлэн Их Британийн Нутгийн удирдлагын холбооны мэргэжилтэн Мари Дэвис 2017 оны 5 дугаар сард Монгол Улсад ажиллах хугацаандаа аймгийн ИТХ-ын дарга нар, орон нутгийн сургагч багш нар, зарим дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдэд сургалт явуулсан бөгөөд эдгээр сургалтад манлайллын гарын авлагыг боловсруулсан үндэсний 6 сургагч багш хамтран ажиллаж, онолын мэдлэгээ бататгахын зэрэгцээ сургалтын арга зүйн онцлогт суралцаж, дадлага хийсэн байна.

Сургалтад хамрагдсан аймгийн ИТХ-ын дарга нар, дүүргийн ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчид энэхүү сургалтад хамрагдсан гэж тайланд дурдсан боловч тус сургалтад ИТХ-ын ажлын албаны зарим албан хаагчид мөн оролцсон бөгөөд энэхүү үр нөлөөний судалгаанд оролцож санал, бодлоо илэрхийлсэн байв.

Сургалтад оролцсон аймгийн ИТХ-ын дарга нар МУЗЗНДНТУХ болон орон нутгийн эрх ашиг, сонирхлыг хөндсөн хууль, шийдвэрийг өөрчлөхөд орон нутаг дуу хоолойгоо хүргэх хэрэгцээ шаардлага байгааг онцолж, ийм бололцоог бий болгож өгөхийг төслөөс хүсч байсан талаар төслийн мониторингийн тайланд мөн дурдсан байна.

Тусгайлан боловсруулсан Манлайллын хөтөлбөрийн дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн манлайллын сургалтыг 2017 оны 10 болон 11 дүгээр саруудад Улаанбаатар хотод зохион байгуулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн манлайллын сургалтыг 3 аймгийг нэг ээлж болгон нийт 7 ээлжээр зохион байгуулсан байна. Тус сургалтад нийт тэргүүлэгчдийн 80 хувь хамрагдсан байна. Үүнийг аймаг бүрээр задалж доорх хүснэгтэд харуулав. Үүнд:

Хүснэгт 4. ИТХ-ын Тэргүүлэгчдийн манлайллын сургалт зохион байгуулсан хугацаа, оролцогчид /орон нутгаар/

№	Аймаг	Огноо	Тэргүүлэгчдийн тоо	Оролцсон тоо
1	Архангай	2017.11.07-08	11	10
2	Баян-Өлгий	2017.10.26-27	11	11
3	Баянхонгор	2017.11.13-14	11	6
4	Булган	2017.11.09-10	11	11
5	Говь-Алтай	2017.11.13-14	11	10
6	Говьсүмбэр	2017.11.09-10	7	7
7	Дархан-Уул	2017.11.16-17	11	4
8	Дорноговь	2017.10.30-31	11	8
9	Дорнод	2017.11.07-08	11	6
10	Дундговь	2017.10.26-27	11	9
11	Завхан	2017.11.07-08	9	9
12	Орхон	2017.11.16-17	11	10
13	Өвөрхангай	2017.11.13-14	11	8
14	Өмнөговь	2017.10.30-31	11	9
15	Сүхбаатар	2017.11.02-03	11	11
16	Сэлэнгэ	2017.11.16-17	11	9
17	Төв	2017.11.02-03	11	6
18	Увс	2017.10.26-27	11	11
19	Ховд	2017.10.30-31	11	9
20	Хөвсгөл	2017.11.09-10	11	9
21	Хэнтий	2017.11.02-03	11	7
Дүн:			225	180

Энэхүү үр нөлөөний үнэлгээний судалгаанд нийт 681 иргэдийн төлөөлөгчид оролцсоноос 18 хувь буюу 122 нь ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан байв.

Зураг 12. ИТХ-ын Тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчид



Харин дээрх хүснэгтээс үзэхэд ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад нийт 180 хүн хамрагдсан бол энэхүү үр нөлөөний үнэлгээний судалгаанд тэдний 67.8 хувь нь хамрагдсан байна.


ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад тэргүүлэгч биш ИТХ-ын төлөөлөгчид болон ИТХ-ын тамгын газрын зарим албан хаагчид оролцосон бөгөөд судалгааны зарим оролцогчид энэхүү сургалтад суусан эсэх асуултад хариулаагүй эсвэл оролцоогүй гэж хариулсан боловч зарим асуултад хариулсан байгааг энэхүү судалгааны үзүүлэлтүүдэд багтаан харуулсан. Иймд тэдний бөглөсөн хариултууд нэмэгдсэний үр дүнд зарим асуултын хариултын тоо нь 128 хүртэл өссөн болохыг анхаарах нь зүйтэй юм.

Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин

Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшинг сургалтын ерөнхий зохион байгуулалт, сэдвийн ач холбогдол, багшийн ур чадвар, сургалтын хугацаа гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэснийг доорх хэсгээс үзнэ үү.

Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарын талаар 124 хүн хариулт өгсөн бөгөөд оролцогчдын 49.2% нь маш сайн, 50.0% нь сайн, 0.8% нь дунд гэж үнэлсэн бол муу, маш муу гэж хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид зохион байгуулалтыг ерөнхийдөө сайн (88.6% буюу 4.43 оноо) гэж дүгнэжээ.

Зураг 13. Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг үнэлсэн байдал




Харин энэхүү үзүүлэлтийг хүйсээр ангилж үзвэл эмэгтэйчүүд харьцангуй өндөр буюу 87.97 хувиар, харин эрэгтэй төлөөлөгчид бага зэрэг доогуур буюу 87.49 оноо өгч үнэлсэн байна.

Зураг 14. Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг үнэлсэн байдал /хүйсээр/



Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдлыг 47.6% нь маш сайн, 46.8% нь сайн, 5.6% нь дунд гэж үнэлсэн бол 1.6% нь муу гэж хариулсан, харин маш муу гэж хариулсан оролцогч байхгүй байв. Сургалтад хамрагдсан оролцогчид сэдвийн ач холбогдлыг ерөнхийд нь сайн (87.6% буюу 4.38 оноо) гэж үнэлсэн байна.

Зураг 15. Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдал




Багшийн ур чадвар, заах арга зүйг 46.1% нь маш сайн, 48.4% нь сайн, 3.1% нь дунд гэж үнэлсэн бол 0.8% нь муу, маш муу гэж хариулсан оролцогч байхгүй байв. Сургалтад хамрагдсан оролцогчид багшийн ур чадварыг ерөнхийд нь сайн (88.4% буюу 4.42 оноо) гэж үнэлсэн байна.

Шигтгээ 10. Говь-Алтай аймаг, Шарга сум ярилцлага


Мэдлэгийн хувьд 3 багшийг дүгнэвэл харьцангуй туршлагатай зааж байгаа хичээл нь амьдралд тохиолддог бодит практикаас жишээ татаж бидэнд ойлгомжтой байдлаар тайлбарлах тал дээр тун давгүй байсан гэж үзэж байгаа. Заах аргын хувьд миний хувьд олон сургалтан дээр сургаагч багш хийж байсан үүн дээрээ ч бодоод үзэхэд аль нэг идэвхитэй хэсэг нь оролцоод бусад нь хараад байдаг биш бүгдийг хамруулж, оролцуулж байсан нь оролцооны аргыг сайн хэрэглэсэн гэж үзэхэд хүргэж байгаа юм. Сэдвүүдийг тайлбарлахдаа амьдралтай холбоод онолын мэдлэгийг зөв сайхан олгож байсан гэж үзэж байгаа.

Зураг 16. Багшийн ур чадвар, заах арга зүй



Сургалт зохион байгуулсан цаг үе болон, сургалт үргэлжилсэн хугацааг 42.2% нь маш тохиромжтой, 46.1% нь тохиромжтой, 8.6% нь боломжийн гэж үнэлсэн бол 1.6% нь тохиромжгүй гэж үнэлсэн бол маш тохиромжгүй гэж хариулсан оролцогч байхгүй байв. Сургалтад хамрагдсан оролцогчид сургалтын цаг, хугацааны оновчтой байдлыг ерөнхийд нь сайн (86.2% буюу 4.31 оноо) гэж үнэлсэн байна.

Зураг 17. Сургалтын хугацааны тохиромжтой байдал




Шигтгээ 11. Сүхбаатар аймаг, Мөнххаан сум ярилцлага

Нөгөө талаас болж өгвөл дахиад суух юмсан гэсэн сэтгэгдэл төрж байсан. Сургалт үргэлжлэх хугацаа бол харин ч богино хугацаанд их мэдээлэл агуулсан сургалт болсон гэж бодож байгаа. Нийт 2 өдөр сургалтанд суусан, энийг мэдчих юмсан энийг л асуучих юмсан гэхээр зүйл их байсан тийм ч учраас 2 хоногийн сургалтын хугацаа тун боломжийн л байсан гэж үзэж байгаа. Зохион байгуулсан цаг хугацаа нь аливаа тайлан ч юм уу мал төллөлтийн цагтай давхцаагүй. Учир нь төлөөлөгчдөөс урьдчилан санал авч төлөвлөсөн байсан.

Сургалтын гарын авлага, тараах материалын чанарыг 45.3% нь маш сайн, 46.9% нь сайн, 3.9% нь дунд гэж үнэлсэн бол 1.6% нь муу гэж үнэлсэн бол маш муу гэж хариулсан оролцогч байхгүй байв. Сургалтад хамрагдсан оролцогчид Сургалтын гарын авлага, тараах материалын чанарыг ерөнхийд нь сайн (87.8% буюу 4.39 оноо) гэж үнэлжээ.

Зураг 18. Сургалтын гарын авлага, тараах материалын чанар




Шигтгээ 11. Төв аймаг, Зуунмод сум ярилцлага

Сургалтанд суусан хүмүүстээ гарын авлага бас өгсөн, сургалтан дээр үзсэн юмаа хурлын явцад, асуудлыг хэлэлцэж байх үедээ, хэлэлцүүлээд гаргасан шийдвэрээ иргэддээ танилцуулах үедээ, иргэдийн тулгамдаж байгаа асуудлыг гаргаж ирж асуудал гаргаж тавих үедээ гээд сургалтынхаа мэдлэгийг их бага хэмжээгээр ашиглаж байгаа. Нөгөө талаас аль болох ашиглах гэж бодсон ч гэлээ хүн ганцхан удаа сонссон юмаа шууд хэрэгжүүлчихнэ гэхээр боломж муутай. Ямар ч байсан оролдож байгаа, хэрэглэж хэвшиж байгаа яг 100 хувь бол хэрэгжүүлж хараахан чадахгүй байна.

Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшинг дүгнэвэл оролцогчид сургалтын гарын авлага, тараах материалын чанарт хамгийн өндөр (88.6%), сургалтын хугацааны тохиромжтой байдалд харьцангуй өндөр (88.4%), багшийн ур чадварт дундаж (87.8%), заасан сэдвийн ач холбогдолд харьцангуй бага (87.6%), харин сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарт хамгийн бага (86.2%) үнэлгээ өгсөн байв.

Эдгээр үзүүлэлтүүдийг ерөнхийд нь харьцуулан доорх зурагт харууллаа. Үүнд:

Зураг 19. ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан Манлайллын сургалтын оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин /үзүүлэлт бүрээр/



Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшинг сургалтын ерөнхий зохион байгуулалт, сэдвийн ач холбогдол, багшийн ур чадвар, сургалтын хугацаа гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэж, тус бүрд нь оноо тавьж дээрх хэсэгт харьцуулан харуулсан билээ. Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл оролцогчдын ерөнхий сэтгэл ханамж 87.7% буюу 4.39 оноо байна. Үүнээс үзэхэд сургалтын зохион байгуулалтад төлөөлөгчид сэтгэл ханамж өндөр байсан гэж үзэж байна. Сэтгэл ханамж өндөр байсан талаар чанарын ярилцлагад хамрагдсан оролцогчид ч хэлж байсан юм.

Шигтгээ 12. Булган, Булган сум ярилцлага

Би 3 удаагийн сургалтанд суусан, үнэхээр өөрсдөөсөө манлайллыг эхлэх ёстой гэдэг үүднээсээ ч юмуу хүмүүсийн идэвхи, цаг баримтлах, сургалтын зохион байгуулалт, дүрмээ өөрсдөөр нь батлуулаад, завсарлагаанаас эхлээд бүх зүйл яг л цагийн хуваарийн дагуу байсан. Оролцогчдын тоо хичээл хийдүүлэх тийм асуудал байгаагүй ирсэн бүх хүмүүс жигд сайн сургалтандаа оролцож байсан. Техник хангамжийн хувьд ч бас сургалтын чанарт эерэг үр нөлөөтэй байсан гэж үзэж байна.

Төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин

Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчдоос тус сургалтаас олж авсан мэдлэг, ур чадварыг нь өөрсдөөр нь үнэлүүлэхэд маш хангалттай гэж 39.1%, ер нь хангалттай гэж 50.8%, дундаж гэж 8.6%, ер нь хангалтгүй гэж 1.6% нь тус тус үнэлсэн бол хангалтгүй гэж хариулсан оролцогч байхгүй байлаа. Үүнийг дүгнэж үзвэл оролцогчид өөрийн олж авсан мэдлэг, ур


чадвартаа дунджаар 85.5% буюу 4.27 оноо өгсөн байна. Үүний зургаар харуулбал доорх байдалтай байна. Үүнд:

Зураг 20. Төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авч чадсан байдал



Төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авч чадсан байдлыг эмэгтэйчүүд 84.3 хувиар, эрэгтэй төлөөлөгчид 86.7 орчим хувиар үнэлсэн нь ойролцоо үзүүлэлт байлаа. Үүнийг харьцуулан доорх зурагт харуулав. Үүнд:

Зураг 21. Төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авч чадсан байдал



Харин тус сургалтад оролцсон төлөөлөгчдийн мэдлэг, ур чадвар дараах чиглэлд хэрхэн дээшилсэн эсэхийг тодруулахад оролцогчдоос төлөөлөгчийн үүргээ гүйцэтгэхдээ манлайллын арга барилуудыг ашиглах чадвар дээшилсэн байдалд 87.1% буюу 4.36 оноо, иргэдийн амьдралд хэрэгтэй байгаа өөрчлөлтийг олж харах чадвар дээшилсэн байдалд 88.2% буюу 4.41 оноо, өөрийнхөө үзэл бодол, байр суурийг бусдад ойлгуулах чадвар дээшилсэн байдалд 87.1% буюу 4.36 оноог, харин өөрчлөлтийг бий болгохын төлөө бусдад нөлөөлөх, тууштай ажиллах чадвар


дээшилсэн байдалд 86.6% буюу 4.33 оноог тус тус өгч үнэлсэн байна. Үүнийг зургаар харьцуулан харуулбал доорх байдалтай байна. Үүнд:

Зураг 22. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр дүнд тэргүүлэгчдийн мэдлэг, ур чадвар дээшилсэн байдалд өгсөн үнэлгээ /үзүүлэлт тус бүрээр/



Эдгээр үзүүлэлтийн дэлгэрэнгүй үнэлгээг доорх графикт харьцуулан харуулав. Үүнд:

Зураг 23. Төлөөлөгчдийн мэдлэг, ур чадвар тодорхой чиглэлд дээшилсэн байдал



Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл төлөөлөгчид тодорхой чиглэлээр мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байдлаа дунджаар сайн (87.3% буюу 4.36 оноо) гэж дүгнэсэн байна.


Шигтгээ 13. Сүхбаатар аймаг, Уулбаян сум ярилцлага

Ажлын хороод дүгнэлт гаргадаг болсон. Түүнчлэн багаар ажиллах чадамж нэмэгдэж, тэргүүлэгчдийн хуралд орох асуудлаа бодлогын хороодоороо хэлэлцүүлж дүгнэлт гаргадаг болсон. Тэргүүлэгчдийн идэвх оролцоо нэмэгдсэн, ил тод байх болон илтгэх чадвар, өөрийн үзэл бодлоо бусад илэрхийлэх чадвар сайжирсан, иргэдийн оролцоог хангах болон иргэдийн төлөөллийг хэрхэн төлөөлөх талаар илүү туршлага мэдлэгтэй болсон. Ялангуяа иргэдтэй ажиллах арга барилаа өөрчилж, харах хүрээгээ тэлсэн нь ажилд сайнаар нөлөөлсөн.

Төлөөлөгчид олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал

Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчдоос тус сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа өдөр тутам ашиглаж байгаа гэж 37.5%, ихэвчлэн ашигладаг гэж 46.9%, заримдаа ашигладаг гэж 14.1%, бараг ашигладаггүй гэж 1.6% нь хариулсан бол ашигладаггүй гэж хариулсан оролцогч байхгүй байна. Үүнийг зургаар харуулбал доорх байдалтай байна. Үүнд:


Зураг 24. ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтаас сурсан мэдлэг, чадвараа ашиглаж байгаа байдал



Эдгээрээс үзэхэд сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдлаа оролцогчид дунджаар 84.1% буюу 4.20 оноогоор үнэлсэн байна.

Энэ үзүүлэлтийг хүйсээр ангилж үзвэл эмэгтэйчүүд арай доогуур буюу 84.01 хувиар, эрэгтэй төлөөлөгчид 2 орчим хувиар өндөр буюу 84.2 хувиар үнэлсэн нь бараг ижил үзүүлэлт байлаа. Үүнийг доорх зурагт харьцуулан харуулав. Үүнд:

Зураг 25. ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтаас сурсан мэдлэг, чадвараа ашиглаж байгаа байдал /хүйсээр/



Шигтгээ 14. Төв аймаг Лүн сум ярилцлага


Сургалтанд суугаад бид төлөөлөгчдийг харж байсан, төлөөлөгч болохоос өмнө суучихсан бол би аль эрт үүнийг хийчих байсан шүү дээ гэж ярьж байсан хүн бий, ёстой гоё сайхан сургалтанд суулаа, яг ийм л юм дутаад байсан юмаа тэр үед энийг мэдээд ингээд ажиллачихсан бол гэсэн ийм зүйлс сонсогдож байлаа. Миний хувьд бол тэр сургалтанд сууснаар хэдийгээр 2 сонгогдоод, аймгийн төлөөлөгч болоод иргэдийн асуудлыг сонсоод явж байсан ч гэсэн сонгогчидтойгоо ажиллаад, мэдээлэл хүргэх тал дээр учир дутагдалтай байгаад байсан. Иргэдэд тулгамдаж байгаа асуудлыг яаж оновчтойгоор тодорхойлж ямар гүүр шат дамжлагаар шийдэж болох тал дээр хүмүүсийн жишээн дээр туршлага, мэдээлэл хуримтлуулж хэлэлцүүлэг хийх, иргэний танхимаар дамжуулж хэлэлцүүлээд гэх мэт энэ бүх юм яг л энэ сургалтаас олж авсан мэдээлэл дээр тулгуурласан л гэж бодож байгаа.

Мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүд

ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр дүнд олж авсан мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн төлөөлөгчид болон тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүдийг авч үзвэл доорх байдалтай байна.

ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар тухайн төлөөлөгчийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдлыг асуухад маш их дээшилсэн гэж 34.4%, ер нь дээшилсэн гэж 49.2%, зарим талаар дээшилсэн гэж 14.8%, харин бараг дээшлээгүй гэж 1.6% нь хариулсан бол огт дээшлээгүй гэж хариулсан оролцогч байхгүй байна. Үүнийг зургаар харуулбал доорх байдалтай байна. Үүнд:


Зураг 26. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар төлөөлөгчдийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдал



Эдгээрээс дүгнэхэд сургалтын үр дүнд тухайн төлөөлөгчийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдалд оролцогчид дунджаар 83.3% буюу 4.16 оноо өгчээ.

Харин энэ үзүүлэлтийг хүйсээр ангилж үзэхэд эрэгтэйчүүд ажлын арга барил өөрчлөгдсөн байдлыг эрэгтэй болон эмэгтэй төлөөлөгчид харьцангуй өөр өөр үнэлсэн байна. Тодорхой хэлбэл эрэгтэй төлөөлөгчид илүү доогуур буюу 76.9 орчим хувиар үнэлсэн бол эмэгтэйчүүд тэднээс 13 орчим оноогоор өндөр буюу 89.7 оноогоор үнэлжээ. Үүнээс ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар эмэгтэй төлөөлөгчдийн ажлын арга барил илүү өөрчлөгдөн сайжирсан гэсэн дүгнэлтэд хүрч байна. Үүнийг доорх зурагт харьцуулан харуулав. Үүнд:

Зураг 27. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар эмэгтэй төлөөлөгчдийн ажлын арга барил илүү өөрчлөгдөн сайжирсан байдал /хүйсээр/



ИТХ-ын тэргүүлэгчид нь тус сургалтад хамрагдсанаар тухайн ИТХ-ын ажил сайжирсан эсэхийг тандахад маш их сайжирсан гэж 29.6%, ер нь сайжирсан гэж 49.6%, зарим талаар сайжирсан гэж 17.6%, бараг сайжраагүй гэж 2.4% нь тус тус хариулсан бол огт сайжраагүй гэж 0.8% нь хариулсан байлаа. Үүнийг зургаар харуулбал доорх байдалтай байна. Үүнд:


Зураг 28. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар тухайн хурлын ажил сайжирсан байдал



Эдгээрээс үзэхэд тус сургалтад хамрагдсанаар тухайн ИТХ-ын ажил сайжирсан байдалд оролцогчид 81.0% буюу 4.05 оноо өгч дүгнэсэн байна.

Дээрх үзүүлэлтийг хүйсээр ангилж харвал ИТХ-ын эрэгтэй төлөөлөгчид хурлын ажил сайжирсан байдалд 82.3 оноог өгч үнэлсэн бол эмэгтэйчүүд үүнээс бага зэрэг доогуур буюу 79.6 оноог өгч дүгнэсэн байна. Үүнээс тус сургалтын үр дүнд хурлын ажил сайжирсан байдалд эмэгтэйчүүд сэтгэл ханамж арай доогуур байгаа нь харагдаж байна. Үүнийг доорх зурагт харьцуулан харуулав. Үүнд:

Зураг 29. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар тухайн хурлын ажил сайжирсан байдал /хүйсээр/



Харин ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр дүнд бий болсон хамгийн эерэг болон сөрөг туршлагуудын талаар асуухад тус сургалтад хамрагдсан төлөөлөгчдийн зүгээс

- ИТХ-д идэвхтэй оролцох хандлага сайжирсан,
- Төлөөлөгчид бид бусдыг хошуучлагч болохоо сайн ойлгодог болсон,
- Асуудлыг зөв оновчтой тодорхойлдог болсон, тэргүүлэгчид бүгд хамтарч нэг үзэл бодолтой болсон,
- Тэргүүлэгчдийн ажил үүргийн хуваарьтай болсон, тэргүүлэгчдийн ажил хариуцах чадвар дээшилсэн гэж үзэж байна, тэргүүлэгчдийн оролцоог нэмэгдүүлж чадсан,
- Тэргүүлэгчдийн хурлын үр нөлөө сайжирсан, тэргүүлэгчдийн хурлын дэгтэй болсон,
- Тэргүүлэгчдийн хурлын ирц мэдэгдэхүйц дээшилсэн, тэргүүлэгчийн хурлын чанар дээшилсэн, хурлын шийдвэр илүү оновчтой болсон зэрэг эерэг хариултуудыг өгсөн байлаа.

Дэд бүлгийн дүгнэлт

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран ШХА-ын санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн Хүрэх үр дүн 3-ын хүрээнд 2017 онд ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд зориулан зохион байгуулсан манлайллын сургалтын үр нөлөөг судалгаанд оролцогчид хэрхэн дүгнэснийг доор хүснэгтэд нэгтгэн харууллаа. Үүнд:

Хүснэгт 5. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын ерөнхий үнэлгээ

№	Үзүүлэлтүүд	Үнэлгээ	Оноо
1	Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	87.7	4.39
2	Төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин	87.3	4.36
3	Төлөөлөгчид сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал	84.1	4.2
4	Мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүд	81.0	4.05
Дундаж үнэлгээ		85.0	4.25

Оролцогчдын өгсөн үнэлгээг үзүүлэлт тус бүрээр ангилан хамгийн өндөр үнэлсэн үзүүлэлтээс хамгийн доогуур үнэлсэн үзүүлэлтээр жагсааж доорх графикт харуулав. Үүнд:

Зураг 30. ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан Манлайллын сургалтыг үнэлсэн байдал /Үзүүлэлт бүрээр/



Үүнээс үзэхэд ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчид сургалтын ерөнхий зохион байгуулалт, сэдвийн ач холбогдол, багшийн ур чадвар болон сургалтын хугацааны тохиромжтой байдалд сэтгэл ханамж өндөр байсан бөгөөд тус сургалтаар заасан мэдлэг ур чадварыг өндөр түвшинд эзэмшсэн байна. Харин төлөөлөгчид сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж чадсан байдлаа харьцангуй доогуур буюу 84.1%-иар үнэлсэн бол сурсан мэдлэг, ур чадвараа ашиглан өөрчлөлт гаргасан байдалдаа хамгийн доогуур үнэлгээ өгсөн байна. Гэвч энэхүү сургалтын үр нөлөөг тодорхойлсон дээрх үзүүлэлтүүд бүгд 80-аас дээш хувьтай, дундаж үзүүлэлт нь 85 хувьтай үнэлэгдсэнээс үзэхэд тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө хангалттай сайн гэж дүгнэж байна.

Чанарын ярилцлагын үр дүнд ч мөн тус сургалтад хамрагдсан төлөөлөгчид маш сэтгэл хангалуун байсан талаар хэлсэн бөгөөд ярилцлагын судалгаа авсан судлаачдын ажигласнаар ИТХ-ын тэргүүлэгчдэд, түүний дотор хурлын дарга нарт энэхүү сургалтын үр нөлөө илүү мэдрэгдсэн байна. Тухайлбал нэгэн аймгийн ИТХ-ын дарга “Хурлын тэргүүлэгчид өөрсдөө илүү идэвхтэй болсноор хурлын ирц, хэлэлцэх асуудлын оновчтой байдал зэрэг миний санаа зовох асуудал багассан гэж хэлж болно. Би өөрөө ч төлөөлөгчдийг хэрхэн манлайлж ажиллах ёстойгоо ойлгосон нь энэ сургалтын давуу тал байсан” гэж хэлсэн байна. Иймд ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалт нь зорилтот бүлэгтээ бодит байдлаар хүрч, ИТХ-ын төлөөлөгчдийн дунд манлайллын ур чадварыг илүү ашиглах шаардлагатай

тэргүүлэгчид болон хурлын дарга нарын шаардлагатай ур чадварыг хөгжүүлэхэд үндэслэл бүхий дэмжлэг болж чадсан гэж дүгнэж байна.

Харин энэхүү сургалтын үр нөлөөнд өгсөн ерөнхий үнэлгээг хүйсээр ангилж үзвэл ИТХ-ын эрэгтэй төлөөлөгчид 84.1 хувиар үнэлсэн бол эмэгтэйчүүд 85.9 хувийн үнэлгээ өгч дүгнэсэн байна. Үүнээс ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалт нь эмэгтэйчүүдийн хувьд бага зэрэг илүү үр нөлөөтэй байсан нь харагдаж байна. Мөн судалгааны явцад Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтад суугаагүй боловч тэргүүлэгчдэд зориулсан энэхүү манлайллын сургалтад суусан зарим орон нутгийн эмэгтэй төлөөлөгчдийн хамтран ажиллах чадвар сайжирсан нь сургалтын үр нөлөө өндөр байсныг илэрхийлж чадах эерэг үр дүн болохыг энд дурдах нь зүйтэй байна.

Цаашид энэхүү сургалтыг хэрхэн сайжруулах талаар судалгаанд оролцогчдоос санал бараг ирээгүй бөгөөд сургалтыг ойрхон давтамжтай явуулах, дахин зохион байгуулах, байнга буюу тогтмол явуулж байх хэрэгтэй гэсэн саналууд хамгийн олон байлаа. Харин ярилцлагын судалгааны үр дүнгээс үзэхэд Сүхбаатар аймаг, Баянзүрх дүүрэг зэрэг улс төрийн намууд ойролцоо хувиар сонгогдсон орон нутгийн ИТХ-ын тэргүүлэгчид солигдох, хоорондоо хамтран ажиллахгүй байх зэрэг улс төрийн шалтгаантай сөрөг нөхцөл байдал үүссэн тохиолдол цөөнгүй байна.

Цаашид сургалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр төлөөлөгчдийн манлайллын сургалтаас сурсан мэдлэг, чадвараа ашиглан өөрчлөлт гаргасан байдлыг төлөөлөгчид олгох урамшууллын тогтолцоонд багтааж, төлөөлөгчийн ажлын үнэлгээнд тухайн сургалтад хамрагдсан байдлыг мөн оруулан тооцох байдлаар ажиллах нь зүйтэй гэсэн саналыг судалгааны зарим оролцогчид өгсөн байв.

1.3 Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө

Орон нутгийн сонгуулиар 2016 онд бүх шатны ИТХ-д сонгогдсон нийт 2164 эмэгтэй төлөөлөгчийн 59.8% нь анх удаагаа сонгогдсон шинэ төлөөлөгч байжээ. Иймд эдгээр төлөөлөгчдөд тус сургалтыг дахин явуулах хэрэгцээ шаардлага тавигдсан байна. Иймд сургалтын агуулгыг шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, өмнө нь сургалтад хамрагдсан оролцогчдын саналд үндэслэн дахин боловсруулах ажлыг зохион байгуулжээ³. Үүний үр дүнд 2018 (2019) онд “Эмэгтэй төлөөлөгчийн манлайллын сургалтын хөтөлбөр, агуулга өмнөхөөсөө бүрэн шинэчлэгдэж, зохион байгуулагдсанаар аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид


³ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлаг, “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл, 2017 оны Үйл ажиллагааны тайлан.

тойргийн сонгогчидтойгоо илүү ойр ажиллах, иргэдийн оролцооны чиглэлийн хууль тогтоомжийг үр дүнтэй ашиглах, орон нутагт тулгамдсан асуудлыг тодорхойлох, шийдлийг олох, эдгээр зорилгын үүднээс бие биенээ дэмжиж хамтран ажиллах сэдэл, чадварыг олж авч чадсан гэж тус хөтөлбөрийн тайланд дурдсан байна⁴.

Түүнчлэн төслийн хүрээнд зохион байгуулсан эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалт бусад төрлийн сургалтуудаас оролцогчдын үнэлгээ хамгийн өндөр гарсныг дор дурдах манай тоон судалгааны үзүүлэлтүүдээс харж болхоор байна. Эмэгтэй манлайлагчийг бэлдэх, хамтын ажиллагааг өрнүүлэхэд тус төслийн хүрээнд зохион байгуулсан ажлыг сайн туршлага хэмээн онцолж, Улаанбаатар хотод 2018 оны 9 дүгээр сард болсон “Азийн улсуудын сайн засаглалыг бэхжүүлэх нь” олон улсын хуралд танилцуулга хийхээр уригдсан нь төсөлд өгч байгаа бас нэг өндөр үнэлгээ гэж харж байна.

Дээрх дүгнэлт бидний судалгааны ажлын үр дүнгээр батлагдсан гэж хэлж болно. Энэ удаагийн үр нөлөөний судалгаанд оролцсон нийт 681 төлөөлөгчдийн 110 буюу 16.2 хувь нь эмэгтэйчүүдийн манлайллын сургалтад хамрагдсан байна.

Зураг 31. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчид



Сургалтын үр нөлөөг дүгнэхдээ доорх дэд хэсгүүдэд ангилан үзлээ. Үүнд:


Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин

Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшинг сургалтын ерөнхий зохион байгуулалт, сэдвийн ач холбогдол болон хэрэгжүүлэх боломжтой байдал, багшийн үр чадвар,

⁴ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлаг, “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл, 2018 оны Үйл ажиллагааны тайлан.


сургалтын хугацаа, сургалтын гарын авлага тараах материалын чанар, хэрэгцээтэй байдал гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэснийг доорх хэсгээс үзнэ үү.

Зураг 32. Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг үнэлсэн байдал




Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг оролцогчдын 60.5% нь маш сайн, 31.5% нь сайн, 8.1% нь дунд гэж хариулсан бол муу болон маш муу гэж хариулсан оролцогч байхгүй байв. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид зохион байгуулалтыг ерөнхийдөө сайн (91.2% буюу 4.56 оноо) гэж дүгнэжээ.

Зураг 33. Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдал




Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдлыг оролцогчдын 66.9% нь маш сайн, 22% нь сайн, 10.2% дунд, 0.8% нь муу гэж үнэлсэн бол маш муу гэж хариулсан оролцогч байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдлыг ерөнхийдөө сайн (91.8% буюу 4.59 оноо) гэж үнэлжээ.

Зураг 34. Багшийн ур чадвар, заах арга зүй




Багшийн ур чадвар, заах арга зүйг оролцогчдын 66.1% нь маш сайн, 26.6% нь сайн, 7.3% дунд гэж үнэлсэн бол муу болон маш муу гэж хариулсан оролцогч байхгүй байв. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид багшийн ур чадвар, заах арга зүйн чадварыг ерөнхийдөө сайн (90.9% буюу 4.54 оноо) гэж үнэлсэн байна.

Зураг 35. Сургалтын хугацааны тохиромжтой байдал



Сургалт зохион байгуулсан цаг үе болон, сургалт үргэлжилсэн хугацааг оролцогчдын 59.2% нь маш тохиромжтой байсан, 37% нь тохиромжтой байсан, 3.2% нь боломжийн гэж үнэлсэн бол тохиромжгүй гэж хариулсан оролцогч байгаагүй юм. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид сургалт зохион байгуулсан цаг үе болон сургалтын үргэлжлэх хугацааг ерөнхийдөө сайн (90.5% буюу 4.52 оноо) гэж үнэлжээ.

Зураг 36. Сургалтын гарын авлага, тараах материалын чанар




Сургалтын гарын авлага, тараах материалын чанарыг оролцогчдын 59.2% нь маш сайн, 36% нь сайн, 4.8% дунд гэж үнэлсэн бол муу, маш муу гэж хариулсан оролцогч байхгүй байв. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид сургалтын гарын авлага, тараах материалын чанарыг ерөнхийдөө сайн (91% буюу 4.55 оноо) гэж үнэлсэн байна.

Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчдын сэтгэл ханамжийн түвшинг дүгнэн үзэхэд сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдалд хамгийн өндөр (91.8%), сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанар (91.2%) болон сургалтын гарын авлага, тараах материалын чанар, ойлгомжтой байдалд харьцангуй өндөр (91.0%), багшийн заах арга зүйн ур чадварт боломжийн сайн (90.9%), харин сургалтын хугацааны тохиромжтой байдалд (90.5%) бусад үзүүлэлтээс хамгийн бага боловч боломжийн өндөр түвшинд үнэлсэн байна.

Дээрх үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулан дараах зурагт харуулав. Үүнд:

Зураг 37. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин /Үзүүлэлт бүрээр/




Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшинг сургалтын ерөнхий зохион байгуулалт, сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдал, багшийн ур чадвар, сургалтын хугацааны тохиромжтой байдал, сургалтын гарын авлага, тараах материалын чанар гэсэн үзүүлэлтүүдээр нэгтгэн дүгнэвэл оролцогчдын ерөнхий сэтгэл ханамж сайн 91.1% буюу 4.55 оноо байна.

Төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин

Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан оролцогчдоос сургалтаас олж авсан мэдлэг, ур чадварыг өөрсдөөр нь үнэлүүлэхэд маш хангалттай гэж 65%, ер нь хангалттай гэж 29%, дундаж гэж 6% нь хариулсан бол хангалтгүй, маш хангалтгүй гэсэн үнэлгээг өгөөгүй байна. Үүнийг дүгнэж үзвэл оролцогчид өөрийн олж авсан мэдлэг, ур чадвартаа дунджаар 91.7 хувь буюу 4.59 оноо өгсөн байна. Үүний зургаар харуулбал доорх байдалтай байна. Үүнд:


Зураг 38. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авсан байдал



Түүнчлэн тус сургалтад оролцсон эмэгтэй төлөөлөгчдийн мэдлэг, ур чадвар дараах чиглэлд хэрхэн дээшилсэн эсэхийг тодруулав. Үүнд:


Тойргийн сонгогчидтойгоо илүү ойр ажиллах чадвар дээшилсэн байдалд 92.9% буюу 4.65 оноо, орон нутагт тулгамдсан асуудлыг жендэрийн мэдрэмжтэй тодорхойлох чадвар дээшилсэн байдалд 90.4% буюу 4.52 оноо, эмэгтэй төлөөлөгчид бие биенээ дэмжин, хамтран ажиллах чадвар нэмэгдсэн байдалд 90.1% буюу 4.5 оноогоор үнэлсэн бол эмэгтэйчүүдийн оролцооны чиглэлийн хууль тогтоомжийг үр дүнтэй ашиглах чадвар дээшилсэн байдалд 89.8% буюу 4.49 оноог тус тус өгч үнэлсэн байна. Үүнийг дараах зурагт харуулав.

Зураг 39. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын үр дүнд эмэгтэй төлөөлөгчдийн мэдлэг, ур чадвар дээшилсэн байдалд өгсөн үнэлгээ /үзүүлэлт тус бүрээр/



Энэхүү графикт үзүүлсэн үзүүлэлтийн дэлгэрэнгүйг доорх графикт харуулав.
Үүнд:

Зураг 40. Эмэгтэй төлөөлөгчдийн мэдлэг, ур чадвар тодорхой чиглэлд дээшилсэн байдал




Дээрх үзүүлэлт тус бүрт өгсөн үнэлгээг нэгтгэн дүгнэвэл эмэгтэй төлөөлөгчид тус сургалтад суусан сэтгэл ханамжаа дунджаар 90.8% буюу 4.54 оноогоор үнэлсэн байна.

Төлөөлөгчид сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал

Эмэгтэйчүүдийн манлайлал сургалтад хамрагдсан оролцогчдоос тус сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа өдөр тутам ашиглаж байгаа гэж 67%, ихэвчлэн ашигладаг гэж 18%, заримдаа ашигладаг гэж 12%, бараг ашигладаггүй гэж 3% гэж тус тус хариулсан бол огт ашигладаггүй гэж хариулсан оролцогч байхгүй байв.

Үүнийг доорх зурагт харуулав. Үүнд:

Зураг 41. Эмэгтэй төлөөлөгчид манлайллын сургалтаас олж авсан мэдлэг, ур чадварыг ашиглаж байгаа байдал




Үүнээс үзэхэд сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдлаа оролцогчид дунджаар 89.7% буюу 4.5 оноогоор үнэлсэн байна.

Мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүд

Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтын үр дүнд олж авсан мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн төлөөлөгчид болон тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүдийг авч үзвэл доорх байдалтай байна.

Энэхүү сургалтад хамрагдсанаар тухайн төлөөлөгчийн хувьд ажлын арга барил өөрчлөгдсөн байдлыг асуухад маш их дээшилсэн гэж 65%, ер нь дээшилсэн гэж 29%, зарим талаар дээшилсэн гэж 6% нь хариулсан бол бараг дээшлээгүй эсхүл огт дээшлээгүй гэж хариулсан оролцогч байхгүй байв. Үүнийг зургаар харуулбал доорх байдалтай байна. Үүнд:


Зураг 42. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар төлөөлөгчдийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдал



Дээрх зургаас дүгнэхэд сургалтын үр дүнд эмэгтэй төлөөлөгчдийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдалд оролцогчид дунджаар 87.6% буюу 4.38 оноо өгсөн байна.

Эмэгтэй төлөөлөгчид нь тус сургалтад хамрагдсанаар тухайн ИТХ-ын ажил сайжирсан эсэхийг тандахад маш их сайжирсан гэж 54%, ер нь сайжирсан гэж 31.7%, зарим талаар сайжирсан гэж 11%, бараг сайжраагүй гэж 2.4%, харин огт сайжраагүй гэж 0.8% нь хариулсан байлаа. Үүнийг доорх зурагт харуулав. Үүнд:

Зураг 43. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар тухайн хурлын ажил сайжирсан байдал



Эдгээрээс дүгнэхэд сургалтын үр дүнд тухайн хурлын ажил сайжирсан байдалд оролцогчид дунджаар 87.1% буюу 4.4 оноо өгчээ.

Төслийн баримт бичигт⁵ сонгуульт албан тушаал хашиж буй эмэгтэйчүүд орон нутагтаа болон ИТХ-д манлайлж ажиллах, сонгуульд өрсөлдөх, орон нутагт тулгарч

⁵ **ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ**

буй асуудалд нэгдсэн шийдэл олох, ИТХ-ын шийдвэрт нөлөөлөх чадварыг нь дээшлүүлэх, ИТХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийн тулд манлайллын сургалтыг үргэлжлүүлнэ гэж заасан нь 2018 онд ашигласан сургалтын шинэчилсэн хөтөлбөрт тусгалаа олсон ба энэ нь эргээд амьдралд бодитоор хэрэгжих нөхцөлийг илүү бүрдүүлсэн байна.

Тухайлбал, “Говь-Алтай аймгийн Алтай сумын ИТХ-ын дэргэд “Эмэгтэйчүүдийн манлайллын клуб” байгуулагдаж эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулжээ. Орон нутгийн зорилтот бүлгүүдийг дэмжих зорилгоор Сайн үйлсийн аян зохион байгуулж, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар сонсгол хийхээр төлөвлөж байна. Булган аймгийн Рашаант сумын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид өмнө нь намын харьяаллаасаа шалтгаалан хамтран ажилладаггүй байсан бол сургалтын дараа сумын эмэгтэйчүүдийн баярын хурал, арга хэмжээг хамтран зохион байгуулж, тус сургалтын агуулгыг танилцуулан, нийгмийн сайн сайхан орон нутгийн хөгжлийн төлөө эмэгтэйчүүд нэгдэж ажиллах талаар зөвлөгөөн хийсэн” гэж төслийн 2017, 2018, 2019 оны тайлангуудад дурдсан нь бидний чанарын судалгааны үр дүнтэй ерөнхийдөө нийцэж байгаа тул энд ишлэх нь зүйтэй гэж үзлээ.

Шигтгээ 15. Булган аймаг, Баян-Агт сум ярилцлага

Маш их идэвхтэй болсон, хийе бүтээе л гээд байдаг болсон. Намайг байхгүйд өөр эмэгтэйчүүдийн байгууллага хурал зөвлөгөөн хийгээд явсан гэсэн. Хамгийн гол зүйл нь л идэвх нэмэгдэж оролцоо сайжирсан. Байгууллагууд ч өөр болсон, ялангуяа эмэгтэй удирдлагатай байгууллагуудад их нөлөөлж байна лээ. **Би эмнэлгийн ажилтан болохоор ялангуяа ажлынхандаа мэдээллээ хуваалцсан. Үүний үр дүнд 32 хүний бүрэлдэхүүнтэй “Эрүүл зөв амьдарцгаая” нэртэй клуб үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Надтай хамт аймаг руу сургалтанд явсан 10 эмэгтэйн 4 нь хамт клубд маань элссэн бөгөөд бидний энэхүү үйл ажиллагааг ЗДТГ зохих ёсоор дэмжинэ гэдгээ амласан.**

Дээрх жишээний адил сайн туршлага болохуйц жишээг фокус ярилцлагын үед эмэгтэйчүүд дурдаж байлаа. Түүнчлэн сургалтад хамрагдсан эмэгтэй төлөөлөгчид асуудалд илүү объектив байр суурьнаас хандаж, өөрсдийн тавьж байгаа зорилгодоо хүрэхэд ямар шийдэл зөв зүйтэй байгаа талаар нухацтай, шинэлэг санааг дэвшүүлж ярьж байсан нь сонирхол татаж байв.

Төслийн нэр: Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь **Төслийн дугаар:** Хэрэгжүүлэгч **байгууллага:** Монгол Улсын Их Хурлын Тамгын газар **Эхлэх хугацаа:** 2017 оны 1 дүгээр сар **Дуусах хугацаа:** 2020 оны 12 дугаар сар **Төслийн үнэлгээний хурлын огноо:** 2016 оны 6 дугаар сарын 14

Шигтгээ 16. Булган аймаг, Булган сум ярилцага

Бид нар сургалтад хөдөөний сумдын хүмүүстэй сууснаас Орхон аймгийн ч юм уу суурьшмал байдаг төлөөлөгчидтэй нэг суувал зүгээр юм байна лээ. Иргэддээ л төрийн үйлчилгээг хүргэх анхан шатны байгууллага шүү дээ, тэр талаасаа арай ойрхон байхгүй юу. Тэгэхэд хөдөөнийхөн голцуу хэсэгчилсэн хурал хийдэг юм байна лээ. Хоёр өөр орчны төлөөлөгчдийг суулгахаар хэрэгжих боломж дээр учир дутагдал гарч байгаа юм. Манай баг сумандаа харьцангуй их малтайд тооцогддог хэрнээ тэгж санагдаж байгаа юм чинь малгүй багийн төлөөлөгчдөд бүр л өөр санагдана шүү дээ. Хүмүүсээ яаж оролцуулах вэ, иргэдийн нийтийн хурлаас багийн засаг дарга ямар ялгаатай вэ гэдгийг бас хэлж өгч байна лээ, бүлгийн ажил дээр 100 хувиас 40 хувь нь нийтийн юм яриад, 60 хувь нь бол мал ахуйгаа яриад л, багийн сан гэдэг ч юмуу. Багийн санг хөдөөнийхөн аягүй их хэрэглэдэг юм байна лээ. Манай төв дээр бол багийн санг огт хэрэгжүүлж чадахгүй байгаа байхгүй юу.

Төслийн зохион байгуулагчдын зүгээс Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтыг ач холбогдолтой гэж үнэлж байгаа боловч цаашид сургалтын хөтөлбөр болон агуулгад сайжруулах зүйл байгааг Төслийн баримт бичиг, болон үйл ажиллагааны тайлангууддаа дурдсан байдаг. Түүнчлэн төслийн зүгээс эмэгтэйчүүдийн манлайллын сургалтын зорилгыг сонгуульт албан тушаал хашиж буй эмэгтэйчүүд орон нутагтаа болон ИТХ-д манлайлж ажиллах, сонгуульд өрсөлдөх, орон нутагт тулгарч буй асуудалд нэгдсэн шийдэл олох, ИТХ-ын шийдвэрт нөлөөлөх чадварыг нь дээшлүүлэх, ИТХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх явдал гэж үзсэн байна. Чанарын судалгааны зарим жишээнээс харахад энэ чиглэлээр цаашид эмэгтэй манлайлагчдыг бэлдэхдээ зөвхөн эмэгтэй төлөөлөгч гэдэг утгаар нь биш иргэдийг нийтэд нь төлөөлж буй төлөөлөгч гэдэг утгаар илүү өргөн цар хүрээтэй ажил, төсөл, бодлого боловсруулж шийдвэрлэх түвшинд манлайлагч байхад бэлдэх хэрэгцээ шаардлага харагдаж байлаа. Фокус ярилцлагын болон анкетын судалгаагаар эмэгтэй манлайллын сургалтын талаар сөрөг гэхээр жишээ шууд дурдаагүй боловч сургалтын агуулга, сургагч багшийн өгөх мэдлэг мэдээллийг сайжруулахад анхаарал татахуйц нэгэн сонирхолтой ярилцлага болсныг доорх шигтгээнд онцолж байна.

Шигтгээ 17. Төв аймаг, Зуунмод сум ярилцлага

Эмэгтэйчүүдийн манлайлал сургалтын нэрийн дор эмэгтэйчүүдэд хэтэрхий их үүрэг хүлээлгэх, заавал эрэгтэйчүүдээс илүү байх ёстой мэт хандлага гаргаж байгаа нь ажиглагдаж байсан. Жендер гэдэг ойлголт өөрөө дан ганц эрэгтэй, эмэгтэй гэлтгүй аль ч хүйсийн эрх тэгш байдлыг агуулж байдаг ойлголт учраас заавал эмэгтэйчүүдийн манлайлал гэхгүйгээр зүгээр тэргүүлэгчдийн эсхүл төлөөлөгчдийн манлайлал гэдэг сэдвээр сургалт явуулах нь

зүйтэй гэж санагдсан. Эмэгтэйчүүд гэж ялгаж ангилснаараа эргүүлээд эрэгтэйчүүдийг ялгаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг юм билээ...

Сургалтын явцад эмэгтэй төлөөлөгчид манлайлж хэрэгжүүлсэн ажлын талаар бидэнд бусад аймаг, сумдын туршлагыг танилцуулсан. Үүний дараагаар биднийг өөрсдөө иймэрхүү санаачилга гаргаад хэрэгжүүлэх боломжтой ажлыг санаачлахыг зөвлөсөн. Үүний үр дүнд бид нийлж байгаад Төв аймагт дулааны цахилгаан станц баригдах гэж буйтай холбоотойгоор дулааны шугамыг гэр хороололтой холбох санаачилга гаргасан боловч сургалт орж байсан багшийн зүгээс хэтэрхий том ажил байна, амьдралд хэрэгжихүйц жижигхэн ажил бодож ол зэрэг хандлага гаргаж байсан нь зохимжгүй байсан. Эмэгтэйчүүдийн манлайлал ийм л зүйл дээр гарч ирэх ёстой гэж бодож байна. Гэхдээ бид энэ сургалтын үр дүнд энэ ажлаа үргэлжлүүлэн хийж дуусгасан.

Төслийн баримт бичигт дурдсан дараах санааг судалгааны үр дүнтэй харьцуулан дурдах нь зүйтэй байна. Сум, дүүргийн ИТХ-тай (30 орчим хувь) харьцуулахад аймаг, нийслэлийн ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь маш доогуур буюу аймагт 17, нийслэлийн ИТХ-д 13 хувь байна. Төслийн үйл ажиллагааны тайлан болон явцын судалгаанд үндэслээд шат, шатны ИТХ-д эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэмэлт үйл ажиллагааг төслөөс хэрэгжүүлэх боломжийг эрж хайх, аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд өрсөлдөхөд эмэгтэйчүүдэд тулгарч буй саад бэрхшээлийн талаар судалгаа хийх нь зүйтэй гэж үзсэн нь маш чухал дүгнэлт болжээ. Учир нь эмэгтэйчүүд сонгуульд амжилттай өрсөлдөж төлөөлөгчөөр сонгогдох, улмаар иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд өрсөлдөн сонгогдох шатанд эмэгтэй улс төрчдийн манлайллын сургалт онц ач холбогдолтой юм. Олон зуун өрсөлдөгчдөөс нэгэнт сонгогдсон эмэгтэй төлөөлөгч хүйсийн хувьд биш иргэдийн төлөөлөгчийн хувьд манлайлан ажиллах зорилгыг илүү түлхүү анхааран ажиллах ёстой билээ.

Дэд бүлгийн дүгнэлт


“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд эмэгтэй төлөөлөгчдөд зориулан зохион байгуулсан манлайллын сургалтын үр нөлөөг судалгаанд оролцогчид хэрхэн дүгнэсэн болохыг дараах хүснэгтэд харуулж байна. Үүнд:

№	Үзүүлэлтүүд	Үнэлгээ	Оноо
1	Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	91.1	4.55
2	Төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин	91.7	4.59
3	Төлөөлөгчид сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал	89.7	4.48
4	Мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүд	87.4	4.37

Дундаж үнэлгээ	90.0	4.5
----------------	------	-----

Энэхүү үр нөлөөний судалгаанд хамрагдсан оролцогчдын үнэлгээг үзүүлэлт тус бүрээр ангилан харьцуулж доорх графикт харуулав. Үүнд:

Зураг 44. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтыг үнэлсэн байдал /Үзүүлэлт бүрээр/



Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшнээ хамгийн өндрөөр, сургалтын зохион байгуулалтад өгсөн сэтгэл ханамжаа харьцангуй өндрөөр, сурсан мэдлэг, чадвараа ашиглаж дадсан байдлыг харьцангуй доогуур, харин мэдлэг, ур чадвараа ашиглан орон нутагтаа өөрчлөлт гаргасан байдлаа хамгийн доогуур үнэлсэн байна.

Эмэгтэй төлөөлөгчийн манлайллын сургалтын ач холбогдол, үр нөлөөтэй байдал ялангуяа судалгааны тоон үзүүлэлтээр өндөр гарсныг юун түрүүнд дурдах нь зүйтэй юм. Судалгаанд оролцогчдын олонхи төдийгүй цөөнхийн санал хүсэлт, фокус ярилцлагын үеэр хөндөж байсан санал, дүгнэлт дээр үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Түүнчлэн хөтөлбөрийн стратеги зорилтууд хэрхэн биелэгдэж байгаа болон дараагийн зорилтуудыг дэвшүүлэх гэж буй энэ цаг үед ололт амжилт, сайн туршлага дээр үндэслэн цаашид ямар арга зүй, стратегиар явбал илүү оновчтой байх тал дээр илүү бодолцон дараах зөвлөмжийг санал болгож байна.

1. Сургалтын агуулгын хувьд

Хурлын төлөөлөгч нь тухайн орон нутгийн иргэдийг нийтэд нь төлөөлж байгаагийн хувьд жендэрийн асуудлаар мэдрэмжтэй байх ёстой гэсэн нийтлэг зарчим дээр ойлголцох, жендэрийн мэдрэмжтэй бодлого, шийдвэрийн төлөө багаар ажиллах сэтгэлгээг суулгах нь сургалтын үр дүнг цаашид тогтвортой, өгөөжтэй байлгахад ач холбогдолтой байна. Иймд эмэгтэйчүүдийн манлайллын сургалтыг цаашид

Төлөөлөгчдийн манлайллын сургалттай хамтатган явуулах нь шийдвэрлэх нэг арга зам байж болох юм. Ингэснээр манлайллын хөтөлбөрийн зорилго зөвхөн хүйсийн хувьд бус харин иргэдийн төлөөлөгчийн хувьд манлайлагч байх гэдэг нийтлэг зарчмыг хангахаас гадна, сэдвийн агуулгын давхцал, хэд хэдэн сургалтад суух оролцогчдын давхцал зэрэг нь багасч сургалтын чанар, оролцогчдын идэвх илүү сайжирна гэж үзэж байна.

2. Оролцогчдын хувьд

Хөтөлбөрийн хүрээнд 2018 онд эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалтанд аймаг нийслэл дүүргийн нийт 2162 эмэгтэй төлөөлөгчдөөс 1858 эмэгтэй буюу 85.9 хувь нь сургалтад хамрагдсан нь ирц, оролцооны хувьд нэлээн өндөр байсан нь харагдаж байна. Харин манай тоон судалгааны дүнгээс харахад эмэгтэйчүүдийн манлайллын сургалтын сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдлыг оролцогчдын 66.9% нь маш сайн, 22% нь сайн, 10.2% дунд, 0.8% нь муу гэж үнэлсэн нь асуулгын нийт асуултуудаас хамгийн сул үнэлгээ байлаа. Эндээс дүгнэвэл манлайллын сургалтад бүх эмэгтэй төлөөлөгчдийг хамруулахыг зорилгоо болгохоос илүүтэй тухайн сургалтын ач холбогдлыг мэдэрч, ажил, албан тушаалдаа бүтээлчээр хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлэлийг нь харгалзан үнэлж сонгон шалгаруулвал оролцогчдын тоо багасах магадлалтай ч сургалтын чанарт эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна. Ийнхүү оролцогчдыг сонгон шалгаруулах нь төлөөлөгчийн манлайллын сургалтад ч бас адил үр дүнг авчрах магадлалтай.

3. Сургалтыг зохион байгуулахын хувьд

Монгол улс нь өргөн уудам нутаг дэвсгэртэй, засаг захиргааны олон жижиг нэгжтэй, тус бүртээ хүн ам, байгаль цаг уур, эдийн засаг, нийгэм, аж ахуйн хувьд харилцан адилгүй байдаг тул манлайллын сургалтыг бүсчлэн явуулах нь илүү ач холбогдолтой байж болох юм. Манлайлагч төлөөлөгчдийн хувьд өөр хоорондоо харилцан суралцах, туршлага солилцох, бүсчилсэн байдлаар бодлогын болон цаг үеийн асуудлаа шийдвэрлэх зэргээр хамтран ажиллах боломжийг илүү бодитой болгох болмжтой юм.

Ийнхүү дээр дурдсанаар Төлөөлөгчийн манлайллын сургалт болон Эмэгтэй төлөөлөгчийн манлайллын сургалтын агуулга, зохион байгуулалтыг хамтатган, нэгдсэн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулбал:

1. Тухайн нэг хүйсийн хувьд бус нийт иргэдийг төлөөлөгчийн хувьд манлайлагч байх зарчмыг практикт хүлээн зөвшөөрч хэрэгжиж эхэлнэ. Энэ нь эргээд эрэгтэй төлөөлөгч мөн нийт иргэдийг төлөөлж байгаагийн хувьд жендэрийн асуудалд хүйс харгалзахгүйгээр мэдрэмжтэй хандах эерэг нөлөөтэй. Манлайллын сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлаар үндэсний болон орон нутгийн

хэмжээнд хэрэгжүүлэх бодлого шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар өргөн таниулж сургах нь зүйтэй юм.

2. Эдийн засгийн хувьд хэмнэлттэй байх магадлалтай. Төлөөлөгчийн манлайлал болон Эмэгтэй төлөөлөгчийн манлайллын хөтөлбөрийг нэгтгэн оролцогчдыг сонгон шалгаруулалтын журмаар бүртгэх нь сургалтын нийт зардалд хэмнэлт гарах төдийгүй ур чадвартай багшлах боловсон хүчний нөөц дутагдалтай байдал багасах, сургалтанд хэрэглэгдэх сургалтын материалын чанар, хүртээмж илүү сайжрах боломжтой юм.

1.4 Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын үр нөлөө

“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслөөс мөн багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан байна.

Тус сургалтын хөтөлбөр нь ИНХ-ын эрх зүйн үндэс, суурь ойлголт; хуралдаан; тэргүүлэгчид; багийн өөрөө удирдах ёс ба иргэдийн оролцоо; шийдвэр, түүний хэрэгжилтэд хяналт тавих нь; багийн хэмжээнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх нь гэсэн зургаан сэдэв бүхий нийт 18 цагийн агуулга бүхий сургалт юм.

ИНХ-ын дарга нарт зориулсан гарын авлагад багийн ИНХ-тай холбоотой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн эмхэтгэл, архив бичиг хэргийн стандарт болон Хурлын үйл ажиллагаанд нийтлэг хэрэглэгддэг баримт бичгийн жишиг загвар, бэлчээр ашиглалтын гэрээний загвар зэрэг сайн туршлага, сургамжуудыг багтаасан байна.

Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын сургагч багш нарыг бэлтгэх сургалтын үеэр ИНХ-ын дарга нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байдаг сумдын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарыг мөн сургалтад хамруулах хүсэлтийг аймгуудаас гаргасныг хүлээн авч, энэ удаагийн сургалтад нийт 1562 багийн ИНХ-ын дарга, 307 сумдын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга хамрагдсан байна.


Хүснэгт 6. Сургалтад хамрагдсан аймаг, сумдын хуваарь⁶

⁶ Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн 2017 оны үйл ажиллагааны тайлан

	Аймаг	сургалтын огноо	нийт багийн ИНХ-ын дарга	сургалтад хамрагдсан БИНХ дарга	хувь	сумдын ИТХ-ын нбд	сургалтад хамрагдсан нбд	хувь
1	Архангай	2017.11.16-17	101	95	94.1	19	19	100.0
2	Баян-Өлгий	2017.11.08-09	89	79	88.8	13	13	100.0
3	Баянхонгор	2017.11.01-02	104	104	100.0	20	20	100.0
4	Булган	2017.10.30-31	75	67	89.3	16	15	93.8
5	Говь-Алтай	2017.11.03-04	87	87	100.0	18	18	100.0
6	Говьсүмбэр	2017.10.26-27	10	10	100.0	3	3	100.0
7	Дархан-Уул	2017.11.02-03	26	26	100.0	4	4	100.0
8	Дорноговь	2017.10.26-27	64	64	100.0	14	14	100.0
9	Дорнод	2017.10.30-31	66	66	100.0	14	14	100.0
10	Дундговь	2017.11.01-02	66	66	100.0	15	15	100.0
11	Завхан	2017.11.13-14	115	115	100.0	24	24	100.0
12	Орхон	2017.11.09-10	24	23	95.8	2	2	100.0
13	Өвөрхангай	2017.10.30-31	109	108	99.1	19	19	100.0
14	Өмнөговь	2017.11.14-15	58	57	98.3	15	12	80.0
15	Сүхбаатар	2017.11.06-07	67	64	95.5	13	13	100.0
16	Сэлэнгэ	2017.11.02-03	56	56	100.0	17	17	100.0
17	Төв	2017.11.14-17	97	87	89.7	27	27	100.0
18	Увс	2017.11.05-06	93	90	96.8	19	0	0.0
19	Ховд	2017.11.08-09	91	89	97.8	17	17	100.0
20	Хөвсгөл	2017.10.23-26	126	126	100.0	23	23	100.0
21	Хэнтий	2017.11.09-10	88	84	95.5	18	18	100.0
	ДҮН		1612	1563	97.0	330	307	93.0

Сургалтад нийт багийн ИНХ-ын дарга нарын 97 хувь, сумдын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга нарын 93 хувь нь оролцжээ.

Зураг 45. Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсан байдал




Энэ удаагийн үр нөлөөний судалгаанд оролцсон төлөөлөгчдийн 88 буюу 12.9 хувь нь Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсан байна.

Суурь сургалтын үр нөлөөг дүгнэхдээ доорх дэд хэсгүүдэд ангилан үзлээ. Үүнд:

Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин

Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшинг сургалтын ерөнхий зохион байгуулалт, сэдвийн ач холбогдол, багшийн ур чадвар, сургалтын хугацаа гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэснийг доорх хэсгээс үзнэ үү.

Зураг 46. Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин, сургалтын үзүүлэлтүүдээр



Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг оролцогчдын 17.5% нь маш сайн, 74.6% нь сайн, 7.9% нь дунд гэсэн бол муу болон маш муу гэж хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид зохион байгуулалтыг ерөнхийдөө сайн (89.6 оноо) гэж дүгнэжээ

Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдлыг оролцогчдын 20.6% нь маш сайн, 73% нь сайн, 6.4% нь дунд гэсэн бол муу болон маш муу гэж хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдлыг ерөнхийдөө сайн (91 оноо) гэж дүгнэжээ

Багшийн ур чадвар, заах арга зүйг оролцогчдын 30.2% нь маш сайн, 65.1% нь сайн, 4.8% нь дунд гэсэн бол муу болон маш муу гэж хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид багшийн ур чадвар, заах арга зүйн чадварыг ерөнхийдөө сайн (93.2 оноо) гэж дүгнэжээ


Сургалт зохион байгуулсан цаг үе болон, сургалт үргэлжилсэн хугацааг оролцогчдын 19.4% нь маш сайн, 64.5% нь сайн, 16.1% нь дунд гэсэн бол муу болон маш муу гэж хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид зохион байгуулсан цаг үе болон сургалтын үргэлжилсэн хугацааг ерөнхийдөө сайн (79.9 оноо) гэж дүгнэжээ.

Сургалтын гарын авлага, тараах материалын чанарыг оролцогчдын 22.2% нь маш сайн, 69.8% нь сайн, 4.8% дунд 3.2% нь муу гэж үнэлсэн бол маш муу гэж хариулсан хүн байхгүй байна. Энэхүү сургалтад хамрагдсан оролцогчид тараах материал, гарын авлагыг ерөнхийдөө сайн (89.1 оноо) гэж дүгнэжээ

Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшинг сургалтын ерөнхий зохион байгуулалт, сэдвийн ач холбогдол, багшийн ур чадвар, сургалтын хугацаа гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэж, тус бүрд нь оноо тавьж дээрх хэсэгт оруулсан билээ. Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл оролцогчдын ерөнхий сэтгэл ханамж 88.6 оноо байна.


Багийн ИНХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга нар шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин

Зураг 47. Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтаас хангалттай мэдлэг, чадвар олж авч чадсан гэж үзэж байна уу?



Багийн ИНХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын сургалтад хамрагдсан оролцогчдоос тус сургалтаас олж авсан мэдлэг, ур чадварыг нь өөрсдөөр нь үнэлүүлэхэд маш хангалттай гэж 27%, ер нь хангалттай гэж 63%, дундаж гэж 10%, тус тус үнэлсэн байна. Үүнийг дүгнэж үзвэл оролцогчид өөрийн олж авсан мэдлэг, ур чадвартаа дунджаар 83.3 оноо өгсөн байна.

Зураг 48. Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтаас хангалттай мэдлэг, чадвар олж авч чадсан гэж үзэж байна уу? /хүйсээр/



Мэдлэг, ур чадвар олж авч чадсан талаар хүйсээр харьцуулж үзвэл эмэгтэй төлөөлөгчид нь эрэгтэй төлөөлөгч нараасаа 2 дахин илүү хувиар үнэлжээ. Эрэгтэй төлөөлөгчид энэ байдал дээр эмэгтэй төлөөлөгч нараасаа дутуу байна гэж үзэж болохоор байна.


Шигтгээ 18. Булган аймаг, Бүрэгхангай сум ярицлага

Анх багийн иргэдийн нийтийн хурлын даргаар сонгогдоод яаж ажиллах вэ, ард иргэдтэйгээ яаж уулзах вэ, эрх зүйн ямар актуудыг гаргах вэ, төр захиргааны байгууллага болон дээд шатны албан байгууллага руу яаж албан тоот явуулах уу, тойргийн иргэдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах вэ гэдэг дээр учир дутагдалтай байлаа. Тухайн сургалтанд сууснаар иргэдтэйгээ хаана, хэзээ, хэрхэн уулзах вэ талаар мэдэж авлаа. Тэдний эрх ашгийг хамгаалахын тулд дараа дараагийн эрх зүйн байгууллагуудад ямар эрх зүйн актаар шаардлага, хүсэлт тавих вэ гэдэг талаар олж авсан. Өнөөдөр төрийн ажил бичиг, цаасаар хийгдэж байгаа болохоос биш нэг хүний амнаас сонссон үгээр цааш ам дамжуулж явах маягаар хийгдэхгүй учир түүнийгээ эрх зүйн акт болгон баримт бичиг хийж явуулах нь хэр зэрэг үр дүнтэй вэ гэдгийг мэдэж амьдрал дээр хэрэгжүүлж явна.

Багийн иргэдийн нийтийн хурлын сургалтын хувьд ИНХ-ын дарга нарт зайлшгүй, хэрэгцээтэй сургалт болсон гэж үзэхийн зэрэгцээ, тэнд шаардагдах ур чадварыг тодорхой хэмжээнд өгсөн гэж үзэж байна. Иргэдийн нийтийн хурал нь зохион байгуулалтад орж, бодлого тодорхойлогч нарын шийдвэрт оролцохдоо эрх зүйн акт болон баримт бичгийн түвшинд оролцох нь үр дүнтэй гэдгийг мэдэж авсан гэж үзжээ.


ИНХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга нар сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал

Зураг 49. Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтаас сурсан мэдлэгээ ашиглаж байгаа юу?



Багийн ИНХ-ын дарга нарын сургалтад хамрагдсан оролцогчдоос тус сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа өдөр тутам ашиглаж байгаа гэж 12% нь, ихэвчлэн ашигладаг гэж 58% нь, заримдаа ашигладаг гэж 28% нь, бараг ашигладаггүй гэж 2%, тус тус хариулсан байна. Эдгээрээс үзэхэд сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдлаа оролцогчид дунджаар 76 оноогоор үнэлсэн байна.

Зураг 50. Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтаас сурсан мэдлэгээ ашиглаж байгаа юу? /хүйсээр/



Багийн ИНХ-ын дарга нарын сургалтаас сурсан мэдлэг, ур чадвараа ашиглаж байгаа талаар хүйсээр харьцуулж үзвэл эмэгтэй төлөөлөгч нар нь илүү ашигладаг байна. Энэ байдал эмэгтэй төлөөлөгчдөд байнга ашигладаг хувь нь 21.1 хувь бол эрэгтэй төлөөлөгчдөд 7.3 хув байна. Гэхдээ эмэгтэй төлөөлөгчдөд бараг ашигладаггүй гэж үзэх хандлага (5.3%) ч байна.

Шигтгээ 19. Сүхбаатар аймаг, Мөнххаан сум ярилцлага

Бид сумын бүх өрх айлуудаараа Хөтөч хавтас нэртэй хавтсыг явуулдаг болсон. Энэ нь тухайн засаг, захиргаа, нутгийн удирдлагын чиглэлээр ажиллаж буй


мэргэжилтнүүд нь өөр өөрсдийн чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээ мэдээллийг, төлөөлөгчид хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг тухайн хавтсанд хийгээд иргэд, малчдад хүргүүлдэг. **Харин багийн дарга нар сар бүр тухайн айлд хүргүүлэх мэдээллийг шинэчлээд, хавтсыг баяжуулдаг.** Ингэснээр иргэдтэй илүү их ойр ажиллах боломжийг бүрдүүлж өгсөн гэж үзэж байна. Энэ ажлыг **2017 оноос бодитоор хэрэгжүүлж эхэлсэн, өөр сум аймагт ийм ажил хийгддэг талаар сайн мэдэхгүй** байна.

Багийн нийтийн хурал нь иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ялгаатай нь төлөөлөх бус шийдвэр гаргах ажиллагаанд иргэд шууд оролцдогоороо ялгаатай. Иймээс иргэдэд сум, орон нутгийн үйл ажиллагааны талаар шууд иргэдэд мэдээлэл хүргэх нь зайлшгүй хэрэгтэй. Энэ ажлыг хэрэгжүүлсэн сайн гэж хэл болох туршлагыг Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын багийн иргэдийн нийтийн хурлаас хэрэгжүүлсэн байна. Энэ нь Хөтөч нэртэй мэдээллийн хавтсыг сумын бүх өрх айлуудаараа аялуулж мэдээлэл хүргэдэг байна.

Мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүд

Багийн ИНХ-ын дарга нарын сургалтын үр дүнд олж авсан мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн төлөөлөгчид болон тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүдийг авч үзвэл доорх байдалтай байна.


Зураг 51. Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсанаар таны ажлын арга барил өөрчлөгдсөн үү?



Багийн ИНХ-ын дарга нарын сургалтад хамрагдсанаар тухайн төлөөлөгчийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдлыг асуухад маш их дээшилсэн гэж 13% нь, ер нь дээшилсэн гэж 62% нь, зарим талаар дээшилсэн гэж 25% нь тус тус хариулсан байна.

Эдгээрээс дүгнэхэд сургалтын үр дүнд тухайн төлөөлөгчийн ажлын арга барил өөрчлөгдсөн байдалд оролцогчид дунджаар 77.7 оноо өгчээ.

Зураг 52. Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсанаар таны ажлын арга барил өөрчлөгдсөн үү? /хүйсээр/




Ажлын арга барил өөрчлөгдсөн талаар хүйсээр харьцуулж үзвэл эмэгтэй төлөөлөгчид нь эрэгтэй төлөөлөгчдөөсөө илүүтэйгээр өөрчлөгдсөн гэж үнэлжээ.

Шигтгээ 20. Булган аймаг, Бүрэгхангай сум ярилцлага

Энэ сургалтанд манай багийн дарга, багийн төлөөлөгч нийт зургаан төлөөлөгч суусан. Хоёр дэд дарга байгаа. Эд нар маань хурал зохион байгуулах, хурал зарлах, хурлын тоо шийдвэр гаргах, хэлэлцэх асуудлаа шийддэг. Манай багт нэг онцлог байдаг нь таван тэргүүлэгчидтэй хоёр дарга тулж ажилладаг. Хурлын дарга нь тэргүүлэгчидтэй хурлын тов гаргах, хэлэлцэх асуудлаа танилцаж бидний зүгээс нэмэх асуудал, ярилцах зүйл, хүсэлт байгаа эсэхийг асуудаг. **Манай баг шинэ төвтэй болж сайн тохижуулсан. Энэ төвдөө сүүлийн хоёр жил хурал хийж байгаа. Өмнө нь иргэд маань хоёр айлд хуваагдаж хурал хийдэг байсан. 900 гаруй хүн амтай тул багтаамжийн асуудалтай. Хоёр дарга маань хүчин чармайлт гаргаж ард иргэдтэйгээ нийлж, сум орон нутгаас дэмжиж энэ шинэ төвийг бий болгосон. Үүний хүчинд иргэд маань бараг 100 хувийн ирцтэй хуралд оролцдог болсон. Энэ нь их бахархууштай байгаа.** Иргэдээ залхаахгүйн тулд цай хоолоор үйлчилж, хэлэлцэх асуудлыг дарга нар жигд болгон иргэдийн санал хүсэлтийг бүрэн авч чаддаг болсон. Шинэ төвдөө хурал хийхэд тав тухтай байгаа. Иргэдээ хуралд татан оролцуулахад дарга нар сайн ажиллаж чаддаг. Төлөөлөгч миний бие мөн адил дарга нарыг дэмжиж хуралд оролцох нь иргэдэд ямар үр нөлөөтэй болохыг сануулж, хурал таслаж болохгүй гэдгийг захиж хуралдаа оролцоод өөрт тулгарч байгаа асуудлаа шийд гэж захиж хэлдэг. 2016 оноос хойш дарга нар маш сайн ажиллаж байгаа. Сум орон нутгийн иргэдтэй уулзаж малчид дундаа орж ажиллаж чаддаг. Энэ нь манай багт гарсан ахиц дэвшил юм. Миний бие 2016 оноос төлөөлөгч болон сонгогдож ажилласан. Өмнө нь хоёр удаа багийн иргэдийн нийтийн хурлаар багийн тэргүүлэгч болон сонгогдож байсан. Сургалтанд сууснаар хүнтэй харьцах, ажиллах, олныг удирдах, төлөөлөгч хүн ард иргэдийн дунд тэр тусмаа малчдын дунд орж дуу хоолой болон ажиллах нь миний үүрэг юм байна гэдгийг ойлгосон. Ямар ч хурлыг таслахгүй оролцон малчдын хэлж ярьж байгаа зүйл, ирж байгаа оролцоог ажиглаж байдаг. Сүүлийн хоёр удаагийн хуралд малчид

идэвхитэй оролцож санал хүсэлт, асуудал байвал надад хандаж надаар дамжуулж сум орон нутагт гүүр болж тулж ажиллаж байгаа нь энэ сургалтанд суусны ач гэж боддог. Энэхүү сургалтыг цаашид багийн тэргүүлэгч, дарга нарт оруулбал үр дүнтэй юм байна. Цааш цаашид орон нутагт тэр тусмаа малчид хөдөөний багаас сонгогдож байгаа тэргүүлэгч нарт өгөөжтэй юм байна гэж бодсон.

Зураг 53. Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсанаар танай байгууллагын ажилд өөрчлөлт гарсан уу?



Багийн ИНХ-ын дарга нарын сургалтад хамрагдсанаар тухайн Багийн ИНХ-ын ажил сайжирсан эсэхийг тандахад маш их дээшилсэн гэж 10%, ер нь дээшилсэн гэж 53% нь, зарим талаар дээшилсэн гэж 27% нь, бараг дээшлээгүй гэж 2% нь тус тус хариулсан байна.

Эдгээрээс дүгнэхэд сургалтын үр дүнд тухайн байгууллагын ажил өөрчлөгдсөн байдалд оролцогчид дунджаар 74.3 оноо өгчээ.

Багийн ИНХ-ын дарга нарын сургалтын үр дүнд бий болсон хамгийн эерэг болон сөрөг туршлагуудын талаар асуухад давхардсан тоогоор 30 гаруй эерэг, 10 орчим сөрөг туршлагуудыг дурдсан бөгөөд эдгээрийн багцалвал:

- **Ажилдаа мөрдлөгө болох зүйлүүдийг сурсан**
- **Багийн ИНХ зохион байгуулах арга барил сайжирсан**
- **Иргэд идэвх санаачлагатай болж зохион байгуулалтад орсон**
- **ОНХСангийн талаар илүү мэдээлэлтэй болж, хөрөнгө оруулалтыг зөв хийвэл үр дүнд хүрэх талаар дэлгэрэнгүй ойлголттой болсон**
- **Хамтын шийдвэр гаргаж сурсан**
- **Иргэд чөлөөтэй, нээлттэй, ил тод мэдээлэл дээр суурилж шийдвэр гаргадаг болсон ... зэрэг эерэг туршлагуудыг дурдсаныг онцлон тэмдэглэх шаардлагатай гэж үзэж байна. Тооны хувьд эерэг санал олон байна.**

Завхан аймгийн Дөрвөлжин сумын багт иргэдийн Нийтийн Хурлын жишиг хуралдааныг зохион байгуулах талаар дараах тайланг төсөл рүү явуулжээ. Үүнийг загвар байдлаар оруулбал:

Дөрвөлжин сумын Хурлын дарга В.Батмэндлэх, Буурал, Буга багийн ИНХ-ын дарга Д.Саранчулуун, Ч.Эрдэнэцэцэг нартай өмнө нь гар утсаар мэдээлэл солилцсоны дагуу багт ажиллах удирдамжийн дагуу дараах ажлыг зохион байгуулж ажилласан.Үүнд:

1. Буурал, Буга багуудын ИНХ-ын дэгтэй танилцаж шинжилгээ хийхэд багийн ИНХ-ын хуралдааныг хуулийн хүрээнд зохион байгуулахад учир дутагдалтай ерөнхий дэг байсан.
2. Багийн ИНХ-ын Хуралдаан зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг тухайн багуудын ИНХ-ын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг хангах аргачлалыг ажлын байрны сургалтаар тэдэнд олгосон.
3. Багийн ИНХ-ын хурлын хуралдааны ирцийг нэмэгдүүлэх зорилгоор хуралдааны зар мэдээллийг цахим сүлжээ ашиглах, хариуцсан төрийн албан хаагчдаар зар хүргүүлэх багийн ИНХ-ын дарга, Тэргүүлэгчдийг айл өрхүүд рүү утсаар зарыг хүргэх ажлыг зохион байгуулж, Буга багийн ИНХ-ын хуралдааныг 2019 оны 11 дүгээр сарын 22 нд сумын Соёлын төвд зохион байгуулж 74 өрхийн 118 иргэнийг оролцуулан хуралдааны өмнө тухайн багийн баталсан хуралдааны дэгийн дагуу зохион байгуулж алдаа дутагдалтай зүйлийг газар дээр нь зөвлөгөө өгч, багийн ИНХ-ын жишиг дэгтэй холбон тайлбарлаж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Өмнө нь багийн ИНХ-ын дарга Хурлаа удирдахын зэрэгцээ тэмдэглэлээ давхар хөтөлдөг байсан бол энэ хуралдаанд багийн ИНХ-ын даргын санал болгосноор ажлын хэсэг томилж ажиллуулсан.Энэ удаагийн багийн ИНХ-аар “Өвөлжилтийн бэлтгэл хангалтын ажлын тайлан, мэдээлэл”, багийн ИНХ-ын Хуралдааны жишиг дэгийг танилцуулах асуудлуудыг хэлэлцсэн. Энэ хуралд Буурал багийн ИНХ-ын дарга,Тэргүүлэгчдийг ажиглагчаар оролцуулж туршлага судлуулсан. Энэ Хуралдаанд оролцогч иргэдийн зарим нь хэлэлцэж буй асуудалтай холбоогүй санал шүүмжлэл тавьж Хуралдааныг удаашруулах, зарим иргэд бухимдлаа илэрхийлэх, багийн ИНХ-ын даргын шаардлагыг бүрэн биелүүлэхгүй байх, зөвшөөрөлгүй гарч, орох зэрэг дутагдал байсныг жишиг дэгтэй холбон арга зүйн зөвлөгөө өгөхөд иргэд ойлгон багийн Хуралдааны жишиг дэгийг батлан түүний дагуу хуралдаж байх талаар 11 иргэн дэмжиж санал гаргав.



4. Өвөлжилтийн бэлтгэл ажлын дутууг хангуулах чиглэлээр шийдвэр гаргаж жишиг хуралдааны дэгийг дараагийн хуралдаанаар батлахаар тогтов.

Дөрвөлжин сумын Цогт баг гэхэд багийн хурлаа хийж асуудлаа шийдэж Хуралдаанаа хаасны дараа сумын тайланг тавиулдаг хэвшлийг тогтоосон нь бусад багуудад сайнаар нөлөөлсөн байна.

Дэд бүлгийн дүгнэлт

Хүснэгт 7. Багийн ИНХ-ын дарга нарын сургалтын ерөнхий үнэлгээ

№	Үзүүлэлтүүд	Үнэлгээ	Оноо
1	Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	88.6	4.44
2	Төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин	83.3	4.19
3	Төлөөлөгчид сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал	76	3.8
4	Мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүд	74.3	3.64
	Дундаж үнэлгээ	80.55	4.01

Багийн ИНХ-ын дарга нарын сургалтын үр нөлөөг судалгаанд оролцсон оролцогчид 80.55 хувийн үнэлгээ өгсөн байна. 1-5 оноонд шилжүүлж үзвэл 4.01 оноо байна. Үүнийг дотор нь дээрх хүснэгтэд байх 4 үзүүлэлтээр хувааж үзвэл сургалтын сэтгэл ханамжийн түвшин 88.6 хувь, төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин 83.3 хувь, сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдлыг 76 хувь, мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлснээр тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүдэд 74.3 хувийн үнэлгээг тус тус өгсөн байна.

Зураг 54. Багийн ИНХ-ын дарга нарын сургалтын ерөнхий үнэлгээ



Бүх шатны Багийн ИНХ-ын дарга нарын сургалтад хамрагдсан оролцогчид сургалтын талаарх үзүүлэлтүүд болох сургалтын сэтгэл ханамж, заасан мэдлэг ур

чадвар түвшин, төлөөлөгчийн дадал, ажлын өөрчлөлтүүд зэрэгт нийтэд нь 80 хувь буюу хангалттай сайн үнэлгээ өгсөн.

Багийн иргэдийн хурлын дарга нар мөн л 4 жил тутамд солигддог. Солигдох бүрт нь шинэ дарга нар ажил, үүргээ мэдэхгүй, туршлага дутах явдал гардаг байна. Энэ сургалтаар Багийн ИНХ-ын дарга нар маш их зүйлийг сурч, ажил, амьдралдаа хэрэгжүүлж чаддаг байна. Тэдний үндсэн ажил болох иргэн бүрт мэдээлэл хүргэх, шийдвэр гаргах түвшинд оролцуулах, хамтын шийдвэр гаргах зэрэгт суралцдаг байна.

Чанарын ярилцлагын үр дүнд ч мөн тус сургалтад хамрагдсан төлөөлөгчид маш их сэтгэл хангалуун байсан талаар дурджээ. Төлөөлөгчид суурь сургалтыг явуулсны дараа иргэдийг хэрхэн сэдэлжүүлэх, идэвхтэй болгох хамгийн гол нь ямар нэг аргаар иргэдэд мэдээллийг байнга хүргэх ёстой зэргийг маш сайн ойлгодог байна. Түүнийг төрөл бүрийн аргыг хэрэглэдэг байна. Айл бүрээр мэдээллийн дэвтэр аялуулах, нийгмийн сүлжээнд бүлэг үүсгэх, багийн төвүүдийг шинээр байгуулах зэрэг олон дорвитой сайн гэж хэлж болох ажлуудыг хийж туршжээ.

Харин сургалтын үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулж үзвэл оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин буюу зохион байгуулалт, сэдэв, багшийн ур чадвар, хугацаа, гарын авлага болон төлөөлөгчид заасан мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түвшин зэрэгт 90 орчим хувийн үнэлгээ өгсөн бол төлөөлөгчид сургалтаас авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал болон тухайн орон нутагт гарсан өөрчлөлтүүд зэрэгт 70 гаруй хувийн үнэлгээ өгсөн байна.

Үүнээс үзэхэд сургалтыг тасралтгүй цааш үргэлжлүүлэх нь зайлшгүй бөгөөд иргэдийн эрх зүйн ухамсар, тэдний идэвх, оролцоог нэмэгдүүлэх нь орон нутгийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд хувь нэмэртэй байна.

1.5 ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн үр нөлөө

Энэхүү үр нөлөөний үнэлгээний судалгаагаар үнэлж байгаа төслийн зохион байгуулсан өөр нэгэн үйл ажиллагаа нь 2017 болон 2018 онд ИТХ, ТББ-уудад ИТХ-уудын зохион байгуулалтыг сайжруулах, тэдгээрийн хяналт, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх, сайн туршлагыг хөхиүлэн дэмжих, бэлчээрийн менежментийг сайжруулах зэрэг чиглэлээр тэтгэлэг олгосон үйл явц юм.

УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2017 оны 279 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ИТХ-уудын дунд тэтгэлэг зарласны дагуу тус онд ИТХ-уудаас 104 санал ирүүлснээс 20 саналыг сонгон шалгаруулж тус бүр 4 сая төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

Харин 2018 онд тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд ШХА-ын “Ногоон алт” төсөлтэй хамтран бэлчээрийн менежементийн чиглэлээр тэтгэлэг олгосноороо онцлог байна. Энэ оны ээлжит тэтгэлэгт хөтөлбөрийг 2018 оны 1 сард зарласны дагуу ИТХ-аас 81, ТББ-аас 23 санал ирүүлсэн бөгөөд ИТХ-ын хяналт, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх сайн туршлагыг хөхиүлэн дэмжих 20, бэлчээрийн менежементийг сайжруулах чиглэлээр боловсруулж ирүүлсэн 19 төсөлд буюу нийт 39 тэтгэлгийг ИТХ-уудад олгож, зургаан ТББ-д тус бүр 6 сая хүртэл төгрөгийн тэтгэлэг олгожээ.

ИТХ-д олгосон тэтгэлгийг үр нөлөө


Төслийн 2017 оны үйл ажиллагааны хүрээнд аймгийн ИТХ- 5 сая хүртэл, Сумын ИТХ-д 3 сая хүртэл, Дүүргийн ИТХ-д 4 сая хүртэл төгрөгийн тэтгэлгийг олгосон байна. Ингэхдээ тэтгэлгийн шалгуур үзүүлэлтүүдийг (1) тэтгэлэг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага, үндэслэл, зорилго, зорилт, үйл ажиллагаа, үр дүн, төсвийг уялдаа холбоотой, бүрэн сайн боловсруулсан байх, (2) иргэдийн саналд тулгуурласан, тухайн орон нутагт зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай, гарах үр дүнг цаашид тогтвортой хэрэгжүүлэх боломжтой байх, (3) тэтгэлгийн санал боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад ИТХ-ын нийт төлөөлөгчид, хороод, ажлын албаны ажилтнуудыг оролцуулах гэсэн шаардлагуудыг тавьсан байна. Харин дараагийн жилүүдэд тэтгэлэг хүсэгч нь аймаг, дүүрэг, сумын ИТХ байх (буюу тэтгэлгийн саналыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж, дэмжсэн байх), ИТХ-аас хууль тогтоомжид заасны дагуу хяналт тавих, иргэдийн оролцоог хангах, ил тод байдлыг сайжруулах зорилгыг агуулсан, орон нутгийн түвшинд хэрэглэх аргачлалыг бий болгох, боловсронгуй болгохоор зорьсон байх, тодорхой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодитой, шинэлэг, бүтээлч арга зүй, аргачлалыг санал болгосон байх, хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүн, үр шимийг хүртэгсдийн жендэрийн эрх тэгш байдал, нийгмийн

бүлгүүдийн төлөөллийг харгалзсан байх зэрэг шаардлагуудыг тусгайлан нэмж тусгажээ.

Хөтөлбөрийн зүгээс 2017 онд хэрэгжүүлсэн тэтгэлэгт хөтөлбөрийн сайн туршлагыг солилцох тусгай семинарыг 2018 онд зохион байгуулахад семинарын явцад Хэнтий аймгийн ИТХ, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ИТХ, Увс аймгийн Зүүнговь сумын ИТХ-ын төлөөлөгчид, Захиргааны шинэ санаачлага ТББ, Монголын нутгийн удирдлагын холбоо ТББ, Нутгийн удирдлага иргэний хяналт ТББ, Хил хязгааргүй алхам ТББ, Хөвсгөл далайн эзэд ТББ, Энгүйнаран ТББ-ууд сайн туршлагаа танилцуулсан бол 2014-2016 онд тэтгэлэг хэрэгжүүлсэн талаар Баянхонгор аймгийн ИТХ, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын ИТХ, Дундговь аймгийн Хулд сумын ИТХ-ын төлөөллүүд тус тус сайн туршлагаа ярьжээ.

Тэтгэлэгт хамрагдсан орон нутгийн оролцогчид энэхүү судалгааны нийт оролцогчдын 17.4%-ийг эзэлж байв. Үүнийг доорх графикт дүрслэн харуулав. Үүнд:

Зураг 55. Тэтгэлэгт хамрагдсан орон нутгийн оролцогчдын эзлэх хувь



Харин эдгээр оролцогчид тухайн орон нутагт гарсан өөрчлөлтийг дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

Тухайн ИТХ-ын хэрэгжүүлсэн тэтгэлэг зорилгодоо хүрч чадсан эсэхэд оролцогчдын 13.2% нь хангалттай хүрсэн, 60.3% нь ерөнхийдөө хүрсэн, 20.6% нь тодорхой хэмжээнд хүрсэн гэж хариулсан бол 4.4% хангалтгүй, 1.5% нь маш хангалтгүй гэж хариулсан байна. Үүнийг дүгнэвэл судалгаанд оролцогчид тухайн тэтгэлэг нь зорилгодоо хүрсэн байдалд дунджаар 75.9% гэсэн үнэлгээг өгчээ.


Тухайн тэтгэлгийн үр дүнд ИТХ иргэдийг татан оролцуулах тал дээр өөрчлөлт гарсан эсэхэд оролцогчдын 17.6% нь маш их өөрчлөлт орсон, 54.4% нь их өөрчлөлт орсон, 13.2% нь тодорхой хэмжээнд өөрчлөлт орсон, 7.4% нь мэдэхгүй гэж хариулсан

байна. Үүнийг дүгнэвэл судалгаанд оролцогчид тухайн тэтгэлэгт хамрагдсаны үр дүнд ИТХ иргэдийг татан оролцуулах байдалд дунджаар 73.5% гэсэн үнэлгээг өгсөн байна.

Харин тэтгэлгийн үр дүнд ИТХ-ын хяналт тавих чадавхи сайжирсан эсэхийг асуухад судалгаанд оролцогчдын 19.1% нь маш их сайжирсан, 60.3% нь их сайжирсан, 8.8% нь тодорхой хэмжээнд сайжирсан гэж хариулсан бол 2.9% нь бараг сайжраагүй, мөн ижил 2.9% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Үүнийг дүгнэвэл судалгаанд оролцогчид тухайн тэтгэлэгт хамрагдсаны үр дүнд ИТХ хяналт тавих чадавхи сайжирсан байдлыг дунджаар 76.2% гэж үнэлсэн байна.

Эдгээрийг нэгтгэн зургаар харьцуулж харуулбал доорх байдалтай байна. Үүнд:

Зураг 56. Оролцогчид ИТХ-д олгосон тэтгэлгийг үр нөлөөг үнэлсэн үнэлгээ /хувиар/



Тэтгэлэгт хамрагдсан оролцогчдоос тэтгэлэгт хамрагдсанаар тухайн орон нутагт гарч буй өөрчлөлтийг түвшинг тэтгэлгийн зорилгодоо хүрсэн байдал, тэтгэлгийн үр дүнд ИТХ иргэдийг шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулах байдал болон ИТХ-ын хяналт тавих чадавхид гарсан өөрчлөлт гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэж, тус бүрд нь оноо тавьж дээрх хэсэгт оруулсан билээ. Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл тэтгэлгийн үр дүнд тухайн орон нутагт гарсан буй өөрчлөлтөд оролцогчид дунджаар 75.2% буюу 3.76 оноо өгч дүгнэсэн байна.

Тэтгэлгийн үр нөлөө нь сургалтуудын үр нөлөөнөөс харьцангуй доогуур байна. Ялангуяа тэтгэлэгт хамрагдсанаар ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдсэн байдалд оролцогчид хамгийн бага үнэлгээг өгсөн байна.

Төслийн тайланд тэтгэлэгт өрсөлдөх саналыг бичихээс эхлээд, хамтрагч, оролцогч талууд, иргэдийн оролцоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан гаргаж тайлагнах, тогтвортой байдлыг хангах зэрэг цогц, тасралтгүй үйл ажиллагаа бөгөөд ИТХ-уудын тэтгэлэг хэрэгжүүлэх чадавх ерөнхийдөө сул байсан ч төслийн хэрэгжилтийн явцад тодорхой хэмжээний ойлголт, мэдлэг, хандлагатай болж чадсан гэжээ. Түүнчлэн тэтгэлэгт шалгарсан дүүргийн ИТХ-ууд тэтгэлэг төсөл хэрэгжүүлэх туршлага, чадавх, хүний нөөцтэй боловч, тэтгэлгийг хэрэгжүүлэхэд хангалттай анхаарсангүй гэж дурдсан байв.

Тэтгэлгийн үр нөлөө харьцангуй сул байгаа нь тэтгэлэг өгчихөөд хэрэгжилтийн тайланг нь авсан боловч нарийвчлан шалгаагүйтэй холбоотой гэж үзсэн оролцогч ч байлаа.

Шигтгээ 21. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг ярилцлага

... Үр дүнг сайжруулахын тулд төслийн нэгжийн зүгээс тэтгэлэг авсан дүүрэг, аймаг сумдуудаараа тойрох, зөвлөлдөх, эргэх холбоотой байх, хяналтаа тавьдаг байвал зүгээр байх ...

Гэвч тэтгэлэгт хөтөлбөрийн үр нөлөө сул байгааг төслийн үйл ажиллагаатай шууд холбоотой гэж үзэх боломжгүй юм. Учир нь тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан ч тайлангаа хугацаанд нь явуулаагүйгээс тэтгэлгийн үлдсэн хэсгийг авах боломжгүй болсон ХУД-ийн ИТХ зэрэг хурлууд байх бөгөөд зарим ИТХ-ын төлөөлөгчид тухайн хурал өөрөө анхнаасаа буруу төлөвлөсөн, хэт өргөн хүрээг хамруулахаар оролдсоны улмаас тодорхой үр дүнд хүрч чадаагүй гэж хэлсэн байна.

Шигтгээ 22. Говь-Алтай аймаг, Шарга сум ярилцлага

... Манай сум “ИТХ-ын шийдвэрт-Иргэдийн оролцоо” сэдвээр тэтгэлэгт хамрагдсан. Тэтгэлгийн хүрээнд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх зорилго тавьж ажилласан боловч бид эхнээсээ хэт өргөн зорилго тавьсан байснаа сүүлд нь ойлгосон. Залуучуудын оролцоог дээшлүүлэх зорилгоор спорт, соёл урлагийн тэмцээн, уралдаан зэрэг арга хэмжээ зохион байгуулахад тухайн үедээ л залуучуудын идэвх харагдаж байсан боловч харамсалтай нь тогтмол үр дүнд хүрч чадаагүй. Тэгээд ч ер нь залуучууд болон эмэгтэйчүүд гэсэн хоёр бүлэг биш ядаж аль нэг бүлгийг сонгож, сумын хэмжээнд биш хэдхэн багийн хэмжээнд арга хэмжээ хэрэгжүүлсэн бол и лүү үр дүнтэй байх байжээ гэж бодсон ...

Гэвч ихэвчлэн анх удаа тэтгэлэг авсан ИТХ-ууд зарим алдаа, дутагдал гаргасан талтай боловч хоёр дахь удаагаа тэтгэлэг авахдаа алдаагаа зассан, тэтгэлгийн зарцуулалтыг илүү нарийн төлөвлөж чаддаг болсон, хэрэгжилтийн үр дүн илт сайжирсан зэрэг сайн талууд ч харагдаж байсан юм. Тухайлбал дээрх жишээнд дурдсан Говь-Алтай аймгийн Шарга сум “Хурлын хяналт- олон нийтийн аудит” сэдвээр 2018 онд дахин тэтгэлэг авсан бөгөөд энэ удаагийн тэтгэлгийг маш үр дүнтэй зохион байгуулж чадсан гэж үзсэн байна. Тухайлбал тус сумын ИТХ нь тэтгэлгийн хүрээнд чадавхжуулах сургалт зохион байгуулж сумын ИТХ-ын төлөөлөгчид, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөлийн гишүүд, хурлын дэргэдэх хороодын гишүүд, олон нийтийн аудитын албаны гишүүд зэрэг 21 хүнийг сургалтад хамруулжээ. Түүнчлэн тус аймагт “Төсвийн байгууллагуудын түлш халаалтын зардалд хяналт тавих журам” батлагдаж, төсөвт 5 байгууллагад хяналт үнэлгээ хийсэн байна.

Шигтгээ 23. Говь-Алтай аймаг, Шарга сум ярилцлага

... Төсвийн байгууллагын зардалд хяналт тавих ажлыг нүүрсний төсөвт хэмнэлт хийх боломжийг бүрдүүлэх ажлаар эхлүүлсэн. Сумын төсөвт байгууллагуудын түлш халаалтын зардал үр ашигтай байх боломжийг бүрдүүлж, нүүрснээс гарах хог хаягдал багасаж, энэхүү хог хаягдлыг зөөвөрлөхөд гардаг үр ашиггүй давхар зардлыг бууруулах, сайн чанарын нүүрс нийлүүлэгчидтэй гэрээ байгуулах, нүүрсний чанар, зарцуулалтад иргэд олон нийт байнга хяналт тавих зэрэг ажлыг хийж гүйцэтгэснээр мэдэгдэхүйц үр дүнд хүрсэн. Энэ ажлыг цаашид үргэлжлүүлж бусад байдлаар олон нийтийн хяналтыг сайжруулахаар төлөвлөж байгаа. Тэтгэлгийн үр дүнд сэтгэл хангалуун байгаа ...

Мөн УИХТГ-ын албан хаагчидтай хийсэн бүлгийн ярилцлагын явцад тус байгууллагын нэгэн төлөөлөгч “ИТХ болон ТББ-уудад олгосон тэтгэлэг үр дүнтэй болсон гэж үзэж байна. Учир нь тэтгэлэг авсан хурлууд нь тэтгэлэг аваагүй хурлуудаасаа хамаагүй илүү идэвхтэй, тайлан, тооцоо нь хүртэл илүү нээлттэй болсон байдаг нь анзаарагдаж байсан” гэж хэлсэн байна.

Эдгээрээс гадна Хөвсгөл аймагт эмэгтэйчүүдэд зориулсан сургалт, ярилцлаг зэрэг тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар ИНХ-д оролцох эмэгтэй гишүүдийн ирц 19 орчим хувиар нэмэгдсэн, Дундговь аймгийн Хулд сумын малчин өрх 449, мал бүхий 186 өрх Бэлчээр ашиглагчдын холбоонд элсэж, дундын хуримтлалын сантай болсон зэрэг энэхүү тайланд нэг бүрчлэн дурдах боломжгүй олон тооны эерэг жишээ судалгааны үр дүнд олдсон болохыг сайшаан дурдах нь зүйтэй гэж үзэж байна.

Харин тэтгэлэгт хамрагдсан талаар ИТХ-ын зарим төлөөлөгчид мэдээлэлгүй байсан, зарцуулалтын талаар сайн ойлголтгүй байсан зэрэг сөрөг мэдээллүүд

байсныг цаашид анхаарч, анх тэтгэлэг зарлахдаа тавьсан шалгуурын дагуу хэрэгжилтийг хянаж, баталгаажуулах арга хэмжээ хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

ТББ-д олгосон тэтгэлгийн үр нөлөө

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран ШХА-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн Хүрэх үр дүн 2-ын хүрээнд ИТХ-ын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор төрийн бус байгууллагуудад тэтгэлэг олгохоор үйл ажиллагааны төлөвлөгөөндөө 2016 оноос тасралтгүй тусгаж ирсэн байна. Энэхүү тэтгэлгийн хөтөлбөр нь олон талын үр өгөөжтэй ажил болжээ гэдэг нь фокус ярилцлагын судалгааг дүгнэхэд харагдаж байна. Судалгааг:

1. Төслийн хүрээнд ямар үр дүн, сайн туршлага бий болов
2. Төслийн үр дүнг цаашид тогтвортой явуулахад ямар санал, зөвлөмж байна вэ гэсэн 2 үндсэн асуудалд чиглүүлж ярилцав.

Бид 2016-2018 оны хооронд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан ТББ-уудаас Хил Хязгааргүй Алхам ТББ, Хөвсгөл Далайн Эзэд Хөдөлгөөн ТББ, Захиргааны Шинэ Санаачилга ТББ гэсэн 3 байгууллагыг дараах шалгуураар сонгож аван судалгааг гүйцэтгэв.

1. Төслийн хүрээнд шинэлэг, үр өгөөжтэй сайн туршлага бий болгосон эсэх
2. Байгууллагын чадавхи (тодорхой сэдвээрээ мэргэшсэн, орон нутгуудад ажиллаж байсан гэх мэт)
3. Тэтгэлэгт хөтөлбөрт оролцсон давтамж (2 ба түүнээс дээш удаа оролцсон)

1. Хил Хязгааргүй Алхам ТББ

Тус байгууллага нь тэтгэлэгт хөтөлбөрт 2016 оноос тасралтгүй хамрагдаж байгаа бөгөөд төслийн хүрээнд Дундговь, Дорноговь, Завхан, Төв аймагт уул уурхай, байгаль орчны чиглэлээр нэг талаас ИТХ-ын үйл ажиллагаанд хяналт тавих иргэдийг чадавхжуулах нөгөө талаас ИТХ-ын хороодыг чадавхжуулах гэсэн 2 чиглэлээр голчлон ажилласан байна. Хил хязгааргүй алхам ТББ нь тэтгэлэгт хөтөлбөрт жил дараалан оролцсоноор байгууллагын хувьд тодорхой чиглэлээр мэргэшиж, үндэсний хэмжээнд зөвлөгөө өгөх хэмжээнд бойжих боломж бүрджээ. ХХА ТББ-тай хамтран ажилласан Төв аймгийн ИТХ-ын төлөөлөлтэй ярилцаж байхад мэргэшсэн ТББ-тай хамтран ажиллах нь олон талаар давуу талтай гэдгийг онцлоод цаашид тус ТББ-тай тогтвортой хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах талаар судалж байна гэж байв. Харин ийм саналыг олон газраас хүлээж авч байгаа ТББ-ын хувьд санхүүгийн

хувьд ч хүн хүчний хувьд ч бололцоо сайнгүй байгааг Тэргүүн Б.Баярсайхан ярьж байлаа.

Шигтгээ 24. “ХХА” ТББ-ын Тэргүүн Б.Баярсайханы яриа

Туршлагаас харахад төлөөлөгчдийг төслийн хүрээнд чадавхжуулж байгаа нь тэдэнд суурь мэдлэг чадвар олгоход ач холбогдолтой. Үүний хажуугаар ТББ-уудад олгосон тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд ИТХ-ын чиг үүргийн хороодыг чадавхжуулах нь маш үр дүнтэй гэж харагдсан. Хурлын төлөөлөгчид (тэргүүлэгчид)-ийг харьяалах хороодын үйл ажиллагаатай нь уялдуулан сургаж, мэдээллээр хангавал хурлын үйл ажиллагаа илүү чанаржих боломж бий. Тодорхой асуудлаар хороодын саналыг урьдчилан авах зэрэг механизмыг хэрэглэхгүй асуудлыг ИТХ-ын хуралдаанд шууд задгай оруулж ирж байна. Эдийн засаг нийгмийн халамжийн ч юмуу боловсрол эсвэл байгаль хамгаалах асуудал хариуцсан хороодыг чадавхжуулж ажиллуулвал хурлаар хэлэлцэх, шийдвэрлэх асуудалд илүү нухацтай, судалгаатай, тогтвортой хандах боломж бий болно. Хороодыг ажиллуулах талаар холбогдох хууль тогтоомжид ерөнхий зохицуулалтууд байгаа. Хороодыг ажиллуулах төсөв орлогоо бүрдүүлэх боломж нь ч хурлуудад байгаа. ИХ-ын төлөөлөгч өөрсдийн итгэл үнэмшлээрээ улс төр хийж байгаа хүмүүс. Тэгхээр том зургаар нь харвал төлөөлөгчдөд хороодын үйл ажиллагаанд ороод, идэвхитэй ажиллах хүсэл зориг, эрмэлзлэл нь бас байдаг. Харин хууль тогтоомжид нийцүүлэн үндсэн чиг үүргийн хүрээнд нь төлөөлөгч нь хорооны ажилдаа нэн тэргүүний ач холбогдол өгөн ажиллах талаар зохицуулалт оруулж бодлогоор дэмжих нь чухал юм. Цаашид төлөөллийн байгууллагыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх энэхүү хөтөлбөр маань үргэлжлээд явбал бид иргэдийн хурлын хороодыг идэвхитэй ажиллуулах, мэргэшүүлэх тал дээр илүү төвлөрч ажиллах бодолтой байна. (ХХА ТББ-ын Тэргүүн Б.Баярсайханы ярианаас)

Тус ТББ-ын тэргүүний хэлж байгаагаар анх 2016 онд Захиргааны Ерөнхий Хууль ба Нийтийн Сонсголын Тухай Хууль батлагдсанаас хойш 2018 онд анх удаа Нийтийн сонсголын тухай хуулийг хэрэгжүүлэх жишиг семинарыг хэд хэдэн аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг байлцуулан хийсэн нь маш оновчтой арга хэмжээ болсон байна. Энэ нь тэтгэлэгт хөтөлбөрийн нэг үр дүн яахын аргагүй мөн юм. Уул уурхай, байгаль орчны хяналтын асуудлаар хийсэн уг сонсголын ажиллагаанд оролцсон ИТХ-ууд нийтийн сонсголыг хийхдээ яам, агентлагийг ч татан оролцуулан хийх боломжтой төдийгүй аймаг, сумдууд нийтлэг асуудлаараа хамтран ажиллах нь зүйтэй гэдгийг олж харсан нь уг нийтийн сонсголыг илүү ач холбогдолтой болгосон байна. Тухайлбал, Төв болон Дундговь аймгийн ИТХ-ууд өөр өөрсдийн нутаг дэвсгэрт үлийн цагаан оготонтой олон жил тэмцэж ирсэн нь үр дүн муутай байгааг олж харснаар 2019 онд Нийтийн сонсгол хамтран зохион байгуулжээ. Үр дүнд нь үлийн цагаан оготныг устгах төлөвлөгөө гаргаж төсөв, зардлыг хамтран шийдэхээр болжээ.

Дээрх жишээнээс харахад мэргэшсэн ТББ-ууд тухайн орон нутгийн асуудлыг илүү өргөн хүрээнд олж харж чадахаас гадна хууль тогтоомжийн зохицуулалтыг

практикт хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх талаар өргөн хүрээнд, бодлогын түвшинд зөвлөн ажиллаж чаддаг тул нэн ялангуяа орон нутгийн НӨУБ-уудад хамтран ажиллах итгэл үнэмшил, хүсэл эрмэлзлэл төрүүлдэг байна.

2. Хөвсгөл Далайн Эзэд Хөдөлгөөн ТББ

ХДЭХ ТББ нь 2017 онд „Оролцооны гэрээ байгуулан хэрэгжүүлэх замаар ИТХ-ын чадавхыг дээшлүүлэх-үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, нөлөөллийн ажил” төсөл, 2018 онд „Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газар дахь газар олгох үйл явцыг иргэдийн оролцоотойгоор ил тод нээлттэй болгох нь” төсөл бичиж тэтгэлэгт хөтөлбөрт амжилттай оролцсон байна.

Тус ТББ нь байгаль орчин, уул уурхайн асуудлаар томоохон ашиг сонирхлын зөрчилтэй хэргүүдэд нөлөөлөл болон стратегийн өмгөөллийн хүрээнд өргөн цар хүрээнд хийдэг туршлагатай байгууллага гэдэг нь ярилцлагаас харагдаж байлаа. 2018 онд хэрэгжүүлсэн төслийн хувьд байгууллагын үйл ажиллагааны онцлог, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх өөрийн арга зүйг нилээн чадмаг ашигласан нь сайн туршлага болхуйц ажил болжээ гэж харагдаж байна. Хөвсгөл нуурын эргэн тойронд хууль бус газар ололт, хээл хахуулийн шинжтэй үйлдэл хит их газар авснаар нутгийн иргэдийн эрх ашиг зөрчигдсөөр ирсэн боловч төвийн болон орон нутгийн захиргааны байгууллагын зүгээс дорвитой арга хэмжээ авч ирээгүй байна. Хүч хомс, цөхөрсөн иргэдийн дуу хоолойг олон нийтийн сонорт хүргэхэд хэвлэл мэдээлэл, сэтгүүлчидтэй хамтран ажилласан нь үр дүнд хүргэжээ. Тухайлбал, 2018 онд Алаг Эрдэнэ сумын ИТХ-тай хамтран Хөвсгөлийн байгалийн цогцолбор газар дахь газар олголтын асуудлаар Ерөнхий Хяналтын Сонсгол хийж энэ талаараа 3 мэдээ, 2 нийтлэл, 2 нэвтрүүлгийг 1 сонин, 6 телевиз, 3 вэбсайт болон олон нийтийн сүлжээгээр нийтэд хүргэж, төр засаг болон олон нийтийн анхаарлыг хандуулсан байна. Дээрх нөлөөллийн ажлын үр дүнд иргэдийн өвөлжөө, хаваржааны газрыг хууль зөрчин хураан авсан Засаг даргын шийдвэрийг цуцлуулж эрхийн бичгийг шинээр олгуулах, дээд шатны захиргааны байгууллагад нь гомдол мэдүүлснээр илт хууль бус аргаар газрын эрхийг нь булаан авсан албан тушаалтанд хариуцлага тооцуулж чадсанаар эрх ашгаа хамгаалан хяналт тавьж, хамтын оролцоог хэрэгжүүлж чадвал үр дүнд хүрч болно гэдэг итгэл үнэмшлийг иргэдэд өгч чадсан байна.

Шигтгээ 25. “ХДЭХ” ТББ-ын Төслийн хүрээнд бичсэн тайлангаас, 2018 он

Хатгал тосгоны иргэдэд УИХ-ын ӨБХ-д өргөдөл хэрхэн гаргах аргыг зааж, өргөдөл бичих компанит ажил зохион байгуулснаар өнөөдрийн байдлаар 215 өргөдөл хүргүүлээд байгаа бөгөөд 800 өргөдөл хүргэхээр үргэлжлүүлэн ажиллаж байна.

Тус байгууллагын хувьд төслийн хүрээнд бий болгосон өөр нэг сайн туршлага нь „УИХ-ын ӨБХ-д хандах аргаар иргэд төрийг удирдах хэрэгт оролцох арга зам“ сургалтын шинэ модуль, хөтөлбөр, арга зүйг боловсруулсан явдал юм.

3.Захирааны шинэ санаачилга ТББ

ЗШС ТББ нь тэтгэлэгт хөтөлбөрт 2017, 2018, 2019 онд амжилттай оролцсон байна. Тус ТББ-ын 3 жил дараалан төсөлд өгсөн санал, төслийн гүйцэтгэлээс харахад иргэдийн төлөөлөгчдийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтын чиг үүргийг гүйцэтгэхэд идэвхжүүлэх, зохион байгуулах, сургалт сурталчилгааны ажилд арвин туршлага хуримтлуулсан нь төслөө амжилттай хэрэгжүүлэхэд суурь болжээ.

Иргэдийн хяналтын бүлэг байгуулж түүгээр дамжуулан НӨУБ-ын төсвийн хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоотой чадавхжуулах зорилгыг тавин ажилласан байна. Төслийн хүрээнд иргэдийн хяналтын бүлгүүдийг Сүхбаатар дүүргийн хэд хэдэн хороод, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумд байгуулсан байна. Тус ТББ-ын төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг онцлог нь тасралтгүй, эргэх холбоотой ажилладагт байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд анх 2017 онд „Төсөвт хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд төлөөлөгчдийг чадавхжуулах, Нийтийн сонсголын тухай хуулийг хэрэгжүүлэхэд суралцах“ гэсэн сэдвээр хэрэгжүүлсэн байна. 2019 оны 06 дугаар сард Сүхбаатар суманд дахин очиж хяналтын бүлгүүдээр давтан сургалт хийж өгсөн байна. 2019 онд хэдийгээр өөр газарт төсөл хэрэгжүүлж байсан ч ийнхүү хийсэн ажлын үр дүнгээ баталгаажуулж санаачилгаараа ажилласны үр дүнд тус суманд иргэдийн хяналтын 8 бүлэг тогтвортой ажиллаж байгаа ажээ.

Шигтгээ 26. “ЗШС” ТББ-ын Гүйцэтгэх захирал С.Цэрэнпүрэвийн яриа

Иргэдийн хяналтын бүлгүүд заавал төсөв, төсөлтэй холбоотой том бодлогын асуудлаар биш өдөр тутамд тохиолдож байдаг асуудлаар маш энгийн аргаар ч иргэд хяналт тавьж болно гэдгийг ойлгон хэрэгжүүлж байгаа нь бидэнд маш сайхан санагдаж байгаа. Жишээ нь: иргэдийн оршин суугаа газарт ойр барилга баригдаж байхад аюулгүй ажиллагааны дүрэм, журам хир хэрэгжиж байгаа, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг стандартын дагуу хэрэглэж байгаа эсэхт иргэд газар дээр нь очоод ажиглалт, хяналт тавьсан туршлага байна. Энэ нь иргэд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэхийн тулд өөрсдөө хяналт тавьж, шаардлагаа зохих газарт хүргүүлэх талаар санаачилгатай ажиллаж болохыг ойлгож, урамшсаны илрэл юм.

Төслийн хүрээнд дээр дурлсан ажлын үргэлжлэл болгож Захиргааны Шинэ Санаачилга ТББ нь төслийн хүрээнд 2019 оны 12 дугаар сарын 10д „Орон нутгийн төлөөлийн байгууллагын хяналтын чиг үүргийг иргэдийн оролцоотой чадавхжуулах нь“ гэсэн үндсэн сэдвээрээ туршлага солилцох хэлэлцүүлгийг Нийслэлийн ИТХ-тай хамтран Улаанбаатар хотод зохион байгуулсан байна. Уг хэлэлцүүлэгт төсөл өмнө

хэрэгжсэн, одоо хэрэгжиж байгаа НӨУБ-ын төлөөллүүдийг оролцуулан хийжээ. Жишээ нь: орон нутгаас Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ИТХ-ын дарга Ц.Ариунтуяа „ИТХ-ын дэргэд иргэйн хяналтын бүлэг байгуулсан арга, туршлага“ сэдвээр илтгэл тавьж оролцсон байна.

Зураг 57. Илтгэлийн постер



Төсөлд 3 жил дараалан хамрагдсан уг байгууллагын хувьд гол сэдэв болох „Иргэдийн хяналтын бүлэг“-ийг тогтвортой барьж НӨУБ болон иргэдтэй харилцан эргэх холбоотой ажилладаг, эргээд олон газарт байгуулагдсан хяналтын бүлгүүд уулзалдах, харилцан туршлага солилцох бололцоогоор ийнхүү хангаж өгдөг нь авуштай туршлага болсон байна.

Дэд бүлгийн дүгнэлт

Төслөөс ИТХ-уудын дунд сонгон шалгаруулалт зарлаж тэтгэлэг олгосон үйл ажиллагаа нь сургалтын үйл ажиллагаанаас харьцангуй доогуур үнэлэгдсэн боловч тус хөтөлбөрийн хүрээнд олон сайн туршлага бий болсон, ИТХ-уудын үйл ажиллагаа мэдэгдэхүйц дээшилсэн, ялангуяа хурлуудын хяналтын чадавх сайжирсан байх тул тэтгэлэгт хөтөлбөр нь эерэг үр нөлөөтэй үйл ажиллагаа болсон гэж дүгнэж байна. ИТХ-д олгосон тэтгэлгийн үр нөлөөг дээшлүүлэх асуудлаар доорх зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:

1. ИТХ-д тэтгэлэг олгохдоо тавьсан шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг тэтгэлгийг хэрэгжүүлэх явцад хянах, баталгаажуулах арга хэмжээ авах.
2. ИТХ-д тэтгэлэг олгохдоо хэрэгжилт болон санхүүгийн зарцуулалтыг зөв төлөвлөсөн эсэхэд санхүүгийн болон холбогдох бусад мэргэжилтнээр дүгнэлт гаргуулах боломжийг судлах.
3. Тэтгэлэгт хөтөлбөрт ирүүлсэн төслийн саналыг шаардлагатай бол зарим байдлаар өөрчлөх боломжийг бүрдүүлж алдаатай төлөвлөгөөг засаж сайжруулах боломжийг бий болгох.

ТББ-уудад олгосон тэтгэлэгт хөтөлбөр ч мөн өндөр үр нөлөөтэй ажил болсон байна. Тэтгэлэг авсан ТББ-уудын туршлага, санал дүгнэлтийг сонсож байхад төслийн үр дүн маш эерэг бөгөөд төслийг цаашид тогтвортой үргэлжлүүлэх талаар ТББ-ууд болон тэдэнтэй хамтран ажилласан иргэд, төлөөллийн байгууллагуудын хүсэл зориг нэг байлаа. Түүнчлэн төсөл хэрэгжүүлэх цаг хугацааны хувьд сонгон шалгаруулалт оройтож зарладаг тул зарим талаар үйл ажиллагаанд саадтай, тохиромжгүй байдаг, төсөв мөнгөний хүрэлцээ, тайлан тооцооны хувьд зарим нэг санаа авхаар зүйл байдаг талаар дурдаж ярьж байлаа. Гэвч холбогдох санал хүсэлтээ төрийн бус байгууллагууд

төслийн тайланд дурдсан гэсэн тул давхардуулахгүйн үүднээс тэдгээр саналыг тухайлан үл дурдан дараах зөвлөмжийг санал болгож байна.

1. Үндэсний хэмжээнд ажиллах, мэргэшсэн төрийн байгууллагыг төслийн хүрээнд олноор бойжуулахын тулд төслийн сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэхэд анхаарах.

2. Төслийн үр, дүн сайн туршлагыг тогтвортой хэрэгжүүлэх үүднээс тухайн хөндөж буй сэдвээр бодлогын судалгааг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж шаардлагатай бол холбогдох хууль тогтоомж, төсөв, төлөвлөгөөнд нь өөрчлөлт, шинэчлэлт хийх ажлыг төслийн зохион байгуулагчид анхаарах.

3. Төслийн баримт бичигт дурдсан тоо баримтаас харахад тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахыг хүссэн ИТХ-ын санал маш их боловч төсөлд хамрагдаж байгаа нь харьцангуй цөөн байна. Иймд төсөл хэрэгжүүлэх хүсэлтэй талуудын эрэлт хэрэгцээг нь харгалзан нэг мэргэшсэн ТББ-ын хувьд хэд хэдэн ИТХ-тай хамтран ажиллах байдлаар төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулвал төслийн үр дүн илүү хүртээмжтэй байх боломж байна гэж харж байна.

1.6 УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх ажлын үр нөлөө

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу УИХ-ын Тамгын газарт шинэ чухал чиг үүргүүд нэмэгдэж байгаа энэ үед төсөл хэрэгжиж байгаа нь цаг үеэ олсон арга хэмжээ болсон гэж үзэж байна. УИХ-ын Тамгын газар хууль тогтоомжийн хуулийг нэг мөр сахин мөрдүүлэхэд гарч буй зарим асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч байгааг судалгааны үр дүнд илрүүлсэн бөгөөд төслийн үр нөлөө харьцангуй сайн байсан нь баримт бичгийн судалгаанаас ажиглагдаж байв.

УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагааг чадавхжуулах төслийн зорилтын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийхдээ туршлага судлах, нийтийн сонсгол зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах үйл ажиллагаа тус бүрийн үр нөлөөг тодорхойлох зорилгоор баримт бичгийн судалгаа хийж, тус судалгааны үр дүнг баталгаажуулахаар УИХТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай фокус бүлгийн ярилцлага хийсний үндсэн дээр энэхүү дэд бүлгийн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан болно.

Туршлага судлах хөтөлбөрийн үр нөлөө

Туршлага судлах хөтөлбөрийн хүрээнд УИХТГ-ын албан хаагчид Монгол Улсад айлчлан ирсэн Швейцарийн Холбооны улсын Парламентын Тамгын газрын төлөөлөгчидтэй туршлага солилцох, УИХ-ын гишүүд болон УИХТГ-ын албан хаагчид Швейцарь, Польш улсуудад очиж хууль тогтоох болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаатай биечлэн танилцах ажлуудыг зохион байгуулжээ.

Төслийн 2017 оны үйл ажиллагааны хүрээнд Швейцарийн Холбооны Улсын парламентын Тамгын газрын төлөөлөгчид УИХТГ-ын албан хаагчидтай парламентын

хууль тогтоох, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр харилцан туршлага солилцжээ. Туршлага солилцох уулзалт семинарт ШХУ-ын талаас парламентын Тамгын газрын техникийн хамтын ажиллагааны төсөл, Байнгын хороо, Хяналт шалгалтын нэгжийн зөвлөх, ажилтнууд, манай улсаас УИХ-ын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ажилтнууд оролцсон байна. Харин тус семинарын явцад “Улс төрийн тогтолцоо, төрийн байгуулал”, “Хоёр улсын парламентын бүтэц, зохион байгуулалт, бүрэн эрх” сэдвийн хүрээнд хоёр орны парламентын Тамгын газрын алба хаагчид илтгэл тавьж, харилцан сонирхсон асуултдаа хариулт авч, мэдээлэл солилцсон байна.

Хамтын ажиллагааг 2018 онд үргэлжүүлж УИХ-ын Тамгын газраас сонгон авсан Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх талаар ШХУ-тай УИХТГ-ын албан хаагчид хамтран ажиллажээ. Үүнтэй холбоотойгоор УИХ-ын Тамгын газар болон Швейцарын парламентын төлөөлөгчид 2018 оны 6 дугаар сарын 4-8-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо хамтарсан сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

Түүнчлэн Хууль, эрх зүйн хэлтсийн зөвлөхүүдийн хуулийн төслийн эхийг барьж ажиллах чадавхыг сайжруулах чиглэлээр “Хуулийн төсөл боловсруулах, хууль тогтоох ажиллагаанд эрх зүйн туслалцаа үзүүлэх чадавхыг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулав. Хуулийн төслийн агуулга бүтээх буюу төсөл боловсруулах, хууль тогтоох ажиллагаанд хууль зүйн техникийг хэрэглэх онол, орчин үеийн чиг хандлага, батлагдсан хуулийн хэлний болон үг зүйн алдаа, тэдгээрийг засварлах зэрэг сэдвээр мэргэшсэн судлаачид сургалт явуулжээ.

Хөтөлбөрийн үр дүнд УИХ-ын Тамгын газар, Швейцарийн Холбооны Улсын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны эхлэлийг тавьж, хуулийн төсөлтэй ажиллах, хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр аргачлал, гарын авлага хамтран боловсруулж, эдгээр үйл ажиллагаанд шинэ жишиг тогтоож чадсан гэж төслийн зүгээс үзжээ. Энэ талаар УИХТГ-ын албан хаагчдаас асуухад мөн л энэхүү үр дүнг дэмжсэн хариултуудыг өгсөн юм. УИХТГ-ын албан хаагчид ялангуяа хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажилд ШХУ-ын парламентын төлөөлөгчидтэй хамтран боловсруулсан аргачлал үр дүнтэй байсан талаар хэлж байв.

Шигтгээ 27. УИХТГ-ын албан хаагчидтай хийсэн ярилцлага

ШХУ-ын парламентын төлөөлөгчидтэй хамтран ажилласны үр дүнд бидний академик судалгааны чадвар дээшилж, өмнө хийж, төсөөлж байсан үйл явц маань дутуу байсан нь илэрсэн. Одоо сайжруулсан байдлаар тодорхой аргачлал боловсруулж батлахад бэлэн болсон байгаа. Хууль тогтоомж боловсруулах нь өөрөө маш нарийн ажиллагаатай, цогц аргачлалын дагуу хийх үйл ажиллагаа

гэдгийг бид ойлгож авсан. Тухайлбал хуулийн төсөл сайн болсон, муу болсон гэж ярих төдий байсан бол сургалтуудад суугаад сайн, муу гэдгийг нь хэрхэн үнэлэх талаар маш сайн ойлголттой болсон.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажилд туршлага судлах хөтөлбөрийн үр дүнг хэрхэн ашигласан талаар асуухад УИХТГ-ын албан хаагчид тодорхой хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг судлахад ашигласан талаар хэлж байлаа.

Шигтгээ 28. УИХТГ-ын албан хаагчидтай хийсэн ярилцлага

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд хоёр өөр аргачлалаар үр нөлөөний үнэлгээг хийж үр дүнг хооронд нь харьцуулан судалсан. Үүнээс ЗГ-ын 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалаас илүүгээр ШХУ-ын парламентын төлөөлөгчидтэй хамтран боловсруулсан аргачлалын дагуу үр нөлөөний үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй байгаа нь илэрхий болсон. Иймд энэ аргачлалыг албан ёсоор баталж ашиглахаар төлөвлөж байгаа.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) хамтран УИХ-ын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга болон Эрх зүйн шинжилгээний албаны 6 ахлах зөвлөхийг 2017 оны 06 дугаар сарын 04-12-ны өдрүүдэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-д сургалтад хамруулав. Сургалтын зорилго нь ХБНГУ-ын хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалыг хэрэглэдэг туршлагыг судлах байв. Дээрх сэдвийн хүрээнд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал арга, технологитой нарийвчлан танилцаж суралцжээ.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэх чиг үүрэг бүхий УИХ-ын Ажлын хэсгийн гишүүд хотын эрх зүйн байдал, орон нутгийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх субъектыг сонгох болон томилох асуудал, орон нутгийн өмчийн удирдлага, татварын чиглэлээр бусад улс орны туршлагыг судалж, мэдээллийг Ажлын хэсгийн хэлэлцүүлэгт танилцуулж, хамтран ажиллажээ. ИТХ-ын үйл ажиллагааг бэхжүүлэх сайн туршлагаас суралцах зорилгоор аймгийн 2018 онд ИТХ-ын дарга нар хөгжиж буй орны /Филиппин, Польш/ нутгийн удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, орон нутгийн бодлого төлөвлөлт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд нутгийн удирдлагын байгууллагаас тавих хяналтын талаар туршлага судалж, шинэ хуулийн үзэл баримтлалд эдгээр улс орны сайн туршлагаас тусгах саналыг боловсруулж байна.

Шигтгээ 29. УИХТГ-ын албан хаагчидтай хийсэн ярилцлага

Гадаадад туршлага судалсан арга хэмжээний хувьд би Польш улсад очиж туршлагаас нь судалсан. Ингэхдээ нутаг дэвсгэрийн хамгийн бага нэгжээс эхлэн үйл ажиллагаатай нь танилцаж туршлага судалсан. Бидний хувьд чиг үүргүүдийг хэрхэн ялгаж, салгаж хэрэгжүүлж байгаа бодит туршлагыг судалсан нь маш чухал ач холбогдолтой байсан.

Туршлага судлах хөтөлбөрийн хувьд УИХТГ-ын удирдах албан тушаалтан, УИХ-ын гишүүдийг туршлага судлах хөтөлбөрт хамруулах байдал илүү байгаа тул цаашид мэргэшсэн албан хаагчид, төрийн жинхэнэ албан тушаалтнуудыг ийм сургалтад илүү олноор хамруулж, туршлага судлах ажиллагаанд оролцуулах нь илүү үр дүнтэй юм.

Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд зөвхөн нэг байнгын хороо, УИХТГ-ын тодорхой нэг хэлтсийг хамруулахад чиглэсэн байгааг өөрчилж, цаашид өөр өөр байнгын хороо, хэлтэс, албадын төлөөлөгчдийг жигд хамруулах талаас нь илүү анхаарах нь зүйтэй байна.

Холбогдох байнгын хорооноос хуулийн төслөөр нийтийн сонсгол зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

Нийтийн сонсгол зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр төслийн хэрэгжилтийн эхний үе шатанд видео хурлын төхөөрөмжийг 21 аймагт суурилуулан хүлээлгэн өгсөн бөгөөд тус төхөөрөмжийг ашиглан доорх сэдвүүдээр олон нийтийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулжээ. Үүнд:

- Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хүрээнд УИХ-ын гишүүд, аймаг, нийслэлийн төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтнуудын оролцсон цахим хурал;
- УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Өргөдлийн байнгын хорооны 2016 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг сонсох тухай асуудлыг хэлэлцсэн байна.

Нийтийн сонсголын хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах УИХ болон УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Бүгд Найрамдахчуудын Олон улсын хүрээлэн (БНОУХ)-тэй хамтран “Нийтийн сонсголыг үр дүнтэй зохион байгуулах нь” сэдэвт сургалт, туршлага судлах үйл ажиллагааг 2018 оны 12 дугаар сарын 10-19-ний хооронд Улаанбаатар болон Сөүл хотноо зохион байгуулав. Энэ арга хэмжээ нь нийтийн сонсголын эрх зүйн зохицуулалт, тулгарч буй сорилт, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, энэ талаарх АНУ болон

БНСУ-ын сайн туршлагаас суралцах зэргээр нийтийн сонсгол зохион байгуулах чиглэлээр хууль тогтоогчид болон УИХ-ын Тамгын газрын зөвлөх, ажилтнуудыг чадавхжуулахад чиглэв.

УИХТГ-ын албан хаагчдын зүгээс сонсголын явцад иргэд үг хэлэх боломжгүй байдал нь зарим талаар сөрөг нөлөөтэй байгааг дурдсан бөгөөд орчуулагчийн зардал, хоол болон цайны завсарлагын зардал маш өндөр байгааг цаашид анхаарч сайтар төлөвлөх шаардлагатай гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байна. Мөн туршлага судлах зорилгоор нийтийн сонсгол зохион байгуулахдаа урьж оролцуулах илтгэгчийн ярилцах сэдэв, илтгэлийн агуулгыг урьдчилан анхаарах шаардлагатай байгаагаа хэлжээ.

Нийтийн сонсголын явцад олж авсан сайн туршлагуудаас асуухад нийтийн сонсголын үед бодитой, үнэн зөв мэдээлэл авах боломж бүрддэг, хэт туйлширсан эсвэл бусдад таалагдах гэсэн мэдээлэл өгдөггүй, яг тодорхой асуудлаар хариуцлага хүлээх үүрэг бүхий этгээд нь албан ёсны мэдээлэл хийж байгаа нь онцгой ач холбогдолтой байсан гэж хариулсан байна. Түүнчлэн хэлэлцүүлгийг явуулах туршлагатай болсон нь өөрөө сайн туршлага бөгөөд ингэхдээ зохион байгуулахын тулд туршилтын загвар хурлыг зохион байгуулж гарч болох асуудлыг урьдчилан харах гэж оролдсон нь үр дүнтэй байсан гэжээ.

Цаашид нийтийн сонсгол зохион байгуулах үйл ажиллагааг хэрхэн сайжруулбал зохих талаар асуухад нийтийн сонсгол зохион байгуулахдаа судалгаанд тулгуурлан мэдээлэл өгөх оролцогчийг хэрхэн зөв сонгох талаар бусад улсын туршлагыг судлах, мэдэж авах шаардлагатай байгаа тул энэ талаар төслийн зүгээс дэмжлэг үзүүлбэл хэрэгтэй байна гэж хариулсан байна.

Мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах үйл ажиллагааны үр нөлөө

Энэхүү судалгаагаар үнэлж байгаа Төслийн үйл ажиллагааны хүрээнд УИХТГ-т одоогийн байдлаар доорх мэдлэгийн бүтээгдэхүүнийг хүргүүлсэн байна. Үүнд:

1. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ /2016/, (дахин хэвлэсэн)
2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ
3. “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” тайлан
4. Хууль зүйн техник. Т.В.Кашанина, 2016
5. Хууль тогтоомжийн төсөл боловсруулагчийн ширээний ном: практик гарын авлага
6. Бүгд Найрамдах Финланд Улсын Үндсэн хууль
7. Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль

8. Австрали Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг
9. Бүгд Найрамдах Франц Улсын Үндэсний Ассамблейн хуралдааны дэг
10. Бүгд Найрамдах Финланд Улсын парламентын хуралдааны дэг
11. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн хуралдааны дэг
12. Оросын Холбооны Улсын Төрийн Думын регламент
13. Канад Улсын парламентын акт
14. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн үйл явцыг шалгах хуудас

Юуны өмнө 2017 онд зарим улсын парламентын хуралдааны дэгийг орчуулж хүргүүлсэн бөгөөд энэ нь УИХ-ын дэгийг өөрчлөхөд ашиглагдахаар төлөвлөсөн гэж үзэж байна. Тодруулбал төслийн хүрээнд ХБНГУ, ОХУ, БНСУ, Финланд (Үндсэн хууль болон парламентын хуралдааны дэг), Франц, Австрали, Канад зэрэг 7 улсын парламентын хуралдааны дэгийн орчуулж хэвлүүлсэн байна. Дэгийн орчуулгыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр олон нийтийн хүртээл болгож судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах бөгөөд энэ нь хууль тогтоогч, эрдэмтэн, судлаачид болон практик ажилтнуудад арга зүйн өндөр ач холбогдолтой судалгааны үндсэн эх сурвалж болж хэрэглэгдэх нөхцөл бүрдэнэ гэж Төслийн зүгээс дүгнэсэн байна. Ярилцлагын судалгааны явцад УИХТГ-ын албан хаагчид ч эдгээр мэдлэгийн бүтээгдэхүүнийг Төслийн хүлээлтийн дагуу ашигласан болохыг баталж байсан юм.

Шигтгээ 30. УИХТГ-ын албан хаагчидтай хийсэн ярилцлага

Финлянд, Солонгос, Австрали зэрэг улсуудын харьцуулсан судалгааны материалуудыг хэрхэн ашиглаж байгаа талаар тоо баримт хэлэхэд хэцүү. Гэхдээ эдгээрийг манай албан хаагчид болон УИХ-ын гишүүд шаардлагатай үед уншиж судалсан нь харагдаж байсан. Жишээ болгож хэлэхэд УИХ-ын дэг батлахад ялангуяа эдгээр материалыг бүх хүн л уншиж, судалж байсан нь хэлэлцүүлгийн явцад ойлгомжтой байсан.

Мөн 2018 онд “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд бий болох гарын авлага, судалгааны шинжилгээний бүтээгдэхүүнийг сургалтын хөтөлбөрийн агуулгатай уялдуулах ажлыг хийжээ. Төслийн 2018 оны тайланд төслийн хүрээнд боловсруулж буй Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон нийтийн, хувийн эрх зүйд хамаарах салбарын хуулийн төсөл боловсруулах гарын авлага, хуулийн төсөл боловсруулагчийн ширээний ном (орчуулгын бүтээгдэхүүн), 7 улс орны парламентын хуралдааны дэг (орчуулгын бүтээгдэхүүн), парламентын хуралдааны дэгийн харьцуулсан судалгаа зэрэг нь УИХ-ын Тамгын

газрын зөвлөх, ажилтны сургалтын практикт нэвтэрч, байнга хэрэглэгдэх эх сурвалж болох нөхцөл бүрдсэн гэж дүгнэсэн байна.

Эдгээр мэдлэгийн бүтээгдэхүүнийг тогтмол ашиглаж байгаа эсэхийг асуухад УИХТГ-ын албан хаагчид мөн л байнга хэрэглэгдэх эх сурвалж болж чадсан гэж хариулсан юм.

Шигтгээ 31. УИХТГ-ын албан хаагчидтай хийсэн ярилцлага

Үндсэн хуулийн дүн шинжилгээ гэсэн гарын авлагыг маш өргөн ашиглаж байгаа. Ялангуяа УИХ-ын гишүүд маш их ашиглаж байсан. Зарим гишүүдэд олдохгүй байсан тул бид дахин хэвлүүлсэн. Мөн Монгол хэлээр орчуулсан Үндсэн хуулиудыг УИХ-ын гишүүд маш сайн судалж, МУ-ын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад Норвеги болон Финланд улсын үндсэн хуулийн баялгийн сантай холбоотой зүйл, заалтуудын тодорхой хэсгийг жишиг болгон ашигласан сайн туршлага байгаа. Тухайн үедээ маш хэрэгцээтэй байсан гэдэг нь үүнээс харагдана.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад ашиглах эх сурвалжаар хангах хүрээнд “The Legislative Drafters deskbook: A practical guide” номын орчуулж, хэвлүүлсэн байх бөгөөд энэхүү бүтээл нь хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны арга зүй, онцлогтой холбоотой өргөн агуулгын хүрээнд онолын суурь ойлголт, практик зөвлөмжүүдийг агуулснаараа хуулийн төсөл боловсруулагчдад (хууль тогтоогчид, хууль тогтоох байгууллагын ажилтан, эрдэмтэн, судлаачид гэх мэт) чухал ач холбогдолтой гэж Төслийн тайланд дурджээ. Ярилцлагын судалгааны оролцогчид ч энэхүү бүтээлийг ашиглаж байгаа гэж хариулсан юм.

Шигтгээ 32. УИХТГ-ын албан хаагчидтай хийсэн ярилцлага

Зөвхөн УИХТГ-ын албан хаагчид, УИХ-ын гишүүдээр тогтохгүй багш, судлаачид маш их асууж, сураглаж байгаа. Харамсалтай нь олдоц нь тийм ч сайн биш байна.

Дээр дурдсанаас бусад мэдлэгийн бүтээгдэхүүнүүд ч тогтмол ашиглах эх сурвалжууд болж чадсан болохыг УИХТГ-ын албан хаагчид хэлж байв. Тухайлбал тус байгууллагын нэгэн албан хаагч “МУЗЗНДНТУТХ-ийн дүн шинжилгээ гэсэн энэ гарын авлага нь үндэсний тэргүүлэх эрдэмтэн судлаачдын боловсруулсан улс орны хэмжээнд гаргасан цорын ганц цогц судалгаа бүхий гарын авлага болж чадсан гэж үзэж байна. Зөвхөн энэ удаагийн үйл ажиллагаанд ч биш дараа дараагийн сонгуулийн үед ч хэрэглэгдэх маш сайн бүтээл болсон” гэж хэлжээ.

Шигтгээ 33. УИХТГ-ын албан хаагчидтай хийсэн ярилцлага

“Хууль зүйн техник” номын хувьд хууль тогтоомжийн төсөл бэлтгэхэд оролцдог бүх хүн уншсан байх шаардлагатай, суурь мэдлэг өгөхөд чиглэсэн маш өгөөжтэй бүтээлийг орчуулж өгсөнд баяртай байгаа.

Төслийн зүгээс ШХА-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр УИХТГ-т хүргүүлсэн мэдлэгийн бүтээгдэхүүн тус бүрийн тогтмол ашиглагдах байдлыг тодруулах зорилгоор УИХТГ-ын албан хаагчдаас анкетын судалгаа авч тандан судлахад

Оролцогчдын нийт мэдлэгийн бүтээгдэхүүнийг ашиглаж байгаа байдлыг дараах хүснэгтэд харуулав. Үүнд:

Хүснэгт 8. Оролцогчдын мэдлэгийн бүтээгдэхүүнийг ашиглаж байгаа түвшин

№	Мэдлэгийн бүтээгдэхүүн	Ашиглаж буй түвшин	Үнэлгээ	
			Оноо	Хувь
1	Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ /2016/, (дахин хэвлэсэн)	Тогтмол ашигладаг	4.33	86.7
2	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” зөвлөмж		4.00	80.0
3	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ	Ерөнхийдөө ашигладаг	3.83	76.7
4	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” тайлан		3.67	73.3
5	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн үйл явцыг шалгах хуудас		3.17	63.3
6	Бүгд Найрамдах Финланд Улсын парламентын хуралдааны дэг	Заримдаа ашигладаг	3.00	60.0
7	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн хуралдааны дэг		3.00	60.0
8	Оросын Холбооны Улсын Төрийн Думын регламент		3.00	60.0
9	Хууль тогтоомжийн төсөл боловсруулагчийн ширээний ном: практик гарын авлага		2.83	56.7

10	Австрали Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг		2.83	56.7
11	Канад Улсын парламентын акт		2.83	56.7
12	Бүгд Найрамдах Финланд Улсын Үндсэн хууль		2.67	53.3
13	Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль		2.67	53.3
14	Бүгд Найрамдах Франц Улсын Үндэсний Ассамблейн хуралдааны дэг		2.67	53.3
Дундаж үнэлгээ			3.18	63.6

Зураг 58. Оролцогчдоос мэдлэгийн бүтээгдэхүүний ашиглагдахуйц байдалд өгсөн үнэлгээ /Бүтээгдэхүүн тус бүрээр/



Дээр зургаас үзэхэд судалгаанд оролцогчид Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ /2016/ (86.7% буюу 4.33 оноо), “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” зөвлөмж(80.0% буюу 4.0 оноо)-ийг тогтмол ашигладаг гэж хариулсан бол Бүгд Найрамдах Финланд Улсын Үндсэн хууль, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль, Бүгд Найрамдах Франц Улсын Үндэсний Ассамблейн хуралдааны дэг-ийг заримдаа л ашигладаг буюу эдгээрийн ашиглагдахуйц байдалд хамгийн бага үнэлгээ өгсөн байна.


Түүнчлэн судалгаанд оролцогчдын ажилдаа түлхүү ашиглаж байгаа бүтээгдэхүүнийг харахад дотоодын хууль тогтоомж, түүнтэй холбогдуулан хийсэн судалгаа, дүн шинжилгээ материал байх бөгөөд харин гадаад улс орны хууль тогтоомж, хуралдааны дэг зэргийг хааяа ашигладаг нь харагдаж байна.

Оролцогчдын мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг ашиглаж байгаа байдлыг нэгтгэн дүгнэвэл төслийн хүрээнд боловсруулан тараасан ном, гарын авлагыг оролцогчид ерөнхийдөө ашигладаг 63.6% буюу 3.18 оноогоор үнэлсэн байна.

Энэхүү үр нөлөөний судалгааны үндэслэл хэсэгт дурдсанчлан төслийн суурь баримт бичигт нийт 4 төрлийн стратеги зорилт тусгагдсан байгаа билээ. Стратеги 4-ийн хүрээнд 2015 онд УИХ-аар батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль 2017 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хуулийн дагуу УИХ-ын Тамгын газарт шинэ чухал чиг үүргүүд нэмэгдэж улмаар УИХ-ын тамгын газар Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд чадавхжуулах нь төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэдгийг онцолсон. Энэ хүрээнд УИХ-ын Тамгын газрын албан хаагчдад Оросын Холбооны Улсын эрдэмтэн Т.В.Кашанина “Хууль зүйн техник” бүтээлийн орчуулан тараасан байна.


Тус мэдлэгийн бүтээгдэхүүнийг УИХ-ын Тамгын газрын албан хаагчид ашиглаж байгаа байдлыг номын хүрэлцээ, орчуулгын чанар, уншиж ашиглахад тохиромжтой байдал, үндсэн ажилдаа ашиглах боломж гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэснийг доорх хэсгээс үзнэ үү.

Зураг 59. “Хууль зүйн техник” номыг үндсэн ажилдаа ашиглах боломжтой байдал




“Хууль зүйн техник” номыг үндсэн ажилдаа ашиглах боломжтой байдлыг оролцогчдын 66.7% нь ерөнхийдөө ашиглах боломжтой, 33.3% нь боломжийн гэж үнэлсэн бол бүрэн дүүрэн ашиглах боломжтой болон огт ашиглах боломжгүй гэж хариулсан оролцогч байхгүй байв. Судалгаанд хамрагдсан оролцогчид уг бүтээлийг ажилдаа ашиглах боломжтой байдлыг ерөнхийд нь боломжтой (73.33% буюу 3.67 оноо) гэж үнэлсэн байна.

Зураг 60. “Хууль зүйн техник” номыг уншиж ашиглахад тохиромжтой байдал




“Хууль зүйн техник” номын хэвлэлийн чанар, үг үсгийн хэмжээ, алдаа буюу уншиж ашиглахад тохиромжтой байдлыг оролцогчдын 16.7% нь маш тохиромжтой, 50.0% нь ерөнхийдөө тохиромжтой, 33.3% нь боломжийн гэж үнэлсэн бол тийм ч тохиромжтой биш, огт тохиромжгүй гэж хариулсан оролцогч байхгүй байв. Судалгаанд хамрагдсан оролцогчид уг бүтээлийн уншиж ашиглах тохиромжтой байдлыг ерөнхийд нь боломжтой (76.67% буюу 3.83 оноо) гэж үнэлжээ.

Зураг 61. “Хууль зүйн техник” номын орчуулгын чанарыг үнэлсэн байдал



“Хууль зүйн техник” номын орчуулгын чанарыг оролцогчдын 66.7% нь ерөнхийдөө сайн, 33.3% нь боломжийн гэж үнэлсэн бол маш сайн болон муу гэж үнэлсэн оролцогч байхгүй байв. Судалгаанд хамрагдсан оролцогчид уг бүтээлийн орчуулгын чанарыг ерөнхийд нь сайн (73.33% буюу 3.67 оноо) гэж үнэлсэн байна.


Зураг 62. “Хууль зүйн техник” номын хүрэлцээт байдал



“Хууль зүйн техник” номын хүрэлцээт байдлыг оролцогчдоор үнэлүүлэхэд оролцогчдын 16.0% нь хангалттай хүрэлцээтэй, 17.0% нь ерөнхийдөө хүрэлцээтэй, 50.0% нь боломжийн хүрэлцээтэй, 17.0% нь хүрэлцээ хангалтгүй байсан гэж хариулсан бол огт хүрэлцээгүй байсан гэж хариулсан оролцогч байхгүй байлаа. Судалгаанд хамрагдсан оролцогчид уг бүтээлийн хүрэлцээ, хангалттай байдлыг ерөнхийдөө боломжийн (66.67% буюу 3.33 оноо) гэж үнэлсэн байна.

Эдгээр үзүүлэлтийн дэлгэрэнгүйг доорх графикт харуулав. Үүнд:

Зураг 63. “Хууль зүйн техник” номыг уншиж ашиглаж байгаа байдал



Дээрх үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэвэл оролцогчид “Хууль зүйн техник” номыг уншиж, ашиглаж байгаа байдлаа дунджаар сайн (72.5% буюу 3.63 оноо) гэж дүгнэсэн байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд УИХТГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн туршлага судлах хөтөлбөр, нийтийн сонсгол зохион байгуулахад үзүүлсэн дэмжлэг болон мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах гэсэн энэхүү төслийн тодорхой үйл ажиллагаа бүр хангалттай үр нөлөөтэй байсан нь ажиглагдлаа.

УИХТГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төслийн үйл ажиллагааг цаашид хэрхэн сайжруулах талаар УИХТГ-ын албан хаагчдын саналыг асуухад УИХТГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн нь маш сайн үр нөлөөтэй байсныг судалгаанд оролцсон бүх албан хаагчид хэлж байсан бөгөөд цаашид тус байгууллагын үйл ажиллагаанд цаашид сайжруулах шаардлагатай олон үйл ажиллагаа байгаа тул төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бодит хэрэгцээ шаардлага байгаа гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байна.

Иймд төслийн тодорхой үйл ажиллагаа бүр хангалттай үр дүнг авч ирсэн тул цаашид энэ туршлагадаа үндэслэн сургалт, туршлага солилцох үйл ажиллагааг хэрэгцээтэй сэдвээр зохион байгуулж, илүү олон мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангавал УИХТГ-ын үйл ажиллагаанд чухал дэмжлэг болж чадна гэж үзэж байна. Ялангуяа УИХТГ-ын дэргэд шинээр байгуулагдсан Судалгааны төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь тус байгууллагын үйл ажиллагаанд өндөр ач холбогдолтой ажил болохоор байна.

2. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Судалгааны баг нь Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн дээрх үйл ажиллагааны үр нөлөө буюу төслийн үр шимийг шууд хүртэгчдийн олж авсан мэдлэгийн түвшин, уг мэдлэгийг албан ажилдаа ашиглах ур чадвар сайжирсан эсэх, үүний үр дүнд тодорхой үр нөлөө гарч байгаа эсэхийг шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитойгоор үнэлж, сургалт болон чадавхжуулах үйл ажиллагааны үр дүнд бий болсон сайн туршлагыг судалж, цаашид анхаарах асуудлууд болон тогтвортой байдлыг хэрхэн хангах талаар санал зөвлөмж боловсруулах төлөвлөгөөтэй ажилласан билээ. Энэхүү үр нөлөөний судалгааны нэгдсэн дүгнэлт болон дүгнэлтэд үндэслэн боловсруулсан зөвлөмжүүдийг энэхүү бүлэгт танилцуулж байна.

Үр нөлөөний судалгааны хүрээнд үнэлсэн үйл ажиллагаануудын нэгдсэн үр дүнгийн танилцуулга

Энэхүү үр нөлөөний үнэлгээний хүрээнд тусгайлан үнэлсэн болон нэгтгэсэн үр дүнг НҮБХХ-ийн зүгээс төслийг хэрэгжүүлж эхлэхдээ хүрэхээр төлөвлөж байсан үр дүнтэй харьцуулан дүгнэхэд Төслийн баримт бичигт дурдсан стратеги зорилтууд бүгд биелсэн гэж үзэж байна.

Төслийн баримт бичигт дурдсанаар стратеги 2-ын хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д зориулсан Захиргааны хэм хэмжээний акт боловсруулах гарын авлага боловсруулах, ИТХ-ын жишиг дэг боловсруулж хэрэгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлж ИТХ-ын зохион байгуулалтын чадавхыг дээшлүүлэх зорилгыг тавьсан байна. ИТХ-ын хуралдааны жишиг дэгийг зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан бөгөөд нарийн бичгийн дарга нараас бүрдсэн ажлын хэсэг ажиллажээ. Үүний үр дүнд аймаг, сумын ИТХ-ууд жишиг дэгийг өөрийн одоогийн мөрдөж буй хуралдааны дэгтэй харьцуулан судалж, шинэчлэн баталсныг тайланд дурдсан байна. ИТХ-ын ажлын үр дүнг үнэлэх багц үзүүлэлтийн төслийг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж буй нарийн бичгийн дарга нарын Ажлын хэсэг Улаанбаатар хотод уулзаж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох орчин үеийн чиг хандлага, Европын орнуудад хэрэгжүүлж буй туршлага, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, мэдээлэл цуглуулах талаар мэдээлэл сонсож, тодорхой ойлголттой болсон байна. Харин ИТХ нь ажлаа хаана, ямар давтамжтайгаар, хэрхэн тайлагнах тогтсон механизм одоогоор бүрэлдээгүй бөгөөд энэ нь Монгол Улсын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хөгжлийн явцтай холбоотой гэж үзэж байна. Цаашид энэхүү нөхцөл байдлыг хууль тогтоомжоор зохицуулж, эрх зүйн зохицуулалтыг тогтмол хөгжүүлж байх шаардлагатай байна.

Стратеги 3-ын хүрээнд ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт, ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалт, Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалт, Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалт болон ИТХ, ТББ-уудад тодорхой чиглэлээр тэтгэлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлсний үндсэн дээр

ИТХ-ын төлөөлөгчдийн шийдвэр гаргах, хяналтын болон төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгыг тавьжээ.

Сургалтын үйл ажиллагааны хувьд төслийн хүрээнд зохион байгуулсан бүх сургалтын үр нөлөө 80 хувиас дээш үнэлэгдсэн нь сайшаалтай бөгөөд эдгээрийн дотроос Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалт болон ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө хамгийн өндөр байлаа. Сургалтын үр дүнгийн цаашдын тогтвортой байдлыг хадгалах асуудлаар ИТХ-ын төлөөлөгчид болон нарийн бичгийн дарга нарын олж авсан мэдлэг мэдээлэл, хамтын ажиллагааны талаарх боломж, санал шүүмжид үнэлгээ хийхэд ИТХ-ын зардалд төлөөлөгчдөд зориулсан сургалтын зардлыг багтаасан байдаг бөгөөд энэхүү зардлыг илүү өндөр төсөвлөж, тухайн зардлаас санхүүжилтийг нь шийдвэрлэх замаар энэ төрлийн сургалтуудыг зохион байгуулах боломжтой болохыг оролцогчид дурдсан байна. Иймд НҮБХХ болон ШХА зэрэг донор байгууллагын оролцоогүйгээр үндэсний хэмжээнд энэ төрлийн сургалтуудыг ялангуяа орон нутгийн сонгуулийн дараа зохион байгуулах бодит боломжийг цаашид ашиглах нь зүйтэй гэж үзэж байна. Ингэхдээ аймаг, дүүрэг, сумдын өмнөх сайн туршлагыг харилцан солилцох зорилгоор сургалтын үйл ажиллагааг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах нь илүү үр нөлөөтэй юм.

ИТХ-ын хяналтын болон төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ИТХ болон ТББ-уудад зориулан олгосон тэтгэлгийн үр дүн нь сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвараа ашиглах нэг ёсны практик туршилт хийх боломж болсон гэж үзэж байна. Харин тэтгэлгийн зорилго оновчтой, гүйцэтгэл үр дүнтэй байсан эсэхэд үр нөлөөний үнэлгээ хийхэд ИТХ-уудад чиглэсэн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд олон сайн туршлага бий болсон, ИТХ-уудын үйл ажиллагаа мэдэгдэхүйц дээшилсэн, ялангуяа тэтгэлэгт хамрагдсан хурлуудын хяналтын чадавх сайжирсан, ТББ-уудад чиглэсэн тэтгэлгийн хүрээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын үйл ажиллагаа тогтворжсон, тэдний үйл ажиллагааны үр дүнд иргэдийн хяналтын бүлэг байгуулагдсан, иргэдийн оролцоо дээшилсэн зэрэг олон эерэг нөлөөллийг бий болгож чадсан нь судалгааны үр дүнгээр баталгаажсан байна.

Стратеги 4-ийн хүрээнд УИХ-ын Тамгын газарт Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх чадвараа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор албан хаагчдыг туршлага судлах хөтөлбөрт хамруулах, хуулийн төслөөр нийтийн сонгог зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах гэсэн үндсэн гурван үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Хууль тогтоомжийн тухай хууль 2017 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор энэхүү стратегийн зорилтыг тусгайлан төслийн хүрээнд дэвшүүлсэн нь цагаа олсон зөв, зүйтэй үйл ажиллагаа болсон гэж дүгнэж байна. УИХТГ-ын үйл ажиллагааг чадавхжуулах хүрээнд стратегийн зорилтын хэрэгжилт ямар байгаа талаар хөндлөнгийн үнэлгээ хийхэд энэхүү төслийн тодорхой үйл ажиллагаа бүр хангалттай үр нөлөөтэй байсан нь ажиглагдлаа. Ялангуяа судалгаанд оролцсон бүх албан хаагчид эдгээр үйл ажиллагаанд сэтгэл хангалуун

байсныг энд дурдах нь зүйтэй байна. Туршлага судлах хөтөлбөрийн хувьд хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажилд ШХУ-ын парламентын төлөөлөгчидтэй хамтран боловсруулсан аргачлал үр дүнтэй байсан нь судалгааны үр дүнд илэрсэн. Хуулийн төсөлтэй холбоотой нийтийн сонсгол зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны талаар судалгаанд оролцогчид сонсгол зохион байгуулах арга, хэлбэрийг сайжруулж чадсан, хуулийн төсөлтэй холбоотой бодит, үнэн зөв, албан ёсны мэдээллийг олж авах боломжтой болсон нь ач холбогдолтой байсан гэж үзжээ. Харин мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах үйл ажиллагааны хувьд үндсэн хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээний зөвлөмжүүд, МУЗЗНДНТУТХ-ийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ гэсэн хэвлэмэл бүтээгдэхүүнүүдийг байнга ашиглаж байгаа бол харьцуулсан судалгааны зорилгоор гаргасан хэвлэмэл бүтээгдэхүүнүүдийг шаардлагатай тохиолдолд л ашиглаж байгаа нь ажиглагдлаа.

Энэхүү үр нөлөөний судалгааны хүрээнд захиалагчийн зүгээс судалгааны ажлын даалгаварт дурдсан ажилбар бүрийг бүрэн дэлгэрэнгүй түвшинд хамруулах зорилгоор нийслэлийн 3 дүүрэг, 4 аймгийн болон 12 сумын ИТХ-ын төлөөлөгчдөөс шууд аргаар 181 оролцогчийг, бусад 4 аймаг 1 дүүргээс цахим асуулгын аргаар 286 оролцогчийг хамруулан анкетын судалгаа авсан бөгөөд тоон судалгаагаар Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт, ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалт, Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалт, Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын болон ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн үр нөлөөг тус тус тоон аргаар үнэлүүлсэн болно. Харин УИХТГ-ын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны үр нөлөөг судлахдаа зөвхөн баримт бичгийн болон чанарын судалгааны аргыг ашигласан тул тоон үр дүнг тооцоолох боломжгүй байлаа.


Дээр дурдсан анкетын буюу тоон судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж доорх хүснэгтэд харууллаа. Үүнд:

Хүснэгт 9. Үр нөлөөний судалгааны ерөнхий үр дүн

Үр нөлөөний үнэлгээ хийсэн төслийн үйл ажиллагаа	Үнэлгээ	Оноо
1 Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын үр нөлөө	80.8	4.01
2 ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө	85.0	4.25
3 Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө	90.0	4.50
4 Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын үр нөлөө	80.6	4.01
5 ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн үр нөлөө	75.2	3.76
Төслийн үйл ажиллагааны үр нөлөөний ерөнхий үнэлгээ	82.3	4.11

Тоон судалгааны үр дүнд төслийн хамгийн өндөр үнэлэгдсэн үйл ажиллагаанаас хамгийн доогуур үнэлэгдсэн үйл ажиллагаагаар жагсааж харуулбал доорх байдалтай байна. Үүнд:

Зураг 64. Үр нөлөөний судалгааны ерөнхий үр дүн



Энэхүү үр нөлөөний үнэлгээний судалгаанд оролцогчид эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын үр нөлөөг хамгийн өндөр, ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр нөлөөг харьцангуй өндөр үнэлсэн бол иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын үр нөлөөг дундаж, харин багийн иргэдийн төлөөлөгчдөд зориулсан сургалтын үр нөлөөг сургалтын үйл ажиллагаануудын дунд хамгийн бага оноог өгч дүгнэсэн байна. Харин ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн үр нөлөөг сургалтын үйл ажиллагааны үр нөлөөнөөс харьцангуй доогуур үнэлсэн байна.

Сургалтын үйл ажиллагааны үр нөлөө

Сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн багш тусгайлан бэлтгэсэн хөтөлбөрийн хүрээнд, ихэвчлэн зориулалтын анги, танхимд зохион байгуулсан тул сургалтуудын хувьд сургалтын зохион байгуулалтад өгсөн оролцогчдын сэтгэл ханамж илүү өндөр, төлөөлөгчид сургалтын хүрээнд заасан ур чадварыг эзэмшсэн байдал харьцангуй өндөр, харин сургалтаас олж авсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрэгжүүлж дадсан байдал харьцангуй доогуур, мэдлэг ур чадвараа ашиглан орон нутагтаа өөрчлөлтийг бий болгосон байдал ихэвчлэн хамгийн доогуур үнэлэгдэж байв. Сургалтаас олж авсан мэдлэг, ур чадварыг хэрэгжүүлэхэд төлөөлөгчдөд тодорхой зардал гаргах, бусад төлөөлөгчидтэй хамран ажиллах, зөв төлөвлөх зэрэг илүү бодит үйл явцыг бий болгох болон иргэдийн оролцоо өндөр байх, улс төрийн намын дэмжлэг шаардах зэрэг

урьдач бусад нөхцөлүүдийг бүрдүүлэх шаардлагатай байдаг тул ийнхүү сурсан мэдлэг, ур чадвараа ашиглан өөрчлөлтийг бий болгосон байдалд харьцангуй бага үнэлгээ өгсөн гэж үзэж байна.

Чанарын судалгаанд оролцсон ИТХ-ын төлөөлөгчдийн хувьд энэхүү судалгаагаар үнэлж байгаа сургалтуудад оролцохоос гадна тухайн орон нутаг болон бусад донор байгууллагуудаас зохион байгуулсан өөр сургалтуудад хамрагдсан тул өөрийн болон хурлын үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт нь эдгээр бүх сургалтын үр нөлөөнд бий болсон гэж үзэх хандлага түгээмэл байгааг буруутгах боломжгүй байв. Гэвч ярилцлагын судалгаанд хамрагдсан оролцогчдын дийлэнх нь сургалтын сэдэв, зохион байгуулалт, багш нарыг нэг бүрчлэн санаж, тодорхой шийдвэр гаргах зэрэг үйл ажиллагаандаа сурсан сэдвүүдээ ашиглахыг хичээдэг гэж хариулж байв. Иймд сургалтын үйл ажиллагаа нь төлөөлөгчдийн тодорхой үйл ажиллагаанд нөлөөлөхөөс илүү тэдний суурь мэдлэг болон ажил, үүрэгтээ хандах хандлагад илүү нөлөөлсөн гэж үзэж байна. Харин эмэгтэй төлөөлөгчдийн хувьд тэдний бусад эмэгтэй төлөөлөгчидтэйгөө хамтран ажиллах байдалд илүү нөлөөлж чадсан нь чанарын ярилцлагаас ажиглагдлаа. Мөн тоон буюу анкетын судалгааны үр дүнгээс эмэгтэйчүүдийн сурсан мэдлэгээ ашиглаж байгаа байдал эрэгтэй төлөөлөгчдөөс илүү болох нь ажиглагдсан болно.

Тэтгэлэгт хөтөлбөрийн үр нөлөө

Тэтгэлэгт хөтөлбөрийн хувьд ИТХ-ууд урьд нь энэ төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан туршлагагүйгээс төлөвлөсөн үр дүндээ хүрч чадаагүй тохиолдлууд ажиглагдсан бөгөөд энэ нөхцөл байдал нь тэтгэлгийн үр нөлөө сургалтын үр нөлөөнөөс харьцангуй доогуур үнэлэгдэхэд нөлөөлсөн гэж үзэж байна. Гэвч ИТХ-уудын хяналт тавих чадвар сайжирч, иргэдийн оролцоо тодорхой хэмжээгээр нэмэгдсэн нь судалгааны үр дүнгээр баталгаажсан тул тэтгэлэгт хөтөлбөр нь урьдчилан тооцоолсон үр дүндээ тодорхой хэмжээгээр хүрч, иргэдийн амьдралд мэдэгдэхүйц байдлаар эерэг өөрчлөлтийг бий болгосон гэж дүгнэж байна.

УИХТГ-ын албан хаагчдыг чадавхжуулах үйл ажиллагааны үр нөлөө

Энэхүү үйл ажиллагааны үр нөлөөг тодорхойлохдоо зөвхөн баримт бичгийн болон ярилцлагын судалгааны үр дүнд үндэслэн тодорхойлохоор төлөвлөж байсан боловч зөвхөн мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг тогтмол ашиглаж байгаа байдлыг тандах зорилгоор анкетын буюу тоон судалгааг авч дүгнэсэн юм. Тоон судалгааны дүнд мэдлэгийн бүтээгдэхүүнийг ашиглаж байгаа байдлыг оролцогчид дунджаар 63.6 хувь гэж үнэлсэн байна. Ийнхүү доогуур үнэлгээ өгсөн нь Монгол Улсын Үндсэн хууль болон УИХ-ын дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг тодорхой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор тодорхой тооны хэвлэмэл бүтээгдэхүүнийг УИХТГ-т хүргэж байсантай холбоотой юм. Тухайлбал Төслөөс УИХТГ-т хүргүүлсэн хэвлэмэл бүтээлүүдийн ихэнх нь ХБНГУ, БНСУ, ОХУ, Австрали улс зэрэг орнуудын парламентын тухай хууль болон парламентын дэгийн орчуулга байсан бөгөөд

эдгээрийг байнга ашиглах хэрэгцээ шаардлага төдийлөн гарахгүй юм. Харин эдгээр орчуулгын бүтээлүүдийг ашиглан Үндсэн хууль болон УИХ-ын дэгийн тухай хууль, МУЗЗНДНТУТХ-д нэмэлт өөрчлөлт оруулснаар эдгээр эрх зүйн зохицуулалт илүү боловсронгуй болж, боловсронгуй эрх зүйн зохицуулалтыг улс орон даяар байнга хэрэглэх нь дамжиггүй билээ.

3. СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖҮҮД

Энэхүү үр нөлөөний судалгааны хүрээнд үнэлсэн төслийн үйл ажиллагаануудыг тус бүрд нь болон ерөнхийд нь сайжруулах боломжуудыг судалж, эдгээрийг хэрэгжүүлэх явцад гарсан саад, тотгорууд болон сөрөг хүчин зүйлүүдийг харгалзан цаашид анхаарах асуудлуудыг тодорхойлох зорилгын хүрээнд доорх зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:

Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр

- ИХТ-ын сонгууль бүрийн дараа энэ төрлийн сургалтыг давтан явуулдаг эрх зүйн зохицуулалт бий болгох эсвэл жишиг тогтоох;
- ИТХ-ын төлөөлөгчдийн сайн болон муу туршлагаудын талаар дурдсан гарын авлага гаргах;
- Сургалтаар заасан мэдлэг, ур чадварыг бодитоор хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Сургалтын үр нөлөөг сайжруулахын тулд төлөөлөгчдийн энэ төрлийн сургалтад суусан болон сурсан мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлсэн байдлыг тэдний ажлын үзүүлэлтэд тусгадаг болох.

ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр

- Сургалтын сэдэвт хурлын үйл ажиллагаанд нөлөөлөх улс төрийн нөлөөллийг багасгах талаар тусгайлан оруулах;
- Төлөөлөгчийн ажлын үнэлгээнд тухайн сургалтад хамрагдсан байдлыг оруулан тооцох зохицуулалттай болох.
- Тэргүүлэгчдийн манлайллыг буюу сурсан мэдлэг, чадвараа ашиглан өөрчлөлт гаргасан байдлыг төлөөлөгчид олгох урамшууллын тогтолцоонд багтааж өгөх;

Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр

- Эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалт болон ИТХ-ын тэргүүлэгчдийн сургалтыг нэгтгэн жендэрийн асуудлыг бүх тэргүүлэгчдэд заадаг болох;
- Бүсчилсэн байдлаар сургалт явуулж бусад бүсийн сайн туршлагаас суралцах боломжийг бүрдүүлэх;

Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр

- Энэ төрлийн сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх явуулах;
- Сургалтын сэдэвт сайн туршлагаудыг илүү ихээр оруулах.

ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн үр нөлөөг сайжруулах чиглэлээр

- Тэтгэлэг олгохдоо тавьсан шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг тэтгэлгийг хэрэгжүүлэх явцад хянах, баталгаажуулах арга хэмжээ авах;
- Тэтгэлэг олгохдоо хэрэгжилт болон санхүүгийн зарцуулалтыг зөв төлөвлөсөн эсэхэд санхүүгийн болон холбогдох бусад мэргэжилтнээр дүгнэлт гаргуулах боломжийг судлах;
- Тэтгэлэгт хөтөлбөрт ирүүлсэн төслийн саналыг шаардлагатай бол зарим байдлаар өөрчлөх боломжийг бүрдүүлж алдаатай төлөвлөгөөг засаж сайжруулах боломжийг бий болгох;
- Үндэсний хэмжээнд ажиллах, мэргэшсэн төрийн байгууллагыг төслийн хүрээнд олноор бойжуулахын тулд төслийн сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэхэд анхаарах;
- Төслийн үр, дүн сайн туршлагыг тогтвортой хэрэгжүүлэх үүднээс тухайн хөндөж буй сэдвээр бодлогын судалгааг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж шаардлагатай бол холбогдох хууль тогтоомж, төсөв, төлөвлөгөөнд нь өөрчлөлт, шинэчлэлт хийх ажлыг төслийн зохион байгуулагчид анхаарах.

УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх ажлын үр нөлөөг сайжруулах чиглэлээр

- Энэ удаагийн туршлагадаа үндэслэн сургалт, туршлага солилцох үйл ажиллагааг хэрэгцээтэй сэдвээр зохион байгуулж, илүү олон мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах;
- Төслийн үр дүнг сонгуулийн үр дүнгээс хамааралгүй тогтвортой хадгалах үүднээс удирдлагууд болон улс төрийн албан тушаалтнуудаас илүү тоогоор гүйцэтгэх ажилтнуудыг сургалт болон туршлага солилцох арга хэмжээнд хамруулах;
- УИХТГ-ын дэргэд шинээр байгуулагдсан Судалгааны төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

4. ХАВСРАЛТ

Хавсралт 1. Судалгааны тухай ерөнхий мэдээлэл

Хавсралт 2. Судалгаанд ашигласан анкетын асуулгын загвар

Хавсралт 3. Судалгаанд ашигласан ярилцлагын судалгааны чиглүүлэх асуултууд

Хавсралт 3. УИХТГ-ын албан хаагчдаас авсан ярилцлагын чиглүүлэх асуултууд болон анкетын судалгааны загвар

4.1 СУДАЛГААНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үр нөлөөний судалгааны энэхүү бүлэгт судалгааны тухай ерөнхий мэдээллийг өгөх зорилгоор судалгааны үндэслэл, зорилго, зорилтууд, хамрах хүрээ, хүрэх үр дүнг товч танилцуулж, үр нөлөөний судалгаа боловсруулсан арга зүйг дэлгэрэнгүй орууллаа. Ингэхдээ тоон болон ярилцлагын судалгааны түүврийг сонгосон аргачлал, түүврийн хэмжээг тодорхойлж, төлөөлөх чадварыг хангасан баталгааг тайлбарласан болно.

4.1.1 Судалгааны үндэслэл

Баримт бичгийн судалгааны үр дүнгээс холбогдох хэсгүүдийг нэгтгэн судалгааны зорилго, зорилтууд болон хүрэх үр дүнг товч тодорхойлно. Эдгээрийг нэгдсэн дүгнэлт хэсгийг боловсруулахад ашиглана. Мөн “Түгээмэл эрх-Хөгжил” ТББ-ын судалгааны багт тулгарсан хүндрэл бэрхшээлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн арга замуудын талаар дурдана.

“Монгол улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл нь 2017 оны 01 дүгээр сараас 2020 оны 12 дугаар сарыг дуустал буюу 4 жилийн стратеги төлөвлөлттэй үндэсний хэмжээнд хэрэгжиж байна. Энэхүү төслийн хүрээнд 2017, 2018 болон 2019 оны эхний хагас жилд зохион байгуулагдсан сургалт, чадавхжуулах үйл ажиллагааны үр нөлөөний талаарх хөндлөнгийн үнэлгээ хийх судалгааны ажлыг Түгээмэл Эрх Хөгжил ТББ-аас гүйцэтгэж байна.

Судалгааны эхний үе шатанд судалгаа хийх зорилго, агуулга, хүрээг тодорхойлох зорилгоор Төслийн /суурь/ баримт бичиг, төслийн 2017, 2018 оны үйл ажиллагааны тайлан болон 2019 оны эхний хагас жилийн тайлан гэсэн баримт бичгүүд болон бусад холбогдох мэдээллийг үндэс болгов.

“Монгол улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийг УИХ-ын Тамгын газраас НҮБХХ, ШХА-ийн дэмжлэгтэйгээр 2013-2016 онд хэрэгжүүлсэн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь”, “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслүүдийн бий болгосон үр дүнд суурилан хэрэгжүүлж байгаа залгамж шинжтэй байна. Иймд харьцангуй урт хугацааны хэд хэдэн төслийн төгсөлтийн шат гэдэг утгаар илүү бодит үр дүнд чиглэсэн байхаар стратеги зорилгыг тавьсан гэж үзэхээр байна.

Түүнчлэн үр нөлөөг үнэлэх энэхүү судалгаа нь цаг хугацааны хувьд нийт дөрвөн жилийн төслийн төгсгөл дөхөж байгаа гэдэг утгаар сургалт болон тэтгэлгийн хөтөлбөрийн зорилгууд⁷ стратегийн зорилтын хүрээнд биелэгдэх бололцоотой байгаа эсэхэд дүн шинжилгээ өгөх нь ач холбогдолтой гэж үзэж байна.

⁷ Төслийн зорилгууд буюу хүлээгдэж буй үр дүн:

1. Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байна.
2. ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байна.

Төслийн суурь баримт бичигт тусгасан 4 төрлийн стратеги зорилтын хэрэгжилт төслийн үйл ажиллагааны жил бүрийн тайланд хэрхэн тусгасан байдалтай харьцуулж үзээд энэхүү үр нөлөөний үнэлгээ хийх хийх үеийн нөхцөл, хэрэгцээ шаардлага, үндэслэлийг дараах байдлаар товч тодорхойлж байна.

Төсөл хэрэгжихийн өмнөхөн Хууль тогтоомжийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль баталсан нь төслийн ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлсэн гэж үзэхээр юм. 2016 оны сонгуулийн дараа шинээр сонгогдсон, томилогдсон албан хаагчдад төдийгүй дахин ажиллаж байгаа төрийн албан хаагчдын хувьд шинэ хуулиудын зохицуулалтын талаарх мэдлэг мэдээлэл хомсын зэрэгцээ, түүнд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх санхүүгийн боломж орон нутагт хүндрэлтэй байсныг тайланд дурдсан байна. Иймд эрх зүйн орчны хувьд нэгэнт хүрсэн амжилтыг баталгаажуулах цаашид улам боловсронгуй болгоход энэхүү төслийн стратеги зорилт оновчтой болсон бөгөөд үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгаа нь үр нөлөөний үнэлгээний үр дүнгээр тодорхойлогдоно.

Цаашид төсөл хэрэгжих явцад Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх явц, зарим нэг хуульд „гэнэтийн шинжтэй“ өөрчлөлт орох зэрэг гадны хүчин зүйлийн нөлөөгөөр зорьсон үр дүнд хүрэхэд эерэг, сөрөг хэлбэрээр нөлөөлөх нөхцөл байдал үүссэнийг үгүйсгэхгүй юм. Дээрх хүчин зүйлийг багасгах үүднээс төслийн зүгээс холбогдох хуулийн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга батлах үйл ажиллагаанд идэвхитэй оролцсон нь төслийн стратеги зорилт тогтвортой хэрэгжихэд ач холбогдолтой болжээ. Иймд хуулийн төслийн (Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль гэх мэт) ажлын хэсгийн гишүүдийн үйл ажиллагаа болон хөгжиж буй орнуудад явж туршлага судалсан ИТХ-ын дарга нартай ярилцлага хийж нутгийн удирдлагын эрх зүйн шинэчлэлийн орчин, цаашдын чиг хандлагын талаар тэдний санаачилга, байр суурьт дүгнэлт хийх нь судалгааны нэг чухал хэсэг болох юм.

Стратеги хоёрын хүрээнд ИТХ-ын зохион байгуулалтын чадавхыг дээшлүүлэх

Захиргааны ерөнхий хууль 2016 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой ИТХ-аас батлах хэм хэмжээний актыг боловсруулах, батлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэдлэг, мэдээлэл, практик дутагдахыг төслийн баг олж харан стратегийн зорилтод энэ талаар авч хэрэгжүүлэх ага хэмжээг тусгасан байна. Тухайлбал, хялбаршуулсан гарын авлага буюу шалгах хуудас, олон нийтийн хэлэлцүүлэг явуулахтай холбоотой дүрэм журмыг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ гэж төлөвлөсний дагуу 2017 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар

-
3. Сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизм бий болсон байна.
 4. УИХ-ын Тамгын газраас төлөөллийн байгууллагад дэмжлэг үзүүлэх чадавх дээшилсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д зориулсан Захиргааны хэм хэмжээний акт боловсруулах гарын авлага боловсруулсан байна. Энэхүү гарын авлагын хэрэглээ, түүний үр дүн, санал шүүмжийн талаар судалгааны дүгнэлт гарах нь сургалтын үр дүнгийн нэг хэсэг гэж үзэж байна.

ИТХ-ын зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор 2017 онд төслийн зүгээс гол санаачилсан ажлын нэг нь ИТХ-ын дэгийн зохицуулалтын сул талыг нөхөх судалгаа хийж 2018 оны сургалтын туршид жишиг дэгийг танилцуулж сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулжээ. Жишиг дэгийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын уулзалт, сургагч багш нарын сургалтын үеэр хэлэлцүүлэн, тэдний саналыг авч тусган нэмэлт боловсруулалт хийсэн байна. ИТХ-ын нарийн бичгийн дарга нар жишиг дэгийг нэвтрүүлэхээс гадна ажлын гүйцэтгэлийн багц үзүүлэлтийг боловсруулах, ажлын албыг чадавхжуулах сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөө гаргах, төслийн гол хүрэх үр дүнгийн чиглэлээр зургаан ажлын хэсэгт хуваагдан, төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллах зэргээр төсөлд идэвхитэй оролцоотой байжээ. Иймд жишиг дэгийн хэрэгжилтийн үр дүнгийн талаар болон төслийн тогтвортой байдалд ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын дүгнэлт, санал шүүмжлэлд үнэлгээ хийх нь манай судалгаанд тусгагдах нэг сонирхолтой үзүүлэлт байх болно.

Стратеги гурвын хүрээнд ИТХ-ын төлөөлөгчдийн шийдвэр гаргах, хяналтын болон төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх чадварыг нэмэгдүүлэх

Стратегийн энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд сургалт болон тэтгэлэгт хөтөлбөрийн зорилтот бүлгийг оновчтой тодорхойлсон байна. Тухайлбал нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд залуучуудын оролцоог илүү хангахад хөтөлбөрийн зорилго чиглэсэн нь орон нутагт тулгамддаг асуудалд залуучуудын анхаарлыг хандуулах, нийтийн ашиг сонирхлын төлөө хамтран ажиллах идэвхийг өрнүүлэх хөшүүрэг болох ач холбогдолтой юм.

Түүнчлэн төслийн тайлангаас харахад сургалтын төлөвлөгөө, явцын үр дүн, санал, шүүмжлэлд бүтээлч, шуурхай хандаж зохих өөрчлөлтийг цаг тухайд нь хийжээ.

Төслийн эхэнд шууд зорилтот бүлгээр ИТХ-ын Ажлын албад, УИХ-ын Тамгын газрын ажилтан нарт зориулсан сургалт, тэтгэлэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр тодорхойлж байсан бол сургалтын явцад багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарыг чадавхжуулах сургалт явуулах нь зүйтэй гэсэн санал (Үндэсний сургагч багш нарын сургалт-ын үеэр 2017.03.30) гарснаар төслийн хөтөлбөрт нэгэн шинэ зорилтот бүлэг нэмэгдсэн байна. Нийт 21 аймгийн 1612 багийн ИНХ-ын дарга 1500 гаруй хүнийг нэмэлт хөтөлбөр батлан сургалтад хамруулжээ. Иймд орон нутгийн иргэдийн төлөөллийн хамгийн бага шатанд мэдлэг, мэдээлэл түгээх нь өөртөө удирдах ёсны тогтолцоо үр нөлөөтэй ажиллахад энэхүү ИНХ-ын дарга нарт зориулсан сургалт хир үр нөлөөтэй байгаа талаарх үнэлгээ нь судалгааны нэг чухал хэсэг юм.

Төслийн явцад суурь сургалтыг аймаг, сумын ИТХ ба нийслэл, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан өөрчлөх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь сургалтад хамрагдагсдын ирц, идэвхид эерэгээр нөлөөлсөн байж болохоор байна. Үүнтэй төстэй арга хэмжээг манлайллын сургалтын хөтөлбөр, агуулга, багшийн заах аргын хувьд мөн хэрэгжүүлж, санал шүүмжлэлийг тусган дараагийн сургалтад хэрэгжүүлэх талаар 2017 оны тайланд дурдсан байна. Иймд сургалтын явцад шуурхай авч хэрэгжүүлсэн нэмэлт үйл ажиллагааны үр нөлөөг судлах нь ач холбогдолтой байна.

Мөн ИТХ-ын хяналтын болон төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд ИТХ болон ТББ-уудад зориулсан тэтгэлгийн ач холбогдлыг тайлангуудад онцлон дурдсан нь сонирхол татаж байна. Учир нь сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвараа ашиглах нэг ёсны практик туршилт хийх боломж тэтгэлгээр олдсон байна. Харин тэтгэлгийн зорилго оновчтой, гүйцэтгэл үр дүнтэй байсан эсэхэд Үр нөлөөний үнэлгээ хийх нь манай судалгааны дүгнэлтийн нэг үндсэн хэсэг байх болно.

ИТХ-ын хуралдааны жишиг дэгийг зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан бөгөөд нарийн бичгийн дарга нараас бүрдсэн ажлын хэсэг ажиллажээ. Үүний үр дүнд аймаг, сумын ИТХ-ууд жишиг дэгийг өөрийн одоогийн мөрдөж буй хуралдааны дэгтэй харьцуулан судалж, шинэчлэн баталсныг тайланд дурдсан байна.

Стратеги дөрвийн хүрээнд УИХ-ын Тамгын газарт Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

УИХ-аас 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль 2017 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор энэхүү стратегийн зорилтыг тусгайлан төслийн хүрээнд дэвшүүлсэн гэж үзэж байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу УИХ-ын Тамгын газарт шинэ чухал чиг үүргүүд нэмэгдэж байгаа энэ үед төсөл хэрэгжиж байгаа нь цаг үеэ олсон явдал болжээ. УИХ-ын тамгын газар Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд чадавхижих нь нөгөө талаар төслийн үндсэн зорилтот бүлэг болох ИТХ-ын төлөөлөгчид ЗЕХ-ийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлийг даван туулахад арга зүйгээр хангах, төслийн үр дүнг цаашид тогтвортой хадгалахад ач холбогдолтой юм. Хууль тогтоомжийн хуулийг нэг мөр сахин мөрдүүлэхэд гарч буй зарим асуудлууд төслийн үр дүнд илэрч авах арга хэмжээнүүд төлөвлөгдсөн байгаа нь төслийн ерөнхий өгөөжийн хувьд ач холбогдолтой нь маргаангүй юм. Иймд УИХ-ын тамгын газрын үйл ажиллагааг чадавхжуулах хүрээнд стратегийн зорилтын хэрэгжилт ямар байгаа талаар хөндлөнгийн үнэлгээ хийх нь төслийн ерөнхий үнэлгээ, төслийн үр нөлөөний цаашдын тогтвортой байдлыг хадгалах арга хэмжээнд зөвлөмж болох ач холбогдолтой гэж үзэж байна.

4.1.2 Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээ болон хүрэх үр дүн

Судалгааны зорилго, зорилтууд

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн

байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл нь 1) бүх шатны нутгийн удирдлагын байгууллагыг чадавхжуулах; 2) төлөөллийн байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх үндсэн зорилгын хүрээнд 2017, 2018 онд бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт, манлайллын сургалт, эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалт, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан байна.

Энэ судалгаагаар төслийн хүрээнд хэрэгжүүлсэн дээрх үйл ажиллагааны үр нөлөө буюу төслийн үр шимийг шууд хүртэгчдийн олж авсан мэдлэгийн түвшин, уг мэдлэгийг албан ажилдаа ашиглах ур чадвар сайжирсан эсэх, үүний үр дүнд тодорхой үр нөлөө гарч байгаа эсэхийг шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитойгоор үнэлж, сургалт болон чадавхжуулах үйл ажиллагааны үр дүнд бий болсон сайн туршлагыг судалж, цаашид анхаарах асуудлууд болон тогтвортой байдлыг хэрхэн хангах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой.

Судалгааны хамрах хүрээ

Үнэлгээг төслийн хүрээнд 2016 оны 11 дүгээр сараас 2019 оны 6 дугаар сарын хугацаанд зохион байгуулсан дор дурдсан сургалт, чадавхжуулах үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ. Үүнд:

- Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт /7377 хүн оролцсон/
- Төлөөлөгчийн манлайлал сургалт /1368 хүн оролцсон/
- Эмэгтэйчүүдийн манлайллын сургалт /1858 хүн оролцсон/
- Багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зориулсан сургалт /1563 хүн оролцсон/

Судалгааны хүрэх үр дүн

- Сургалт, чадавхжуулах үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх судалгааны аргачлалыг мэргэжлийн өндөр түвшинд боловсруулах. Үнэлгээг хийх судалгааны арга зүй, хамрах асуудал, санал асуулгын дизайн, ажлын төлөвлөгөө зэргийг нарийвчлан боловсруулж, судалгаа эхлэхээс өмнө Захиалагчид танилцуулж, санал аван, туршилтаар нотолсны үндсэн дээр судалгааг эхлэх;
- Төслийн үр шимийг шууд хүртэгчид буюу дараах сургалтад хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, ажлын албаны ажилтнуудын сургалтаас олж авсан мэдлэгийн түвшин, уг мэдлэгийг албан ажилдаа ашиглах ур чадвар сайжирсан эсэх үүний үр дүнд тодорхой үр нөлөө гарч байгаа эсэхийг тандах, үр нөлөөг нь дээшлүүлэх, тогтворжуулах талаар санал боловсруулах:
 - Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт
 - “Төлөөлөгчийн манлайлал” сургалт;
 - Эмэгтэйчүүдийн манлайллын сургалт;

- Багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зориулсан сургалт
- Төслийн хүрээнд шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон тэтгэлгийн үр нөлөөг үнэлж, тэтгэлгийн хүрээнд бий болсон сайн туршлагыг судлан тодорхойлох, тэдгээрийг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн шинэлэг арга замын талаар санал зөвлөмж боловсруулах;
- Төслийн хүрээнд УИХ-ын Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа (сургалт, тэтгэлэгт хөтөлбөр, туршлага судлах, мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах г.м)-ны хүрээнд олж авсан мэдлэгийг ажилдаа ашиглах ур чадвар сайжирсан эсэхийг тандан судалж, тогтвортой байдлыг хэрхэн хангах талаар санал зөвлөмж боловсруулах;
- Үнэлгээний дэлгэрэнгүй болон хураангуй тайлан боловсруулж, холбогдох баримт мэдээллийн хамт Захиалагчид хүлээлгэн өгөх. Үнэлгээний дэлгэрэнгүй тайлан нь зөвлөх үйлчилгээг гүйцэтгэсэнтэй холбоотой бүх мэдээллийг агуулсан байна. Үүнд санал асуулгын загвар, ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлгийн удирдамж, чиглүүлэх асуултууд, тэдгээрийн дүнгийн нэгтгэл, оролцогчдын мэдээлэл, анхдагч мэдээллийг SPSS эсвэл бусад судалгааны програм дээр боловсруулсан нэгтгэл зэрэг холбогдох мэдээ, баримт хамаарна. Үнэлгээний хураангуй тайлан нь үнэлгээний зорилго, арга, аргачлалын талаарх мэдээлэл, үр дүн, судалгааны явцад олж илрүүлсэн сайн туршлагын талаарх мэдээллийг бүрэн багтаасан, олон нийтэд зориулсан мэдээлэл байна.

4.1.3 Үр нөлөөний судалгааг боловсруулсан арга зүй

Уг судалгааны ажлын хүрээнд нийгмийн судалгаанд хэрэглэгддэг олон улсын нийтлэг онол, арга зүй, тэргүүн туршлага, шинжлэх ухааны аргачлалд тулгуурлан, өөрийн байгууллагад мөрдөгдөж буй арга зүй, стандарт дүрэм журамд үндэслэн “Сургалт чадвахжуулах үйл ажиллагааны үр нөлөөний талаар хөндлөнгийн судалгааг хийх” арга зүйг боловсрууллаа. Арга зүйг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан. Үүнд:

- Захиалагчийн зүгээс судалгааны ажлын даалгаварт дурдсан ажилбар бүрийг бүрэн дэлгэрэнгүй түвшинд хамарсан байх;
- Олон Улсын болон үндэсний түвшинд хэрэглэгдэж буй нийтлэг арга зүй, тэргүүн туршлагад үндэслэсэн байх, судалгааны үе шат тус бүрд ёс зүйн болон мэргэжлийн стандартуудыг дагаж мөрдөх;
- Шинжлэх ухааны болон практикийн үндэслэл, нотолгоотой ач холбогдолтой арга зүйг сонгосон байх;
- Аргачлал, арга зүй зохион байгуулалт нь эдийн засгийн болон ажлын эцсийн үр дүнгийн хувьд үр ашигтай байх... зэрэг болно.

Зураг 65. Судалгааны ажлын арга зүйн зураглал



Судалгааны бэлтгэл үе шат

- Судалгааны хөтөлбөр боловруулах
- Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах
- Тайлангийн бүтэц гаргах
- Баримт бичгийн судалгаа хийх
- **Эхлэлтийн тайлан гаргах**



Мэдээлэл цуглуулалтын үе шат

- IDI Ганцаарчилсан ярилцлага
- SURVEY Асуулгын буюу тоон судалгаа
- Программд өгөгдлийг оруулах
- Өгөгдлийг боловсруулах
- Үр дүнг тооцох
- **Явцын тайлан бэлтгэх**



Тайлагнах үе шат

- Тоон судалгаанд дүн шинжилгээ хийх
- Чанарын судалгааг хэв загвар, бүлэглэл хийх, шигтээ, кейс
- Судалгааны хураангуй болон дэлгэрэнгүй тайлан бэлтгэх
- Хавсралт материалууд
- Мэдээллийн дата бааз
- **Эцсийн тайлан**

Судалгааны мэдээлэл цуглуулах үндсэн арга нь асуумж судалгааны болон ярилцлагын арга байх бөгөөд үүний зэрэгцээ боломжит бүхий л эх сурвалжуудаас мэдээлэл цуглуулах зорилт тавьж ажилласан. Ингэснээр олон талын байр суурь, санал бодол, мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх бололцоотой болох ба судалгааны үр дүн илүү бодитой гарах болно.

Судалгааны үндсэн мэдээлэл цуглуулах аргыг тоон ба чанарын судалгааны аргыг хэрэглэсэн. Ямар эх сурвалжаас ямар төрлийн мэдээлэл авахаас шалтгаалан нийгмийн судалгааны мэдээлэл цуглуулах тохирох аргыг хэрэглэсэн. Анхдагч мэдээлэл цуглуулах дараах аргуудыг ашигласан. Үүнд:

- Асуумж судалгааны арга (анкет)
- Ярилцлагын арга (ганцаарчилсан)
- Ажиглалтын арга
- Статистик ба баримт бичиг судлах аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.

Судалгааны түүврийг тооцохдоо нийт сургалтад оролцсон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөс тооцож гаргалаа. Энэ нь 99.7 хувийн баталгааны түвшинтэй, итгэх интервал нь ± 5 хувь байхаар тооцож үзвэл хамгийн ихдээ 662, багадаа 372 хүнийг хамруулахад хангалттай байхаар байна. Үүнийг ерөнхийд нь задалж үзвэл:

Хүснэгт 10. Анкетын түүврийн хэмжээг тооцох нь (99.7% баталгааны түвшинтэй, $p=0.5$)

Үзүүлэлт			Нийслэл	Аймаг нийслэл	Дүүрэг	Сум	Нийт
Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн төлөөлөгчид =N			45	765	152	1568	2530
Эндээс судалгааны шаардлагатай, төлөөлж чадах түүврийн хэмжээ =n			23	383	77	179	662
Шууд хэлбэрээр (Face to face)			23	127	25	60	235
Шууд бус хэлбэрээр (Online, Phone)			-	256	52	119	427
Итгэх түвшин					99.7%		
Итгэх интервал					±5%		

Тоон буюу анкетын судалгааг засаг захиргааны нэгжийг нэлэнхүй (21 аймаг, 9 дүүрэг) байдлаар шууд болон шууд бус (онлайн болон утас) хэлбэрийг хослуулан авах бол чанарын буюу ярилцлагын судалгааг төлөөлүүлэн нийслэлээс 3 дүүрэг, 21 аймгийг бүсчилж, 4 бүсээс⁸ тус бүр 1 аймгийг сонгож, аймаг бүрээс тус бүр 3 сумыг хамруулсан.

Анкетын буюу тоон судалгааны арга зүй

ИТХ-ын төлөөлөгчдөөс мэдээлэл цуглуулахдаа тоон судалгааны арга зүйн үндсэн хэлбэр болох асуулгын хуудас хэрэглэв (анкетыг хавсралтаас үзнэ үү). Өөрөөр хэлбэл, зохиомжилсон асуулгын хуудас буюу кодлогдсон асуултын дагуу тоон судалгааг гүйцэтгэсэн бөгөөд ингэхдээ түүврийн хэмжээг доорх хүснэгтэд зааснаар тодорхойлсон. Үүнд:

Хүснэгт 11. Анкетын түүврийн хэмжээг тооцсон нь


№	Төлөөлөх газар	Төлөөлөх сум, дүүрэг	Анкет
1	Говь-Алтай (баруун бүс)	Шарга сум	10
		Бугат	10
		Есөнбулаг сум	10
		Аймгийн төв	15

⁸ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2001 он

2	Булган (хангайн бүс)	Баян-Агт сум	10
		Бүрэгхангай	10
		Булган сум	10
		Аймгийн төв	15
3	Төв (төвийн бүс)	Лүн сум	10
		Алтанбулаг сум	10
		Зуунмод сум	10
		Аймгийн төв	15
4	Сүхбаатар (Зүүн бүс)	Уулбаян сум	10
		Мөнххаан сум	10
		Баруун-Урт сум	10
		Аймгийн төв	15
5	Улаанбаатар хот (нийслэл)	Хан-Уул дүүрэг ИТХ	20
		Баянзүрх дүүрэг ИТХ	25
		Багануур дүүрэг ИТХ	20
		Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	25
6	УИХ-ын Тамгын газар		
7	ТББ-ын тэтгэлэг		
Нийт			270

Тоон судалгааны мэдээллийг SPSS болон STATA программ ашиглан боловсруулж үр дүнг энэхүү судалгааны суурь мэдээлэл болгон ашиглалаа.


Зураг 66. Судалгаанд хамрагдсан талбар (Аймаг, дүүргүүд)



Санал асуулгын судалгаанд шууд буюу face to face хэлбэрээр 181 хүн, шууд бус буюу online хэлбэрээр 286 хүн хамрагдсан. Үүнээс Завхан аймгийн 162 (34%), Хэнтий аймгийн 79 (23.1%), Сэлэнгэ аймгийн 41 (8%), Хөвсгөл аймгийн 1 (0.2%), Налайх дүүргийн 8 (2%) төлөөлөгч буюу нийт 286 хүн нь цахимаар санал асуулгад


оролцсон. Харин Говь-Алтай, Булган, Сүхбаатар, Төв аймгууд тус бүр 41-43 төлөөлөгч, Нийслэл (Хан-Уул дүүрэг)-ээс 14 төлөөлөгч нийт 181 хүн нь шууд хэлбэрээр санал асуулгад оролцсон.

Зураг 67. Судалгаанд оролцогчдын насны бүлэг болон хүйсийн харьцаа



Судалгаанд 24-64 насны 467 оролцогч оролцсоноос 153 эмэгтэй (33%), 308 эрэгтэй (67%) хүн байна. Энэ нь Монгол Улсын нийт иргэдийн төлөөлөгчдийн хүйсийн харьцаатай адилхан гэж хэлж болно.


Зураг 68. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин



Судалгаанд оролцсон нийт төлөөлөгчдийн 64 хувь нь дээд боловсролтой бол 12 хувь нь техник болон мэргэжлийн , 17 хувь нь бүрэн дунд, 5 хувь нь суурь


боловсролтой байна. Харин бага болон боловсролгүй төлөөлөгч нийт 1.2 хувь буюу 6 хамрагдсан байна.

Зураг 69. Судалгаанд оролцогчид /хурал тус бүрээр/



Судалгаанд оролцогчдын 82% нь сум, дүүргийн, 12% нь аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчид байгаа бол 5% нь баг, хорооны ИНХ-ын төлөөлөгчид байна. Харин 1 хувь буюу 5 хүн нь хурлын нарийн бичгийн дарга нар байна.

Зураг 70. Сургалтад хамрагдсан байдал /сургалтын төрлөөр/



Эдгээрээс Иргэдийн төлөөлөгчдийн суурь сургалтад хамрагдсан төлөөлөгч 57%, ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсан төлөөлөгч 18%, Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтад хамрагдсан төлөөлөгч 16%, Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсан оролцогч 9%-ийг тус тус эзэлж байна.

Ярилцлагын буюу чанарын судалгааны арга зүй

Нийгмийн судалгааны практикт өргөн хэрэглэгддэг оролцооны арга зүйгээр ганцаарчилсан ярилцлага (in-depth interview)-ын хэлбэрээр чанарын мэдээллийг цуглууллаа. Ярилцлагыг бэлтгэсэн удирдамжийн дагуу явуулсан бөгөөд удирдамжид ярилцах сэдэв, сэдэв бүрд тохирсон оролцооны арга зүйн аргачлалыг тусгасан болно. Чанарын буюу ярилцлагын судалгаанд хамрагдах түүврийн хэмжээг доорх хүснэгтэд харууллаа. Үүнд:

Хүснэгт 12. Чанарын (ярилцлага) судалгаанд хамрагдах түүврийг тооцсон байдал

№	Төлөөлөх газар	Төлөөлөх сум, дүүрэг	Ярилцлага
1	Говь-Алтай (баруун бүс)	Шарга сум	3
		Бугат	3
		Есөнбулаг сум	3
		Аймгийн төв	2
2	Булган (хангайн бүс)	Баян-Агт сум	3
		Бүрэгхангай	3
		Булган сум	3
		Аймгийн төв	2
3	Төв (төвийн бүс)	Лүн сум	3
		Алтанбулаг сум	3
		Зуунмод сум	3
		Аймгийн төв	2
4	Сүхбаатар (Зүүн бүс)	Уулбаян сум	3
		Мөнххаан сум	3
		Баруун-Урт сум	3
		Аймгийн төв	2
5	Улаанбаатар хот (нийслэл)	Хан-Уул дүүрэг ИТХ	2
		Баянзүрх дүүрэг ИТХ	2
		Багануур дүүрэг ИТХ	2
		Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3
6	УИХ-ын Тамгын газар		6
7	ТББ-ын тэтгэлэг		5
Нийт			59

Чанарын судалгааны мэдээллийг кодлох, компьютерт шивж оруулах, ярилцлагын протоколыг баримтжуулах аргаар боловсруулж үр дүнг энэхүү тайлангийн холбогдох хэсгүүдэд тусгасан болно.

Ярилцлагын судалгаанд 59 оролцогч хамрагдсан бөгөөд судалгааны үнэн зөв байдлыг хангахын тулд тэдний санал, бодол, байр суурийг энэхүү тайланд тусгахдаа аливаа оролцогчийн нэрийг бичихгүй байх нөхцөлийг урьдчилан тохиролцсон болно.

4.2 СУДАЛГААНД АШИГЛАСАН АНКЕТЫН АСУУЛГЫН ЗАГВАР

“МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН СУРГАЛТ, ЧАДАВХЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Энэхүү анкетын судалгааг УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд зохион

байгуулсан **сургалт, чадаажуулах үйл ажиллагаа болон тэтгэлэгт хөтөлбөрийн** үр нөлөөг үнэлэх зорилгоор “Түгээмэл эрх-Хөгжил” ТББ-аас авч байна.

Таны бичсэн, бөглөсөн аливаа санал, шүүмжлэл болон хувийн мэдээллийг тусгайлан хэн нэгэн хувь хүнд эсвэл байгууллагад дамжуулан өгөхгүй бөгөөд эдгээр мэдээллийг зөвхөн бусад оролцогчийн өгсөн мэдээлэлтэй хамт нэгтгэн дүгнэхэд ашиглана. Мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах болно.

Судлаачийн нэр: _____

Судлаачийн код: [] []

Судалгаа хийсэн огноо: он ____ сар ____ өдөр ____

____ цаг ____ минут

Судалгаа хийсэн газар [.....]	Судалгааны талбарын код: [] []
--	-------------------------------------

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Энэ судалгааг бөглөхдөө та нэрээ бичих шаардлагагүй!!!

1	Та хэдэн настай вэ?	() бичих
2	Таны хүйс:	1. Эрэгтэй 2. Эмэгтэй
3	Таны боловсролын түвшин ямар вэ?	1. Боловсролгүй 2. Бага (3/4 анги) 3. Суурь (8/9 анги) 4. Бүрэн дунд (10/11/12 анги) 5. Техник болон мэргэжлийн дунд (МСҮТ, Коллеж) 6. Дээд
4	Та аль шатны хурлын төлөөлөгч вэ?	1. Аймаг, нийслэлийн ИТХ 2. Сум, дүүргийн ИТХ 3. Баг, хорооны ИНХ 4. Бусад бичих
5	Та дараах сургалтуудаас өөрийн хамрагдсан сургалтын өмнөх дугаарыг дугуйлна уу	1. Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт 2. ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалт 3. Эмэгтэйчүүдийн манлайллын сургалт 4. Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалт

1. ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ЗОРИУЛСАН СУУРЬ СУРГАЛТ

/Энэ сургалтад хамрагдаагүй бол та дараагийн 2 дахь хэсэгт шууд шилжинэ үү./

1.1 Та ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын талаарх дор дурдсан үзүүлэлтүүдэд тохирох үнэлгээг **өөрийн үнэлэмжээр** дугуйлна уу.

№	Сургалтын үзүүлэлтүүд	Маш сайн Сайн Дунд Муу Маш муу					
1	Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг үнэлнэ үү	5	4	3	2	1	Мэдэхгүй
2	Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдал	5	4	3	2	1	Мэдэхгүй
3	Багшийн ур чадвар, заах арга зүйн чадвар	5	4	3	2	1	Мэдэхгүй
4	Сургалтын үргэлжлэх хугацаа тохиромжтой байсан уу?	5	4	3	2	1	Мэдэхгүй
5	Сургалтын гарын авлага, тараах материал ойлгомжтой, хэрэглэх боломжтой байсан уу?	5	4	3	2	1	Мэдэхгүй

1.2 Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтаас **хангалттай мэдлэг, ур чадвар** олж авч чадсан гэж үзэж байна уу?

- А. Маш хангалттай Б. Ер нь хангалттай В. Дундаж
 Г. Ер нь хангалтгүй Д. Хангалтгүй

1.3 Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтаас сурсан **мэдлэг, ур чадвараа** ашиглаж байгаа юу?

- А. Өдөр тутам ашигладаг Б. Ихэвчлэн ашигладаг В. Заримдаа
 Г. Бараг ашигладаггүй Д. Ашигладаггүй

1.4 Та Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад хамрагдсанаар **таны ажлын арга барил** өөрчлөгдсөн үү?

- А. Маш их дээшилсэн Б. Ер нь дээшилсэн В. Зарим талаар дээшилсэн
 Г. Бараг дээшлээгүй Д. Нөлөөлөөгүй

1.5 Сургалтын үр дүнд таны **мэдлэг, ур чадвар хэрхэн дээшилснийг** доорх байдлаар үнэлнэ үү.

№	Мэдлэг, ур чадварууд	Маш сайн, Сайн, Дунд, Муу, Маш муу					
1	ИТХ-ын хуралдаанд илүү идэвхтэй оролцдог болсон	5	4	3	2	1	
2	Хууль тогтоомжийн талаарх мэдлэг, хэрэглэх чадвар сайжирсан	5	4	3	2	1	
3	Орон нутгийн төсвийн төлөвлөлт, хяналтад оролцох мэдлэг, оролцоо дээшилсэн	5	4	3	2	1	
4	Байгаль хамгаалал, газрын харилцааны гэх мэт асуудлыг илүү анхаардаг болсон	5	4	3	2	1	
5	Иргэдтэйгээ ажиллах санаачилга, чадвар нэмэгдсэн	5	4	3	2	1	

1.6 Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтад танай хурлын төлөөлөгчид хамрагдсанаар танай **байгууллагын ажилд** өөрчлөлт гарсан уу?

А. Маш их сайжирсан
сайжирсан

Б. Ер нь сайжирсан

В. Зарим талаар

Г. Бараг сайжраагүй

Д. Нөлөөлөөгүй

- 1.7 Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын үр дүнд бий болсон **хамгийн эерэг болон хамгийн сөрөг туршлагыг** мэдсэн, сонссон бол энэ талаар **мөн** сургалтыг цаашид илүү сайжруулах талаар өөрийн **үзэл бодол, саналаа** бичнэ үү.

ЭЕРЭГ.....
.....

СӨРӨГ.....
..

САНАЛ.....
.....

2. ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН “ТӨЛӨӨЛӨГЧИЙН МАНЛАЙЛАЛ” СУРГАЛТ

/Энэ сургалтад хамрагдаагүй бол та дараагийн 3 дахь хэсэгт шууд шилжинэ үү./

- 2.1 Та ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын талаарх дор дурдсан үзүүлэлтүүдэд тохирох үнэлгээг **өөрийн үнэлэмжээр** дугуйлна уу.

№	Сургалтын үзүүлэлтүүд	Маш сайн, Сайн, Дунд, Муу, Маш муу					
1	Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг үнэлнэ үү	5	4	3	2	1	Мэдэхгүй
2	Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдал	5	4	3	2	1	Мэдэхгүй
3	Багшийн ур чадвар, заах арга зүйн чадвар	5	4	3	2	1	Мэдэхгүй
4	Сургалтын үргэлжлэх хугацаа тохиромжтой байсан уу?	5	4	3	2	1	Мэдэхгүй
5	Сургалтын гарын авлага, тараах материал ойлгомжтой, хэрэглэх боломжтой байсан уу?	5	4	3	2	1	Мэдэхгүй

- 2.2 Та ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтаас **хангалттай мэдлэг, ур чадвар** олж авч чадсан гэж үзэж байна уу?

А. Маш хангалттай

Б. Ер нь хангалттай

В. Дундаж

Г. Ер нь хангалтгүй

Д. Хангалтгүй

- 2.3 Та ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтаас **сурсан мэдлэг, чадвараа** ашиглаж байгаа юу?

А. Өдөр тутам

Б. Ихэвчлэн ашигладаг

В. Заримдаа ашигладаг

Г. Бараг ашигладаггүй

Д. Ашигладаггүй

2.4 ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар таны **ажлын арга барил** өөрчлөгдсөн үү?

- А. Маш их дээшилсэн Б. Ер нь дээшилсэн В. Зарим талаар дээшилсэн
Г. Бараг дээшлээгүй Д. Нөлөөлөөгүй

2.5 ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр дүнд таны **мэдлэг, ур чадвар** хэрхэн дээшилснийг дараах байдлаар үнэлнэ үү.

№	Сургалтын үзүүлэлтүүд	Маш сайн, Сайн, Дунд, Муу, Маш муу				
1	Төлөөлөгчийн үүргээ гүйцэтгэхдээ манлайллын арга барилуудыг ашиглах чадвар дээшилсэн	5	4	3	2	1
2	Иргэдийн амьдралд хэрэгтэй байгаа өөрчлөлтийг олж харах чадвар дээшилсэн	5	4	3	2	1
3	Өөрийнхөө үзэл бодол, байр суурийг бусдад ойлгуулах чадвар дээшилсэн	5	4	3	2	1
4	Өөрчлөлтийг бий болгохын төлөө бусдад нөлөөлөх, тууштай ажиллах чадвар дээшилсэн	5	4	3	2	1

2.6 ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтад хамрагдсанаар танай **байгууллагын ажилд** өөрчлөлт гарсан уу?

- А. Маш их нөлөөлсөн Б. Ер нь нөлөөлсөн В. Зарим талаар нөлөөлсөн
Г. Бараг нөлөөлөөгүй Д. Нөлөөлөөгүй

2.7 ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр дүнд бий болсон **хамгийн эерэг болон хамгийн сөрөг туршлагыг** мэдсэн, сонссон бол энэ талаар **мөн** сургалтыг цаашид илүү сайжруулах талаар өөрийн үзэл бодол, **саналаа** бичнэ үү.

ЭЕРЭГ.....
.....

СӨРӨГ
.....
..

САНАЛ.....
.....

3. ЭМЭГТЭЙ ТӨЛӨӨЛӨГЧДӨД ЗОРИУЛСАН МАНЛАЙЛЛЫН СУРГАЛТ

/Энэ сургалтад хамрагдаагүй бол та дараагийн 4 дэх хэсэгт шууд шилжинэ үү./

3.1 Та эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын талаарх дор дурдсан үзүүлэлтүүдэд тохирох үнэлгээг **өөрийн үнэлэмжээр** дугуйлна уу.

№	Сургалтын үзүүлэлтүүд	Маш сайн, Сайн, Дунд, Муу, Маш муу					
1	Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг үнэлнэ үү	5	4	3	2	1	Мэдэхгүй
2	Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдал	5	4	3	2	1	Мэдэхгүй
3	Багшийн ур чадвар, заах арга зүйн чадвар	5	4	3	2	1	Мэдэхгүй
4	Сургалтын үргэлжлэх хугацаа тохиромжтой байсан уу?	5	4	3	2	1	Мэдэхгүй
5	Сургалтын гарын авлага, тараах материал ойлгомжтой, хэрэглэх боломжтой байсан үү?	5	4	3	2	1	Мэдэхгүй

3.2 Та Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтаас хангалттай мэдлэг, ур чадвар олж авч чадсан гэж үзэж байна уу?

- А.** Маш хангалттай **Б.** Ер нь хангалттай **В.** Дундаж
Г. Ер нь хангалтгүй **Д.** Хангалтгүй

3.3 Та Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтаас олж авсан мэдлэг, чадвараа ашиглаж байгаа юу?

- А.** Өдөр тутам **Б.** Ихэвчлэн ашигладаг **В.** Заримдаа ашигладаг
Г. Бараг ашигладаггүй **Д.** Ашигладаггүй

3.4 Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтад хамрагдсанаар таны ажлын арга барил өөрчлөгдсөн үү?

- А.** Маш их сайжирсан **Б.** Ер нь сайжирсан **В.** Зарим талаар сайжирсан
Г. Бараг сайжраагүй **Д.** Нөлөөлөөгүй

3.5 Сургалтын үр дүнд таны мэдлэг, чадвар хэрхэн өөрчлөгдсөнийг доорх байдлаар үнэлнэ үү

№	Сургалтын үзүүлэлтүүд	Маш сайн, Сайн, Дунд, Муу, Маш муу				
1	Эмэгтэй төлөөлөгчид тойргийн сонгогчидтойгоо илүү ойр ажиллах	5	4	3	2	1
2	Эмэгтэйчүүдийн оролцооны чиглэлийн хууль тогтоомжийг үр дүнтэй ашиглах	5	4	3	2	1
3	Орон нутагт тулгамдсан асуудлыг жендэрийн мэдрэмжтэйгээр тодорхойлох, шийдвэрлүүлэх	5	4	3	2	1
4	Эмэгтэй төлөөлөгчид бие биенээ дэмжиж хамтран ажиллах	5	4	3	2	1

3.6 Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтад танай хурлын төлөөлөгчид хамрагдсанаар танай байгууллагын ажилд өөрчлөлт гарсан уу?

- А. Маш их сайжирсан Б. Ер нь сайжирсан В. Зарим талаар сайжирсан
Г. Бараг сайжраагүй Д. Нөлөөлөөгүй

3.7 Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтын үр дүнд бий болсон **хамгийн эерэг болон хамгийн сөрөг туршлагыг** мэдсэн, сонссон бол энэ талаар **мөн** сургалтыг цаашид илүү сайжруулах талаар өөрийн үзэл бодол, **саналаа** бичнэ үү.

ЭЕРЭГ.....

СӨРӨГ.....

САНАЛ.....

4. БАГИЙН ИНХ-ЫН ДАРГА НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ

/Энэ сургалтад хамрагдаагүй бол та дараагийн 5 дахь хэсэгт шууд шилжинэ үү./

4.1 Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын талаарх дор дурдсан үзүүлэлтүүдэд тохирох үнэлгээг **өөрийн үнэлэмжээр** дугуйлна уу.

№	Сургалтын үзүүлэлтүүд	Маш сайн, Сайн, Дунд, Муу, Маш муу					
1	Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанарыг үнэлнэ үү	5	4	3	2	1	Мэдэхгүй
2	Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдал	5	4	3	2	1	Мэдэхгүй
3	Багшийн ур чадвар, заах арга зүйн чадвар	5	4	3	2	1	Мэдэхгүй
4	Сургалтын үргэлжлэх хугацаа тохиромжтой байсан уу?	5	4	3	2	1	Мэдэхгүй
5	Сургалтын гарын авлага, тараах материал ойлгомжтой, хэрэглэх боломжтой байсан уу?	5	4	3	2	1	Мэдэхгүй

4.2 Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтаас хангалттай **мэдлэг, чадвар** олж авч чадсан гэж үзэж байна уу?

- А. Маш хангалттай Б. Ер нь хангалттай В. Дундаж
Г. Ер нь хангалтгүй Д. Хангалтгүй

4.3 Та Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтаас сурсан мэдлэгээ ашиглаж байгаа юу?

- А. Өдөр тутам Б. Ихэвчлэн ашигладаг В. Заримдаа ашигладаг
Г. Бараг ашигладаггүй Д. Ашигладаггүй

4.4 Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсанаар **таны ажлын арга барил** өөрчлөгдсөн үү?

А. Маш их дээшилсэн
дээшилсэн

Б. Ер нь дээшилсэн

В. Зарим талаар

Г. Бараг дээшлээгүй

Д. Нөлөөлөөгүй

4.5 Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтад хамрагдсанаар танай байгууллагын ажилд өөрчлөлт гарсан уу?

А. Маш их дээшилсэн
дээшилсэн

Б. Ер нь дээшилсэн

В. Зарим талаар

Г. Бараг дээшлээгүй

Д. Нөлөөлөөгүй

4.6 Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын үр дүнд бий болсон **хамгийн зэрэг болон хамгийн сөрөг туршлагыг** мэдсэн, сонссон бол энэ талаар **мөн** сургалтыг цаашид илүү сайжруулах талаар өөрийн үзэл бодол, **саналаа** бичнэ үү.

ЭЕРЭГ.....

СӨРӨГ.....

САНАЛ.....

5. ТЭТГЭЛЭГТ ХАМРАГДСАН БАЙДАЛ

5.1 Танай Иргэдийн төлөөлөгчдийн хурал Төслийн “Шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” тэтгэлэгт хамрагдсан уу?

А. Тийм

Б. Үгүй (энэ хариултыг сонгосон бол 2 дахь хэсэгт шууд шилжинэ үү)

5.2 Танай Иргэдийн төлөөлөгчдийн хурал тэтгэлэгт хамрагдсанаар гарсан үр дүнг доорх үзүүлэлтүүдээр үнэлнэ үү.

№	Тэтгэлгийн үзүүлэлтүүд	Маш сайн, Сайн, Дунд, Муу, Маш муу					
1	Танай ИТХ-ын хэрэгжүүлсэн тэтгэлэг зорилгодоо хүрч чадсан уу?	5	4	3	2	1	Мэдэхгүй
2	Тэтгэлгийн үр дүнд танай ИТХ иргэдийг татан оролцуулах тал дээр өөрчлөлт гарсан уу?	5	4	3	2	1	Мэдэхгүй
3	Тэтгэлгийн үр дүнд танай ИТХ-ын хяналт тавих чадавхид өөрчлөлт гарсан уу?	5	4	3	2	1	Мэдэхгүй

БАЯРЛАЛАА, ТАНД АЖЛЫН АМЖИЛТ ХҮСЬЕ!

4.3 СУДАЛГААНД АШИГЛАСАН ЯРИЛЦЛАГЫН СУДАЛГААНЫ ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД

ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТ

Судалгааны зорилго

Энэхүү анкетын судалгааг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлсэн зарим үйл ажиллагааны үр дүнг үнэлэх зорилгоор “Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт”, “ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалт”, “Эмэгтэйчүүдийн манлайллын сургалт” болон “Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалт”-д хамрагдсан оролцогчдын санал, бодлыг тодруулах зорилгоор “Түгээмэл эрх-Хөгжил” ТББ-аас авч байна.

Судалгааг явуулах заавар:

Таны бичсэн, бөглөсөн аливаа санал, шүүмжлэл болон хувийн мэдээллийг тусгайлан хэн нэгэн хувь хүнд эсвэл байгууллагад дамжуулан өгөхгүй бөгөөд эдгээр мэдээллийг зөвхөн бусад оролцогчийн өгсөн мэдээлэлтэй хамт нэгтгэн дүгнэхэд ашиглаж, мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах болно.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Хаана амьдардаг,
2. Нас, хүйс,
3. Эрхэлдэг ажил
4. Үнэлгээнд хамрагдах аль сургалтад суусан болох
5. Эдгээртэй ижил сургалтад өмнө нь хамрагдаж байсан эсэх

Тэтгэлгийн тухай асуулт

Тэтгэлэг авсан бол

1. Тэтгэлгийн зорилгын оновчтой байдал – Оролцсон, идэвх,
 - а. Одоо бодоход ямар байж вэ?
2. Тэтгэлэг зорилтод бүлэгтээ хүрсэн байдал – Яаж хүрэв. Хүрсэн гэдгийг юугаар хэмжих вэ?
3. Тэтгэлэгт хамрагдсанаар иргэдийн оролцоо дээшилсэн байдал -
4. Тэтгэлэгт хамрагдсанаар иргэдийн хяналт дээшилсэн байдал -
5. Яг ямар арга хэмжээг хэрэгжүүлсэн бэ?
6. Арга хэмжээ бүрээс гарсан үр дүн?

Аваагүй бол

Тэтгэлэг авсан ИТХ-ын талаар мэдэх үү? Сэтгэгдлээ хэлнэ үү? Мэдээлэл хуваалцана уу?

Хамрагдсан сургалт тус бүрийн хувьд доорх асуултуудыг асууна.

1. Сургалтын ерөнхий зохион байгуулалтын чанар

Цагтаа эхэлсэн

Цай, кофены завсарлага

Оролцогчдын тоо буюу дүүргэлт

Техник хангамжийн байдал, чанар – микрофон, тог

Оролцогчдын идэвх

2. Сэдвийн ач холбогдол, ажилд хэрэгжих боломжтой байдал

Аль сэдэв хамгийн сонирхолтой, хэрэгтэй байсан бэ?

Хамгийн ач холбогдолгүй сэдэв ямар сэдэв байсан бэ?

Амьдралд хэрэгжих боломж хэр байсан бэ?

3. Багшийн ур чадвар, заах арга зүйн чанар

Багшийн мэдлэг

Заах арга барил

Оролцооны арга хэрэглэсэн эсэх

4. Сургалт зохион байгуулсан цаг, хугацааны тохиромжтой байдал

Хугацааны хувь их урт эсвэл хэт богино байсан эсэх

Оролцогчдын оролцох боломжтой цаг үеийг зөв сонгож хийж чадсан эсэх?

5. Сургалт зохион байгуулсан байр, тэнхимийн тав тухтай байдал

Агааржуулалт

Дулаан

Ариун цэвэр байдал

Суудал болон ширээний хүрэлцээ

Тав тухтай холбоотой бусад асуудал

6. Та сургалтаас сурсан мэдлэгээ байнга ашиглаж байгаа юу?

Тийм бол яг ямар төрлийн мэдлэгийг ямар зорилгоор

Үгүй бол ямар шалтгаантай байсан бэ?

7. Сургалтад хамрагдсанаар таны ажлын чанар дээшилсэн үү?

Тийм бол ямар асуудлаар дээшилсэн бэ?

8. сургалтад танай хурлын төлөөлөгчид хамрагдсанаар танай байгууллагын ажлын чанар дээшилсэн үү?

9. сургалтын үр дүнд бий болсон хамгийн эерэг болон хамгийн сөрөг туршлагыг мэдсэн, сонссон бол энэ талаар мөн сургалтыг цаашид илүү сайжруулах талаар өөрийн үзэл бодол, саналаа бичнэ үү

4.4 УИХТГ-ЫН АЛБАН ХААГЧДААС АВСАН ЯРИЛЦЛАГЫН ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД БОЛОН АНКЕТЫН СУДАЛГААНЫ ЗАГВАР

**“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд
хэвлүүлсэн ном, гарын авлагын үр нөлөөг дүгнэх
ярилцлагын судалгааны чиглүүлэх асуулт**

“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хэвлүүлсэн ном, гарын авлага зэрэг мэдлэгийн бүтээгдэхүүнийг зорилтот хэрэглэгчид хэрхэн, хэр үр дүнтэй ашиглаж байгааг тодруулах зорилгоор энэхүү ярилцлагын судалгааг Төслийн захиалгаар зохион байгуулж байна.

**I. МЭДЛЭГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР ХАНГАХ БОЛОН ГАДААДАД ТҮРШЛАГА СУДЛАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨ**

I.1 Мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах, гадаадад туршлага судлах үйл ажиллагааны талаар

1. Та Төслийн санхүүжилтээр аль улс руу туршлага судлахаар явсан бэ? Явсан газраасаа юу сурч ирсэн бэ? Түүнийгээ өөрийн ажилд хэрхэн ашигласан бэ?
2. Та Төслийн хүрээнд түгээсэн ямар гарын авлага, номыг хүлээн авсан бэ?
3. Авсан гарын авлага, ном, зөвлөмж зэргээсээ юуг сурч, мэдсэн бэ? Тэдгээрийг өөрийн ажилдаа хэрхэн ашигласан бэ?
4. Гадаадад туршлага судалсан, мэдлэгийн бүтээгдэхүүн хүлээн авсан бусад хүмүүс ямар үр дүнтэй ашигласан талаар мэдээлэл байгаа юу?

Тийшээ явж ирээд, тийм юмыг нь сурч, мэдэж аваад ийм юманд хувь нэмэр оруулсан гэсэн үр дүн байвал сайн. Мөн энэ ажил нь бусад ямар сайн үр дүнд хүрэхэд тус, нэмэр болсон талаар хариултыг олж мэдэхийг хичээнэ.

I.2 “Хууль зүйн техник” (Т.В.Кашанина, 2016) номын ашиглалтын талаар

1. Хууль зүйн техник гэдэг номыг мэдэх үү? Тухайн номонд танд чухал шаардлагатай ямар сэдвүүд байсан бэ? Та санаж байгаа сэдвээ, ашигласан туршлагаа хуваалцана уу.
2. Ийнхүү ном, гарын авлага зэрэг мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах нь УИХТГ болон гишүүдийн ажлын үр дүнд нөлөөлж чадаж байна уу?
3. Өөр шаардлагатай ном, гарын авлага байгаа юу? Ямар сэдэвтэй, юуны тухай ном, гарын авлагыг олж авах, орчуулуулах, хэрэглэх шаардлага гарч байна вэ?

I.3 Мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах Төслийн үйл ажиллагаа нь УИХТГ болон УИХ-ын гишүүдийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн гэж үзэж байгаа вэ?

I.4 Төслийн дэмжлэгийн үр дүнтэй холбоотой Нийтийн сонсгол зохион байгуулсан туршлагаас мэдэх зүйл байна уу?

Та өөрөө зохион байгуулсан, байгуулахад оролцсон уу? Тийм бол ямар үр дүн гарсан, иргэдийн амьдралд яаж нөлөөлсөн, ямар боломжийг бий болгосон гэж үзэж байна вэ?

II. “МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ, ОРОЛЦОО

II.1 Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын талаар явуулж байгаа ажлуудыг хэр сайн мэдэж байгаа вэ?

1. Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан аль үйл ажиллагаа илүү үр дүнтэй болсон гэж үзэж байна вэ? Сургалтууд болон тэтгэлэг хэрэв боломжтой бол бусад үйл ажиллагааны талаар мэдэх зүйлээ хэлж өгнө үү. Үүнд:
 - a. Төлөөллийн байгууллагын эрх зүйн зохицуулалт хэрхэн өөрчлөгдсөн бэ?
 - b. Төлөөллийн байгууллагын үйл ажиллагаа хэрхэн сайжирсан бэ?
 - c. ИТХ-ын төлөөлөгчдийн үр чадвар, мэдлэг, мэдээлэлд өөрчлөгдсөн зүйл байдаг уу? Мэдэгддэг үү?
2. Төслийн оролцоогүйгээр нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой сургалтыг зохион байгуулах боломжтой гэж бодож байна уу? Хэрэв тийм бол эдийн засгийн болон зохион байгуулалтын ямар боломжууд байна вэ? Энэ ажлыг хэн хариуцан гүйцэтгэх нь зүйтэй гэж бодож байна вэ?
3. Төслийн дэмжлэг, туслалцааг ерөнхийд нь юу гэж дүгнэж байна вэ? Тэдний дэмжлэгийн зорилго, зохион байгуулалт хэр оновчтой байсан бэ? Засаж залруулах, өөрчлөх шаардлагатай асуудал байна уу? Тийм бол тоочин тодорхой хэлж өгнө үү.

**“МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД
ХҮРГҮҮЛСЭН НОМ, ГАРЫН АВЛАГЫН АШИГЛАЛТ, ҮР НӨЛӨӨНИЙ ТАЛААРХ СУДАЛГАА**

1. Та өөрийн ажилдаа дор дурдсан ном, гарын авлага зэрэг материалыг ашиглаж байгаа байдлыг хүснэгтэд заасан (1-5 болон 99) үнэлгээний дагуу үнэлнэ үү.

Ашиглаж байгаа байдал

	Ном, гарын авлага, тараах материалын нэр	Байнга	Ихэнхдээ	Заримдаа	Ер нь үгүй	Огт үгүй	Мэдэхгүй
1	Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ /2016/, (дахин хэвлэсэн)	5	4	3	2	1	99
2	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ	5	4	3	2	1	99
3	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” тайлан	5	4	3	2	1	99
4	“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” зөвлөмж	5	4	3	2	1	99
5	Хууль тогтоомжийн төсөл боловсруулагчийн ширээний ном: практик гарын авлага	5	4	3	2	1	99
6	Бүгд Найрамдах Финланд Улсын Үндсэн хууль	5	4	3	2	1	99
7	Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль	5	4	3	2	1	99
8	Австрали Улсын Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг	5	4	3	2	1	99
9	Бүгд Найрамдах Франц Улсын Үндэсний Ассамблейн хуралдааны дэг	5	4	3	2	1	99
10	Бүгд Найрамдах Финланд Улсын парламентын хуралдааны дэг	5	4	3	2	1	99
11	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн хуралдааны дэг	5	4	3	2	1	99
12	Оросын Холбооны Улсын Төрийн Думын регламент	5	4	3	2	1	99
13	Канад Улсын парламентын акт	5	4	3	2	1	99
14	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн үйл явцыг шалгах хуудас	5	4	3	2	1	99

2. “Хууль зүйн техник” (Т.В.Кашанина, 2016) номын чанар, үр нөлөөг доорх хүснэгтэд заасны дагуу үнэлнэ үү.

		Сайн	Ер нь сайн	Дунд	Ер нь муу	Муу
1	“Хууль зүйн техник” номыг үндсэн ажилдаа ашиглах боломжтой байдал	5	4	3	2	1
2	“Хууль зүйн техник” номын уншиж ашиглахад гарах бэрхшээлгүй байдал (хэвлэлийн чанар, үсгийн хэмжээ тохиромжтой байдал зэрэг)	5	4	3	2	1
3	“Хууль зүйн техник” номын орчуулгын чанар (үг, үсгийн болон найруулгын алдаагүй байдал зэрэг)	5	4	3	2	1
4	“Хууль зүйн техник” номын хүрэлцээ	5	4	3	2	1